Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын бизнесийн зөвлөлийн
ШИЛДЭГ ХЭВЛЭЛ
"Mongolian Economy" сэтгүүл

Монголын эдийн засаг, санхүү, бизнесийн сэтгүүл 2012. 12 сар. №23 (033) www.mongolianeconomy.mn



Шог зургийг А.Амарсайхан

NISSAN PATROL.
WELCOME TO OFF-ROAD EXCLUSIVITY

Хэдэн арван жилийн турш Ниссан Патрол нь засмал болон хамгийн хүнд хэцүү бартаат замыг туулах чадвараараа олон арван домог мэт түүхийн эзэн болж бүх замыг туулагч шилдэг автомашинаар шалгарсан байна.
Шинэчлэгдэн хүчирхэгжсэн 5.6 литрийн хөдөлгүүр болон гайхалтай нарийн хийгдсэн тансаг байдал, уламжлалт хэв шинж, дэвшилтэт технологиуд, төгс туулах чадвар, тав тух зэрэг нь Ниссан Патролыг бүх замын хаан болгосон юм.

NISSAN

SHIFT_

NISSAN
PATROL

www.patrol.mn



- 317-hp 5.6L V8 engine with C-VTC • Intelligent 4WD package
- ALL MODE 4x4 system • Hill Start Assist and Hill Descent Control
- Brake Limited Slip • Multi-screen DVD Entertainment System
- 2-GB Music Box hard drive • Class-leading air conditioning system
- Climate-controlled front seats • Rear View Monitor & Around View Monitor
- Intelligent Key and Push Button Ignition

MONNIS
МОННИС МОТОРС

www.monnis.com, 99110014, 99102272

ГОЛОМТ БАНК

Сайн сайхныг санхүүжүүлнэ

МОНГОЛ УЛСЫН ШИЛДЭГ БАНК

хэмээх нэр хүндтэй шагналд хөтөлсөн харилцагчдынхаа итгэлд талархал илэрхийлье.



The Banker

СЭТГҮҮЛЭЭС 2012 ОНЫ ДЭЛХИЙН ШИЛДЭГ БАНКУУДЫГ НЭРЛЭЛЭЭ.

Энэхүү шагналыг хүртэхэд Голомт банкны зах зээлд тэргүүлэгч байр суурь, эрчимтэй өсөлттэй санхүүгийн хүчирхэг үзүүлэлтүүд, үйл ажиллагааны үр дүн, бизнесийн болон бүтээгдэхүүн үйлчилгээний тогтвортой өсөлт чухал нөлөө үзүүлжээ.

Монголын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт-Цэвэр нүүрсний Азийн дээд хэмжээний уулзалт-2012

2012 оны 12 дугаар сарын 10-12-нд ШАНХАЙ хотноо

Хөрөнгө оруулалтын чуулга уулзалт-2012

* Монгол дахь олон улсын хөрөнгө оруулалтын боломжууд (уул уурхай, үл хөдлөх...)
* Монголын байгалийн баялгийн нөөц
* Монголын экспортын хамгийн том түнш Хятадын эдийн засгийн төлөв
* Монголын уул уурхайн салбар дахь Хятад улсын нөлөө

Цэвэр нүүрсний Азийн дээд хэмжээний уулзалт-2012

* Сүүлийн үеийн нүүрс хийжүүлэх, CTL, IGCC&CCS технологийн хөгжлийн үнэлгээ
* CCS-ийн хамгийн сүүлийн үеийн технологийн дэвшлүүд
* Цэвэр нүүрсний салбарын тэргүүлэгчидтэй уулзах боломж

Дэлгэрэнгүй мэдээллийг:

Утас: +21 3175 0649
Факс : +86 21 3175 0647
И-мэйл : info@inbcglobal.com
Вэб: http://www.mongoliainvestmentcongress.org





НҮҮРСНИЙ САЛБАРТ ХӨРӨНГӨ ОРУУЛАГЧДЫН 3 ДАХЬ УДААГИЙН ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ, ҮЗЭСГЭЛЭН

Хуралд **нэгдүгээр** сарын **15**-наас өмнө бүртгүүлбэл **20%**, Үзэсгэлэнд **орванхоёрдугаар** сарын **15**-наас өмнө бүртгүүлбэл **5%** хөнгөлөлттэй

COAL MONGOLIA 2013

2013 оны 2 сарын 21-22

МОНГОЛ УЛС, УЛААНБААТАР ХОТ, SS CONVENTION CENTER

ОЛОН УЛСЫН ЧУУЛГА УУЛЗАЛТ

Чуулга уулзалт, үзэсгэлэн нь Монгол Улсад хэрэгжүүлж буй нүүрсний хайгуул, олборлолт, боловсруулалтын төслүүдэд хөрөнгө оруулалт татах, нүүрсний салбарт төрөөс баримтлах бодлогыг танилцуулах, байгаль орчинд ээлтэй, шинэ дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх, олон улсын харилцан үр ашигтай хамтын ажиллагааг хөгжүүлж Монгол Улсын нүүрсний салбарын өрсөлдөх чадварыг нэмэгдүүлэх үндсэн зорилготой.

ОЛОН УЛСЫН ҮЗЭСГЭЛЭН

"COAL MONGOLIA-2013" чуулга, уулзалт үзэсгэлэнд дэлхийн нэртэй уул уурхайн салбарын тэргүүлэгч компаниуд өөрсдийн үйл ажиллагаагаа танилцуулдаг билээ. Энэ удаагийн үзэсгэлэнд гадаад, дотоодын 62 томоохон компаниуд үзэсгэлэн гаргана.

УУРХАЙТАЙ ТАНИЛЦАХ АЯЛАЛ

"COAL MONGOLIA-2013" чуулга уулзалт, үзэсгэлэнгийн хүрээнд 2013 оны 2 дугаар сарын 23-ний өдөр "Mongolian Mining Corporation"-ы Ухаа Худаг, "Эрдэнэс-Тавантолгой" ХК-ийн нүүрсний уурхайтай танилцах аяллыг зохион байгуулах гэж байна. Нэг удаагийн аяллаар монголын хамгийн том хоёр уурхайтай танилцах боломжтой.

БҮРТГЭЛ ЯВАГДАЖ БАЙНА

Platinum sponsor: MONGOLIAN MINING CORPORATION

Diamond sponsor: HUNNU COAL

Gold sponsor: ЭРДЭНЭС ТАВАН ТОЛГОЙ ERDENES-TT, GEMCOM, XacBank Right Bank, GLOGEX Geology & Mining Consulting Services, ASPIRE MINING LTD, TERRA ENERGY

Bank of the event: TDB TRADE & DEVELOPMENT BANK

Event sponsor: KHAN BANK YOUR TRUSTED FRIEND, WAGNER ASIA EQUIPMENT LLC CAT, MONNIS, UP MINES, carhartt Exclusive distributor, TRANSWEST MONGOLIA LLC, MobiNet leading internet technology

Supporting organizations: THE BUSINESS COUNCIL OF MONGOLIA, Mongolian Mining Club, ZAZA CORPORATE COUNSEL LLC, NAMBC

International media partners: Bloomberg TV MONGOLIA, InfoMine, ASIA Miner, РАЦИОНАЛЬНОЕ ОСВОЕНИЕ НЕДР, COAL spot.com, WORLD COAL, Mining Journal, commodity, MINING LEADERS, globalCOAL, BULKINSIDE

Local media partners: MONGOLIAN ECONOMY, MONTSAME, Mongolia TODAY, iRMUUN, MINING, ӨГЛӨӨНИЙ СОНИН, УУЛ УУРХАЙН МЭДЭЭ

Дэлгэрэнгүй мэдээллийг:
www.coalmongolia.mn, +976-70115590

Зохион байгуулагч: МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР УУЛ УУРХАЙН ЯАМ

MINING.MN

Нөгөөн хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:
Д.Бэхбаяр /9999-4248/

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:
И.Отгонжаргал /8800-6228/

ХАРИУЦЛАГАТАЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА
Б.Энхмарт

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР: Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ: Ж.Түмэнбаяр

СЭТГҮҮЛЧИД: Б.Баяртогтох
Б.Энхцэцэг
Э.Зоригт
Б.Уганбаяр
Х.Хулан
Б.Үүрийнтуяа

ДИЗАЙНЕР, ВЭБ МАСТЕР: Ш.Оюундарь

ПРОГРАММИСТ: Н.Түвшинбаяр

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР: Д.Барианжав /8880-0825/
Д.Баттулга /9902-2279/
Б.Энхцэцэг /9901-5476/

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР: С.Цэнд-Аюуш

"ECONOMY" ТВ СТУДИ

ДЭД ЗАХИРАЛ: Ц.Буянбат /8811-2885/

ЗУРАГЛААЧ: Ц.Бат-Отгон

ГРАФИК ДИЗАЙН Г.Буянбаатар

ХАЯГ:
Улаанбаатар, ЧД IV хороо,
Анкарагийн гудамж-23 Тод Тауэр-604 тоот

15160 Улаанбаатар, Төв шуудан, ш/ х-2762
www.mongolianeconomy.mn
info@mongolianeconomy.mn

УТАС/ФАКС: 976 - 7011 5476

БОРЛУУЛАХ ЦЭГҮҮД:

"Интер ном"
"Цэцэг төв"
"Минж плаза"
"Алтантүлхүүр" номын дэлгүүр
"Номин" супермаркетийн бүх салбар
"Макс" супермаркетийн бүх салбар
"Преско" супермаркет
BTSI супермаркет
"Аз орчлон" номын дэлгүүр
"Билэг" их дэлгүүрийн номын тасаг
"Гранд Плаза" дахь супермаркет
"Мир" номын дэлгүүрийн
"Grand plaza"
"Metro mall"
"Sky" супермаркет
"Улаанбаатар" их дэлгүүр дэх салбар
"Max mall" салбарууд

"Улаанбаатар принт" ХХК-д хэвлэв
www.ubprint.mn

MONGOLIAN ECONOMY

ШИНЭ ОНЫ ЗАХИАЛГА ЭХЭЛЛЭЭ

ЗАХИАЛГЫГ:

"Монгол шуудан"
"Түгээмэл шуудан"
"Sky" шуудан
"UB Post" шуудангийн салбарууд болон сэтгүүлийн редакцид авч байна.

УТАС: 7011-5476
8880-0825
9905-1914

Чингис бондын чин хүсэл юү вэ



...Эндээс явахдаа бондын хүүг 3.5 хувиас хэтрүүлэхгүй, харин ч түүнээс бага байлгах юм ярьж суусан сайд нар эргэж ирээд “Манайх Испаниас сайн нөхцөлтөйгээр бага хүүтэй зарж чадлаа, энэ бол гайхамшиг” хэмээж байна...18

“Бурхан” эмч

...Ажилдаа дуртай, үнэнч, хичээнгүй сэтгэл зүтгэл маань эцсийн эцэст үхлийн ирмэгт буй өвчтөнийг авардаг юм даа. Тэдэнд амь нас бэлэглэсний дараа л сэтгэлийн таашаал баяр баяслыг авч, мэргэжлээрээ бахархаж, эмч гэдгээ мэдэрдэг... 30



Тэгшитгэ эсвэл...



...Өнгөрсөн онд Эрүүл мэндийн даатгалын сангийн хуримтлалын 84.4 хувийг ажил эрхэлж буй иргэд цалингаасаа төлсөн бол төрөөс дөнгөж 9.4 хувийг өгсөн байгаа юм. Үлдсэн 6.3 хувийг өөрөө хариуцагч хэсэг төвлөрүүлсэн байдаг.....42

Жон Кеннеди алагдаагүйсэн бол

... Освальдыг хоёр хоногийн дараа Далласын мужийн шоронд хүргэхээр машинд суулгах зуурт Жек Руби гэгч буудсанаар Ерөнхийлөгчийн аминд хүрсэн байж болох цорын ганц сэжигтэн газар дээрээ үхсэн байна...46



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

10 Иргэд мэтгэлцээнээс ямар сэтгэгдэлтэй Үлдсэн бэ?

ЭДИЙН ЗАСАГ

14 Нийт нэг зүйлийн төлөө
15 Хөрөнгийн зах зээл хөрөх болоогүй
18 Чингис бондын чин хүсэл юү вэ
20 Ц.Элбэгдорж: Улсынхаа нэрээр авч буй өр
22 Баялгаас хараат байх нь эдийн засаг, нийгмийн хөгжилд халтай

ЭРҮҮЛ МЭНД

26 Амьдрал ба элэгний өвчин
27 Тэнгэр, газар шиг ялгаатай Монгол, Солонгосын эмнэлгүүд
30 “Бурхан” эмч
36 Элэгний өвчин Монгол улсын аюул болчихоод байна
42 Тэгшитгэ эсвэл...

ЕРТӨНЦ

46 Жон Кеннеди алагдаагүйсэн бол

БИЗНЕС

50 М.Болд: Сайн засаглалтай компани итгэлт андтай адил

МОНГОЛ

Хүнсний аюулгүй байдал

УИХ-ын чуулганы нэгдсэн хуралдаанаар Хүнсний аюулгүй байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэлэлцэж, стратегийн хүнсэнд мах, сүү, цагаан будаа, үр тариа, гурилыг оруулжээ. Тэдгээрээс цагаан будаанаас бусдыг дотоодоосоо хангах, мөн импортоор авах барааны тоог цөөлөх зорилт тавьжээ.

Эрчим хүч

Эрчим хүчний зохицуулах хорооноос 2013 он гармагц цахилгаан, дулааны үнийг нэмэхээр төлөвлөж байна. Тус салбарынхан одоогийн байдлаар 44.8 тэрбумын алдагдал хүлээгээд байгаа аж. Дулааны үнэ одоогийнхоос 20 хувиар, өрхийн 150 кв.цагаас илүү гарсан цахилгааны хэрэглээний үнэ 15 хувиар өснө гэсэн тооцоог гаргажээ. Өөрөөр хэлбэл, өрхийн хэрэглэгч 150 кв.цаг хүртэлх цахилгааны хэрэглээндээ одоогийн мөрдөж байгаа тарифаар буюу 79 төгрөг 80 мөнгө төлнө. Харин 150 кв.цагаас илүү гарсан цахилгааны хэрэглээ бүртээ одоогийнхоос 20 хувиар нэмэгдсэн үнэ төлөх юм.

Газар тариалан

Нийт 15 аймгийн 579.3 мянган га газарт хийсэн хөрсний ялзмагийн шинжилгээгээр хөрсний 15.1 хувь нь стандарт буюу гурван хувийн ялзмагтай гарсан байна. Энэ нь тариалангийн хөрсний 77.9 хувь нь дунд, долоон хувь нь цайрсан буюу үржил шимээ алдсан гэсэн үг юм. Түүнчлэн эргэлтийн талбайн хөрсний 40 гаруй хувь нь элэгдэлд орсныг “Атрын III” аяны үндэсний хөтөлбөрийн хүрээнд хийсэн судалгаа харуулжээ.



Гол түүхий эдийн дэлхийн зах зээлийн үнэ


	2012				2013	2014	2015
	I	II	III	IV			
Алт	1689	1613	1655	1770	1800	1652	1470
Зэс	8325	7870	7727	8157	8062	7500	7250
Цайр	2027.7	1928.8	1891.3	2028	2187	2400	2750
Төмрийн хүдэр1	141.8	139.5	111.7	115	137.5	130	115
Нүүрс2	120	101	96	95	100	110	120
Газрын тос/WTI/	103	93	92	94,5	97	101	102

ДНБ-ий өсөлт, улс орнуудаар /хүснэгт/

	2008	2009	2010	2011	2012	2013	2014
АНУ	-0.3	-3.1	2.4	1.8	2.2	2.05	2.6
Европын холбоо	0.4	-4.4	2	1.4	-0.5	0.4	1.3
Япон	-1	-5.5	4.53	-0.78	2.3	1.2	1.2
ОХУ	5.2	-7.8	4.3	4.3	3.75	3.6	3.85
БНХАУ	9.6	9.2	10.4	9.3	7.7	8.1	7.5
Энэтхэг	8.18	6.43	8.88	7.5	5.5	6	6.6
Бразил	5.2	-0.32	7.59	2.76	1.6	4.1	4.1
Дэлхий	1.53	-2.38	3.97	2.88	2.2	2.6	3.05

Эх сурвалж: ЭЗХЯ

Монгол улс: Зээл олголтын хэмжээ /сая ам.доллараар/



Эх сурвалж: Дэлхийн банк

Орон сууц борлуулалтын материалын үнийн өсөлт

	2009.III	2012.III	2012.III 2009.III дундаж
Орон сууцны үнийн индекс	1	1.54	15.48
Орон сууц түрээслэх үнэ /1 өрөө/	226000	385000	19.43
Хөнгөн бетон 700 /м.куб/	83000	153500	22.75
Цемент М-500 / 50 кг/	5800	9075	16.09
Улаан тоосго М-100 /ширхэг/	160	275	19.79

Эх сурвалж: ЭЗХЯ

ОЛОН УЛС

Үнэ ханш



703 сая хэрэглэгчтэй, дэлхийн хамгийн том үүрэн телефоны оператор China Mobile компани Nokia корпорацитай Nokia Lumia 920T ухаалаг гар утас борлуулах гэрээ хийсэн нь Apple корпорацийн Iphone5 утасны Хятад дахь борлуултад сөргөөр нөлөөлж байгаа аж . Үүнээс болж 33 хувиар өсөөд байсан Apple –ын хувьцаа 6.4 хувиар унаж, 538.79 ам.доллар болсон нь тус корпорацийн хувьд 2008 оны арванхоёрдугаар сарын 17-аас хойш үзэж буй анхны алдагдал юм. Харин Nokia корпорацийн хувьцаа 6.1 хувиар өсөөд байна.

Хамтын ажиллагаа

Хятадын Хөгжлийн банк болон Оросын Сбербанкны төлөөлөгчид хоёр орны санхүүгийн хамтын ажиллагааг өргөжүүлэх зорилгоор гэрээнд гарын үсэг зурлаа. Гэрээ таван жилийн хугацаатай бөгөөд Засгийн газрын томоохон төсөл, дэд бүтцийн төсөл, олон улсын гэрээ, хэлцэл болон худалдааны санхүүжилт, халамжийн үйлчилгээ, боловсон хүчний сургалт, туршлага солилцох ба нийт хоёр тэрбум ам.доллар зарцуулах аж.

Ази

Дэлхийн 45 орны иргэд ирэх нэгдүгээр сарын 1-ээс Хятадын Бээжин хотод 72 цагийн хугацаанд визгүй зорчих эрхтэй болох юм. Гуравдагч орны виз болон онгоцны тасалбартай иргэд тус улсын онгоцны буудалд газардмагц бүртгүүлэх ёстой. Тус хотыг жилдээ таван сая гаруй хүн зорьдог байна. Тэгвэл дээрх шийдвэр хэрэгжиж эхэлснээр энэ тоо гурван жилийн дараа хоёр дахин өснө гэж үзэж байна.

Ирэх онд Азийн үл хөдлөх хөрөнгийн зах зээлийг Индонезийн Жакарта хот тэргүүлэх таамаг гарчээ. “PriceWaterhouseCoopers” болон “Urban Land Institute”хамтран “Үл хөдлөх хөрөнгийн зах зээлийн чиг хандлага-Ази Номхон далай 2013” урьдчилсан таамаглалыг энэ долоо хоногт гаргалаа. Тус тооцооллоор арван сая хүн амтай Жакарта хот зах зээлд тэргүүлэх бол Шил даран орж ирэх өрсөлдөгчид нь Хонконг,Сингапур болон Сидней байх гэнэ.


Дэлхийн гурван том үнэлгээний агентлагийн хоёр нь буюу “Moody’s” болон “Fitch” нар Их Британийн гурван А зээлжих зэрэглэлийг бууруулж магадгүй байна. Их Британийн эдийн засгийн өсөлт үлбийж, төсвийн алдагдал ихэсч, сангийн оновчтой бодлого үгүйлэгдсэнээс үүдэн тус улсад энэ жил үнэлгээний байгууллагууд муу дүн тавихаа мэдэгдлээ. Тус улсын арван жилийн хугацаатай бондын жишиг хүү л гэхэд өнөөдөр шалдаа бууж 1.78 болоод байгаа бол паунд мөнгөн тэмдэгтийн ам.доллартай харьцах ханш илт суларчихаад байгаа билээ.

Газрын тос



Канад улс 200 тэрбум баррель газрын тосны нөөцөө далайд гарцгүй Албертагаас зөөвөрлөх хоолой барихаар болсон байна. Учир нь Газрын тосны компаниуд тос дамжуулах хоолой дутагдалтай байгаагаас хугацаа алдаж, орлого түгжигдэж байна хэмээн гомдолложээ. ■

А.АМАРСАЙХАНЫ БУЛАН



ХЭЛЭЛЦҮҮЛЭГ

ИРГЭД МЭТГЭЛЦЭЭНЭЭС ЯМАР СЭТГЭГДЭЛТЭЙ ҮЛДСЭН БЭ?

Б.БАЯРТОГТОХ

УИХ-ын гишүүн С.Ганбаатар УИХ-ын дэд дарга С.Баярцогт нар Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний асуудлаар өнгөрсөн сарын 23-нд МҮОНТ-ээр халз мэтгэлцсэн билээ. Тус мэтгэлцээний талаарх иргэдийн байр суурийг “Mongolian Economy” сэтгүүл сонирхлоо.



Оюутолгой төсөл хэрэгжих учиртай

Д.Рэгдэл /Монгол улсын шинжлэх ухааны академийн тэргүүн дэд ерөнхийлөгч/

-Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний асуудлаар УИХ-ын хоёр гишүүний мэтгэлцээнийг үзсэн. Ард түмэн энэхүү мэтгэлцээнээс Оюутолгойн гэрээ ашигтай, ашиггүйн тухай тодорхой ойлголт авч чадсангүй. Өөрөөр хэлбэл, мэтгэлцээн зорилгоо биелүүлээгүй гэж үзэж байгаа. Эдийн засгийн болон математик загварын талаас нь УИХ-ын гишүүн С.Баярцогт нэлээд ярьсан. Энэ нь мэргэжлийн хүмүүст чухал баримт болсон байх. Түүнээс олон нийтийн хүлээлттэй нийцээгүй. Харин УИХ-ын гишүүн С.Ганбаатар ард түмний сонирхлын асуудлыг барьж ярьсан боловч тодорхой гаргасангүй. Ерөнхийдөө энэ удаагийн мэтгэлцээн ард түмэнд тийм ч сайн мэдээлэл өгч чадаагүй. Оюутолгой төсөл хэрэгжих учиртай. Монгол улсын түүхэнд анх удаа баялгаа ашиглах замыг олон улсын түвшинд тус төсөл нээж өгсөн. Гэтэл газрын хэвлийд буй эрдэс, баялгаа манайх хэдий хэмжээний мөнгөөр үнэлсэн бэ гэдэг анхаарал татаж байгаа. Оюутолгой орд өөрөө ямар үнэ цэнэтэй юм бэ. Энэ асуулт хариулт нэхэж байна.

Ямар ч эрсдэлгүй зүйл ашиг авчирдаггүй

Б.Мөнхзаяа /СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн багш/

-Мэтгэлцээн эхлэх үед УИХ-ын гишүүн С.Баярцогт гэрээ ашигтай, ямар ч эрсдэлгүй гэж тайлбарласан. Ямар ч эрсдэлгүй зүйл ашиг авчирдаггүй. Тиймээс ямар ч эрсдэлгүй зүйл гэж байдаггүй. Тэр тусмаа урт хугацааны төслийн хувьд эрсдэлгүй гэдэг байж болохгүй. Ямар ч эрсдэлгүй бол өгөөж өгөхгүй гэсэн үг. Гэхдээ эрсдэлийг аль талаас нь харж байгаагаас шалтгаална. Гэрээ байгуулаад ▸▸

төсөл хэрэгжих хугацаанд манай улсад ямар эрсдэл үүсэх талаар тодорхой ярихгүй байгаа нь том эрсдэл юм. Эрсдэл гэдэг өөрөө ирээдүйн тодорхой бус байдал гэж тодорхойлогддог. Мөн гэрээний зүйл заалтыг уншаад үзэхээр тодорхойгүй зүйл их байна лээ.

С.Ганбаатар гишүүний хувьд аль болох эрсдэл талаас нь хэлэх гээд байсан. Эрх, үүргийг нь тодорхой зааж өгөөгүй бол тэр өөрөө эрсдэл. Эрсдэлгүй гэрээ гэж бүх талын эрх, үүргийг тодорхой заасан, хэзээ ямар нөхцөл үүсэхэд ямар хугацаанд хэрхэн, яаж, хаашаа хандаж шийдэх нь тодорхой байвал эрсдэлгүй гэж үзэж болох юм. Ганбаатар гишүүний хэлж байсан 14 зүйлийн ганц нь Монголын талыг хамгаалсан байсан гэдэг үнэн.

Гэрээний тал дээр Монголын Засгийн газар хойш сууж хандсан юм болов уу. Түүнээс ашгийн дийлэнх хувийг авлаа гэдэг эрсдэлгүй гэсэн үг биш. Мөн ашиг өөрөө юунаас бүрдэж байна вэ гэдэг нь сонин ойлголт. Монголчуудын хяналт тавих тогтолцоо, хэрэгжүүлэх арга зам, ямар арга хэмжээ авах нь тодорхой бус байгаа нь давхар эрсдэл.

Хэвлэл мэдээллийн салбарт шинэ зүйлийн эхлэл болж чадсан

Ж.Алтангэрэл /МҮОНРТ-ийн сэтгүүлч/

-Мэтгэлцээний хөтлөгчийн хувьд тэнцвэртэй байх зарчим баримталсан. Үзэгчид мэтгэлцээнийг хөндлөнгөөс өөр өөрийнхөөрөө дүгнэж цэгнэж суугаа байх. Асуудлыг хэн нь яаж хөндсөн тухай өөрийн байр сууриа илэрхийлэхэд мэтгэлцэгчид олон асуултад хариулт өгч чадсан болов уу. Бас асуултын тэмдэгтэй, хүлээлт үүсгэсэн асуулт ч цөөнгүй үлдсэн. Миний хувьд С.Баярцогт гишүүнийг эдийн засгийн үндэслэл, тооцоо талаас түлхүү тайлбарлав уу гэж бодсон. Хувь улстөрчийнхөө хувьд магадгүй алдаатай гэдэг ч юм уу, хэт дайрсан, ямар нэг байдлаар илүү, өөрийгөө дээгүүр тавьсан хандлага ажиглагдсан байхыг үгүйсгэхгүй. С.Ганбаатар гишүүнийг нэлээд хүчтэй дуу хоолой гаргаж байр сууриа илэрхийлнэ гэж үзэгчид хүлээж байсан байх. Магадгүй энэ хүлээлтийн хэмжээнд хүрээгүй болов уу. Ерөнхийдөө аядуу, зөөлөн байр сууринаас хандав уу гэж бодсон. Гэхдээ энэ мэтгэлцээн хэвлэл мэдээллийн салбарт шинэ зүйлийн эхлэл болж чадсан байх.



Д.Рэгдэл /Монгол улсын шинжлэх ухааны академийн тэргүүн дэд ерөнхийлөгч/



С.Тогоохүү /Сүхбаатар дүүргийн иргэн/



Б.Мөнхзаяа /СЭЗДС-ийн Санхүүгийн удирдлагын тэнхмийн багш/



Д.Ачит-Эрдэнэ /Монголын олон улсын хөрөнгийн корпорацийн ерөнхийлөгч/



Ж.Алтангэрэл /МҮОНРТ-ийн сэтгүүлч/



Д.Цэнд /Өмнөговь аймгийн Манлай сумын малчин/



Х.Владимир /Эрдэс, баялгийн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал/



Б.Энх-Амгалан /МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор/



О.Баасанхүү /УИХ-ын гишүүн/



О.Болор-Эрдэнэ /Хүмүүнлэгийн ухааны их сургуулийн Эдийн засгийн сургуулийн IV-дамжааны оюутан/

С.Баярцогт Сангийн сайдын үүднээс мэтгэлцэх ёстой байсан

Х.Владимир /Эрдэс, баялгийн үндэсний ассоциацийн гүйцэтгэх захирал/

-Мэтгэлцээний хувьд УИХ-ын гишүүн С.Баярцогт илүү мэдээлэлтэй байсан боловч тухайн мэдээлэл нь урьдчилсан тойм тооцоо төдий байсан. Нарийвчилсан тооцоо байгаагүй. Түүний хувьд Сангийн сайд асан хүн. Мэтгэлцээний үеэр Монгол улсын Сангийн сайдын эрх ашгийг хамгаалж, сайдын үүднээс ярьж, мэтгэлцэх учиртай байсан. Тэгж чадаагүй. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээ Монголд ямар үр ашигтай байх вэ.

Анхны хөрөнгө оруулалт нь хэзээ нөхөгдөх гээд нарийвчилсан тооцоо өнөөдрийг хүртэл гаргаагүй. Мэтгэлцээний үеэр ярьж байсан. Техник эдийн засгийн үнэлгээ /ТЭЗҮ/-г хамгаалсан гэж. Гэтэл ТЭЗҮ-д бидний зүгээс оролцоход. ТЭЗҮ-ийн нарийвчилсан тооцоонууд алдаатай байсан. Төслийн багийнхан ч ТЭЗҮ алдаатай болохыг хүлээн зөвшөөрсөн. Алдаагаа засъя гэж тохиролцсон. Эрдэс баялгийн зөвлөлийн 25 гишүүний 24 нь Оюутолгойн ордын ТЭЗҮ-ийн алдааг засуулж, хүлээж ав гэсэн хурлын проткол ч бий. Тиймээс зөрүүтэй ТЭЗҮ-ээр ашигтай байна гэж ярьж болохгүй.

Монгол өнөөдөр зээл аваагүй гэж ярьж байна. Үнэн чанартаа гэрээ бол цэвэр зээлийн гэрээ. Зээлээр бүтээн байгуулалт өрнөж байна. Өөрөөр хэлбэл, Хөрөнгө оруулалтын гэрээ бус санхүүгийн түрээсийн гэрээ болчихоод байна. Хамгийн том эрсдэл бол өр. Түүнээс УИХ-ын хоёр гишүүн мэтгэлцээд, чи мэдэхгүй байна, мэдлэггүй байна гэж маргах нь чухал биш. Олон нийтэд Оюутолгойн талаар нээлттэй, ил тод мэдээлэл өгч чадсангүй. С.Ганбаатар гишүүний хувьд иргэний зориг гаргасан гэж хэлж болно. Цаашид улстөрчид бус мэргэжлийн хүмүүс мэтгэлцэх ёстой. Мэтгэлцээний үеэр ярьж байсан УИХ-ын дэд дарга С.Баярцогтын ашигтай, эрсдэлгүй гэсэн тооцоо бол хөндлөнгийн “Голдман сакс” компанийн хийсэн тойм судалгаа юм.

Мэтгэлцээн бол шоу байсан

О.Баасанхүү /УИХ-ын гишүүн/

-Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний мэтгэлцээнд сэтгэл дундуур үлдсэн. Мэтгэлцээний үндсэн зорилго нь гэрээ байсан боловч гэрээний асуудлыг тодорхой ярьсангүй. Аль аль талд нь сэтгэл дундуур байгаа. Уг нь хэрэгжиж буй Хөрөнгө оруулалтын гэрээний алдаа оноошы талаар мэтгэлцэх байсан. Нэгдүгээрт, Хөрөнгө оруулалтын гэрээ Монгол улсын ямар хуулийг зөрчиж байгаа эсэх, хоёрдугаарт, гэрээний зүйл заалт бүрэн хэрэгжиж байна уу, гуравдугаарт, гэрээ хэнд ашгаа өгч байгаа юм бэ гэсэн асуудлыг тойрч мэтгэлцэх байсан. Гэрээ гэдэг онол байдаг. Онол дээр суурилаад ярихад гэрээний нөхцөл, хугацаа, үнэ төлбөрөө тохирох учиртай. Ингэж гэрээний ерөнхий утга гарна. Дээрх гурван зарчим байснаар гэрээ бий болно. Бусад нь бол тохиролцоо.

Гэтэл Хөрөнгө оруулалтын гэрээний дээрх гурван үндсэн тулгуур зарчим зөрчилдөж байна. Нэгдүгээрт, ТЭЗҮ-ийг засвартай баталсан. Засвартай батална гэдэг батлаагүй гэсэн үг. УИХ-ын гишүүн С.Баяцогтын хувьд зөвхөн нэг компанийн тойм судалгаанд үндэслэн ашигтай, эрсдэлгүй гэж ярьж болохгүй. Гэрээний нөхцөл тодорхой бус байгаа нь гэрээ тодорхой бус гэсэн 100 хувийн нотолгоо. Хоёрдугаарт, хугацаа. Монгол улсын Ашигт малтмалын тухай хуульд 30 жил гэсэн хугацаа байгаа. Нэмэх нь 20, нэмэх нь 20 гэсэн хугацаа байхгүй. Гэтэл гэрээний хугацаа 70 жил гэж ярьж байгаа нь хууль зөрчсөн. Хуульд байхгүй нөхцөл өгнө гэдэг утгагүй хэрэг.

Гуравдугаарт, үнэ. Мэтгэлцээн бол шоу байсан. Ярих сэдэв нь гэрээ байсан ч тэд өөр зүйлийг ярьсаар өндөрлөсөн.

Гэрээний асуудлыг ажил хэрэгч байдлаар шийдэх учиртай

С.Тогоохүү /Сүхбаатар дүүргийн иргэн/

-Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний талаар мэргэжлийн талаас нь зөв буруу ярьж байгааг сайн мэдэхгүй. Эдийн засаг болон нийгмийн хөгжил, хүн ардынхаа амьдралын сайн сайхны төлөөх гэрээг гацаах ёсгүй. УИХ-ын хоёр гишүүн мэтгэлцээнээс гэрээнд засаж залруулах зүйл олон байгааг ойлгосон. Луйврын гэрээ гэдэг ч юм уу, ямар нэгэн байдлаар нэр хүндэд нь халдах нь буруу. Тиймээс гэрээнд манай төр, засаг хүндэтгэлтэй, нэгдсэн бодлого, байр суурьтай оролцох учиртай.

Гэрээг баталсан Засгийн газрын сайд нь ашигтай, эрсдэлгүй гэж байхад бид юу хэлэх билээ. Монголчууд аливаа зүйлд хошуурч, хэт туйлшрах бус авах гээхийн ухаанаар хандах нь зүйтэй. Оюутолгойн орд монголчуудад хишгээ өгнө гэж найдаж байгаа. Олон улсын түвшинд гэрээг тойрсон асуудлаас болоод Монголын нэр төр унаж байгаад харамсаж байна. Манай улстөрчид улс төрийн соёлтой байх ёстой. Тухайн гэрээний асуудлыг ажил хэрэгч байдлаар шийдэх учиртай. Түүнээс өөрсдийн хийх ажил, үүргээ олон нийтэд зарлаад байх шаардлагагүй. Мэтгэлцээнээр асуудлыг хэлэлцэх нь зөв. Гэхдээ мэтгэлцээнээр улсынхаа нэр хүнд, нийгэм, эдийн засгаа бодож, тооцолгүйгээр ярих нь буруу. »

Бага зэрэг мэдээлэлтэй болсон

О.Болор-Эрдэнэ /ХУИС-ийн Эдийн засгийн сургуулийн IV-дамжааны оюутан/

-УИХ-ын гишүүн С.Баярцогт С.Ганбаатар гишүүнийг мэдэхгүй байна, чадахгүй байна, мэдлэггүй байна гэж шууд гүтгэх нь зохимжгүй байсан. УИХ-ын гишүүн, УИХ-ын дэд дарга хүн олон нийтийн хэвлэл мэдээллийн хэрэгслээр орон даяар гарч байгаа гэдгээ мартсан байх. Мэдээж хэрэг үзэгч болон мэтгэлцэгчээ хүндэтгэх ёстой. Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний талаар иргэд төдийлэн сайн мэдэхгүй байсан. Харин энэ удаагийн мэтгэлцээний дүнд тодорхой хэмжээний ойлголт авсан байх. Миний хувьд мэтгэлцээнээс бага зэргийн мэдээлэлтэй болсон. Гэхдээ хангалттай биш.

С.Баярцогт С.Ганбаатараас илүү байх нь аргагүй

Д.Цэнд /Өмнөговь аймгийн Манлай сумын малчин/

-Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний талаар хүмүүсийн мэдэхгүй байсан нэлээд зүйлийг мэтгэлцээнээр ил гаргаж тавьсан. Мэтгэлцээн сайхан болсон. УИХ-ын гишүүн С.Ганбаатарын хувьд байгаа зүйлийг бодитоор нь гэрээний асуудалтай зүйлийг үг, өгүүлбэрээр нь тодорхой хэлж байсан. Харин УИХ-ын гишүүн С.Баярцогт мэтгэлцэгчээ чи юу ч мэдэхгүй байна, юу ч уншаагүй байна гээд дайраад байгаа нь бүдүүлэг хэрэг болов уу. Баярцогт гишүүний хувьд гэрээг байгуулсан, гэрээний төсөл дээр ажилласан, тухайн үед Сангийн сайдаар ажиллаж байсан хүн учраас нарийн мэдээлэлтэй байхаас аргагүй. С.Ганбаатараас илүү байх учиртай. Мэтгэлцээний дараа нь доктор Авирмэд гуай хэлж байсан. Ганбаатар ард түмний төлөөлөл болж, ард түмний төлөө байлаа. Баярцогт бол зөвхөн эрх баригч, хөрөнгө оруулагчдын талд байлаа гэж ярьж байсан. Үүнтэй санал нэг байгаа.

Ашигтай гэрээ болсон гэдэгт эргэлзэж байна

Б.Энх-Амгалан /МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн багш, доктор/

-УИХ-ын гишүүн С.Баярцогтын тайлбарлаж буй эдийн засгийн тооцоо, загварчлал анхаарал татсан. Хамгийн гол асуудал болох загварчлалын талаар эргэлзээтэй зүйл нэлээд ярьсан. Миний хувьд гэрээний үндсэн үзүүлэлт, гэрээний асуудалтай нарийвчилж бүрэн танилцаагүй. Загварын хувьд С.Баярцогт гишүүн 2-3 янзаар ярьсан. Тухайлбал, 20 мянган хувьсагчтай, 150 өгөгдөлтэй гээд. Хувьсагч тийм олон байдаггүй. Харин эсрэгээрээ байвал болно. 150 хувьсагчтай, 20 мянган өгөгдөлтэй гэж. Буруу ойлгосон байж болох юм. Зөвөөр нь ойлгоод 20 мянган өгөгдөлтэй, 150 хувьсагчтай байлаа гэж үзэхэд ийм хэмжээний программчлал миний мэдэхийн дэлхийд байхгүй. Ямар загвар, программ ашиглаж, тооцоо хийж байгааг мэдэхгүй байна.

Эдийн засагч хүний хувьд дүгнэхэд хөрөнгө оруулалтын гэрээ 59 хувийн ашиг хүртэх гэдэг ч юм уу сайн, ашигтай гэрээ болсон гэдэгт эргэлзэж байна. Монголын 34 хувь бол өр. Үүнийг манайх тодорхой хэмжээний хүүтэй авч байгаа. Үүнийгээ буцаагаад хүүтэй нь төлнө. Энэ нь эргээд л иргэдийн нуруунд дарамт учруулна. Төслийн хүрээнд эдийн засаг өсөх хандлага бол бий. Үнээгээр жишээ аваад ярьж байсан. Гэтэл үнээний үнийн талаар сайн яриагүй. Үнээний үнийг ярьж байж, дараа нь тэжээл, ус, орон байрны тухай ярих хэрэгтэй. Өөрөөр хэлбэл, газар доорх баялгаа үнэлэх ёстой байсан. Загварчлал гэдэг бол баталгаатай, бүрэн төлөөлөх зүйл биш. Загвар гэдэг зүйл чинь 100 хувь бодит байдлыг төлөөлөх боломжгүй.

Монгол улс ардчилалтай гэдгээ баталлаа

Д.Ачит-Эрдэнэ /Монголын Олон улсын хөрөнгийн корпорацийн ерөнхийлөгч/

-Мэтгэлцээний хамгийн том үр дүн бол Оюутолгойн хөрөнгө оруулалтын гэрээний талаар олон нийтэд мэдээлэл өгч чадсанд байгаа юм. Гэхдээ ямар зорилгоор мэтгэлцээн хийсэн, ямар асуудлыг хөндөх байсан, ямар асуултыг тавих байсан нь ойлгомжгүй үлдсэн. Тухайн мэтгэлцээний хөтлөгч тааруу, гол сэдэв рүү нь хөтөлж оруулахгүй байсан.

Түүнчлэн Монгол улс ардчилалтай орон гэдгээ дахиад баталлаа. Байгалийн баялаг ихтэй орны гэрээ, тохироог эрх баригч болон 1-2 гэр бүлтэй хийдэг бол Монголд Засгийн газартай нь байгуулж байна. Өнгөрсөн хугацаанд Оюутолгой төслийн ашиг гэж гэрээний зарчмаар иргэдэд 21 мянган төгрөг болон бусад тусламж, дэмжлэгээр хүрсэн.

Төслөөс манайх ашиг хүртэхээс гадна эдийн засаг тэлнэ гэдэг өөрөө том боломж. Үүнийг дагаад ажлын байр, туслах үйлчилгээний салбар хөгжиж байна. Оюутолгойн ордоос монголчууд ногдол ашиг хүртэнэ. Үүнээс гадна иргэд өмчийн харилцааг сайн ойлгохгүй байна. Энэ чиглэлийн мэдээлэл үгүйлэгдэж байна. ■

ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ БА ЦЭВЭР НҮҮРС

ШАНХАЙН УУЛЗАЛТ ЮУ ӨГӨХ ВЭ?

Б.ҮҮРИЙНТУЯА

Дэлхийн эдийн засаг, санхүү, бизнесийн тайзнаа Монгол улс гялалзаж байна. Түүхэнд бэхэлсэн эзэн Чингисийн нэрээр бус газрын хэвлий дэх байгалийн баялаг, эдийн засгийн хурдацтай өсөлтөөрөө олны анхааралд өртөх болсон Монголыг гаднын хөрөнгө оруулагч, байгууллагууд сонирхох болоод багагүй хугацаа өнгөрсөн. Уул уурхай, хөрөнгө оруулалтын чухал “объект” хэмээн хүлээн зөвшөөрөгдсөн Монгол улсын хувьд баялгаа хэрхэн эдийн засгийн эргэлтэд оруулж, улмаар өсөлтөө бататгах вэ гэдэг нь дэлхий нийтийн ярианы сэдэв болж байна. Үүнтэй холбоотой дээд хэмжээний уулзалт, хурлууд зохион байгуулагдах нь энгийн үзэгдэл болжээ.

Дэлхийн эдийн засаг, бизнесийн чигийг тодорхойлогчдын нэгд зүй ёсоор ордог БНХАУ-ын Шанхай хотноо Монголын хөрөнгийн бирж “INBC Global”-тай хамтран “Монголын хөрөнгө оруулалтын чуулга уулзалт - Цэвэр нүүрсний Азийн дээд хэмжээний уулзалт 2012” арга хэмжээг энэ сарын 10-12-нд зохион байгуулах гэж байна. Чуулга уулзалтад олон улсын томоохон хөрөнгө оруулагчид, бизнес, санхүүгийн салбарынхан, Монголын уул уурхай, дэд бүтэц, эрчим хүч, санхүү, хөрөнгө оруулалтын томоохон төлөөлөгчид оролцох юм. Чуулганы үеэр Монгол дахь хөрөнгө оруулалтын орчин болоод боломжууд, уул уурхайн эрчим хүч, дэд бүтэц, түүний санхүүжилтийн талаар хэлэлцэх төдийгүй нүүрсээр баян Монголын нөөц, ашиглалт зэрэг сэдвүүдийг хөндөх аж.



“Монголын хөрөнгө оруулалтын чуулга, уулзалт” нь Их Британи, Япон, Австрали, Франц зэрэг дэлхийн эдийн засгийн гол төлөөллүүд оролцдог нэр хүндтэй арга хэмжээ. Энэ удаа хөгжиж буй зах зээлтэй орнуудын олон улсад олгож буй хөрөнгө оруулалт, бизнес болон санхүүгийн асуудлаас гадна Монголын Гадаадын хөрөнгө оруулалтын тухай хууль, түүний үр нөлөө, хөрөнгийн зах зээл мөн “Эрдэнэс Тавантолгой” болон “Оюутолгой” төслийн хэрэгжилтийн талаар хэлэлцэх аж.

XXI зуунд эрчим хүчний хангамж болоод байгальд ээлтэй шийдэл бидний толгойг гашилгах боллоо. “Цэвэр нүүрсний Азийн дээд хэмжээний уулзалт 2012” арга хэмжээний үеэр уул уурхайн салбарын хөрөнгө оруулалтын боломж, тулгамдаж буй асуудал, нүүрс шингэрүүлэх болон хийжүүлэх дэвшилт технологиудын талаар Мянганы сорилтын сан, “PriceWaterHouseCoopers” болон “Ньюком” группын удирдах албан тушаалтнууд илтгэх юм. Түүнчлэн Монголын хөрөнгийн бирж, Монголын бизнесийн зөвлөл, Anderson & Anderson зэрэг нэр хүнд бүхий байгууллагууд оролцож байгаа юм.

Уг чуулга уулзалтад Дэлхийн нүүрсний ассоциаци, Оксфорд бизнес групп, Монголын үндэсний худалдаа, аж үйлдвэрийн танхим хамтран ажиллаж байгаагийн сацуу “Mongolian Economy” сэтгүүл мэдээллийн ивээн тэтгэгчээр урилгаар ажиллах болсоныг дуулгахад таатай байна. Манай сэтгүүллийн сурвалжлах баг тус хурлаас ганзага дүүрэн ирж уншигч та бүхэндээ сонин сайхан мэдээлэл хүргэх болно. ■

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ХӨРӨНГИЙН ЗАХ ЗЭЭЛ ХӨРӨХ БОЛООГҮЙ

Б.ЭНХЦЭЦЭГ

...Хөрөнгийн зах зээлийн боломж, гарцыг тултал нь ашиглаж чаддаггүй юм аа гэхэд тоглогчдоо төрөлжүүлэх хэрэгтэйг мэргэжилтнүүд учирлаж буй. Монголын хөрөнгийн зах зээл эдийн засгийнхаа өсөлтийг даган гэлдрэх бус хөгжлөө хөшүүрэгдэх хүч байх ёстой...

Ойрын үед хөшингө, хойрго, хөрөнгө мөнгө идсэнээрээ олонтаа дуудуулах болсон Монголын хөрөнгийн биржийг хөгжих гээд байна уу, хөрөх гээд байна уу хэмээн асуух нь их болж.

Шинэ систем нэвтрэхээс өмнө өдөрт дунджаар 100 сая төгрөгийн арилжаа хийгддэг байсан гэдэг. Гэвч сүүлийн үед арилжааны хэмжээ дунджаар 10-20 сая төгрөг болж буурчээ. Энэ нь арилжааны шинэ талбарт талцах болсноос хойших таагүй үзүүлэлт. Өөрөөр хэлбэл, хөрөнгийн биржийн арилжаа мөлхөж, брокер дилерүүд сөхөрч байна гэсэн үг. Манайх шиг жижиг зах зээл шингээж чадахгүй олон брокер дилертэй болсон нь дэлхийд хүлээн зөвшөөрөгдсөн шинэ систем, эдийн засгийн өндөр өсөлт, уул уурхайн "барагдашгүй" баялагтай холбоотой. Системийн шинэчлэлийн дараа хөрөнгийн биржийн босгыг боомилж байна хэмээн бослого гаргах нь холгүй байсан брокер дилерүүдийн дийлэнх нь МХБ-тэй хамтран ажиллах гэрээгээ шинэчилсэн ч шаардлага хангаж арилжаанд оролцох эрхтэй брокерын тоо өмнөх сарынхаас нэгээр ахиж 51-т хүрчээ.

Өнгөрсөн сарын эцсийн МХБ-ийн топ-20 индексийг энэ оны нэгдүгээр сартай харьцуулахад 27.7 хувиар буурсан үзүүлэлттэй гарсан нь таагүй. /Хүснэрт-1/ Шинэ системээс хамаг юм боллоо гэх нэг хэсэг байхад зах зээлийн жамыг технологийн шинэчлэлтэй холбох нь тэнэглэл гэж үзэх хэсэг ч байна.


Дан ганц Монголын хөрөнгийн зах зээл дээрх компаниудын үнэлгээ шалдаа бууж, шал долоох гээд байгаа юм уу гэхээр үгүй бололтой. Монголд үйл ажиллагаа явуулж буй олон улсын хөрөнгийн бирж дээрх хувьцаат компаниудын сүүлийн нэг жилийн хувьцааны ханшийн дундаж 49.7 хувиар буурсан үзүүлэлттэй байгаа юм. /Хүснэгт-2/ Үүн дундаас он гарсаар Торонтогийн хөрөнгийн биржид бүртгэлтэй Монголд үйл ажиллагаа явуулдаг компаниудын үнэт цаасны үнэ 50.2 хувиар буюу хамгийн өндөр "чөлөөт" уналтыг үзүүлжээ.

Өнгөрсөн хямралын үеэр Nasdaq, Нью-Йоркийн хөрөнгийн биржид ямар ч алдаа гараагүй атлаа Америкийн хөрөнгийн зах зээлийн үзүүлэлтүүд шууд уруудаж эхэлсэн. Үүний эх үүсвэр нь тус улсын эдийн засаг хямарсанд байсан юм. Гэвч Монголын эдийн засгийг ерөнхийд нь авч үзвэл өсөж байгаа. Тэгвэл Монголд үйл ажиллагаа явуулж буй компаниудын хувьцааны үнэлгээ яагаад унаад байна вэ?

Хөрөнгийн биржид бүртгэлтэй нийт компаниудын энэ оны ашгийг өнгөрсөн онтой харьцуулахад дор хаяж нэгээс хоёр дахин өсөлттэй байгаа бол 2009 болон 2010 оныхтой зэрэгцүүлбэл илүү өндөр байгаа аж. Гэтэл компаниуд ашигтай ажиллаад байгаа атлаа индекс уруудсаар. Үүнийг брокер дилерийн "BDSec" компанийн мэргэжилтэн Ч.Дагийжанчив "Тоо баримт дээр суурилаагүй сэтгэл зүйн чанартай заралт хийгдээд байна гэж үзэж байгаа" хэмээн тайлбарласан юм. Түүнчлэн тэрбээр хэлэхдээ "Дотоод талаас илүү их зарах хандлага байгаа бол гадаад талаас дансаа нээлгэх үйл явц өрнөж байна. Мөн улс төрийн шийдвэрүүдээс үүдэн хөрөнгө оруулагчдад хүлээлт үүсчихсэн байна. Манай зах зээл жижигхэн учир зарах захиалга ялимгүй нэмэгдэхэд л үнэ уруудаад эхэлж байгаа юм. Түүнээс биш, бөөнөөрөө зараад, зах зээлээс гараад явах гээд байгаа юм бол байхгүй" гэв.

Монголын хөрөнгийн зах зээлийн үзүүлэлт хараахан олон

Хүснэгт 1 27.7 хувийн уналт



Эх сурвалж: МХБ

улсын нөлөөнд автах болоогүй байгаа. Гэвч гадаад тоглогчид дийлэнх хувийг нь эзэлдгийн хувьд дотоод мэдээллээс хараат байдаг. Хэдийгээр 800.000 монгол хүн данс нээлгэсэн ч үнэт цаасны зах зээлийн үйл ажиллагааг ердөө гаднынхны 500-600 гаруй идэвхтэй данс авч явдаг байна. Өнгөрсөн оны эхээр гаднын хоёр гурван хөрөнгө оруулалтын сан арилжаанд оролцож эхэлмэгц монголчууд мөн адил худалдаж аваад эхэлсэн. Иймээс индекс хурдацтай өссөн байдаг.

Төр төрхөмд нь буцаахыг хүсээ юү?

Улаанбаатарчууд уналтаа гайхан суухад гадаадын хөрөнгө оруулагчид Монголын хөрөнгийн зах зээлээс гайхамшиг бус гарц хүлээн анасаар.

Гадаадын хөрөнгө оруулагчид Монголын хөрөнгийн зах зээлийн ямар асуудалд чих тавьж, санаагаа чилээж байгааг хамгийн сүүлд зохион байгуулагдсан хөрөнгө оруулалтын хоёр ч удаагийн хурлаар авч үзэж болох юм. Энэ оны аравдугаар сард Монголын хөрөнгө оруулалт 2012 чуулган, өнгөрсөн сард “Economic dialogue: Invest Mongolia” сэдэвт дугуй ширээний уулзалт тус тус Хонконгт зохион байгуулагдсан билээ. Хөрөнгө оруулагчдын хувьд хамгийн их сонирхож байсан асуудал нь хэзээ Үнэт цаасны тухай хууль батлагдах вэ гэдэг байв. Мөн тэд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар, дүрэм журам юу болох түүнчлэн давхар бүртгэлийн асуудлыг ихээхэн сонирхож байжээ. Хөрөнгө оруулагчид Монголын хөрөнгийн зах зээлд орохыг тэсэн ядан хүлээж байгаа ч тоглоомын дүрэм цэгцэрч, талбай цэвэрлэгдэхийг хүлээж байгаа нь илт.

Монголын хөрөнгийн биржийн системийн шинэчлэл хийгдээд дуусчихсан байхад гол хууль нь УИХ-аар ороо ч үгүй байгаа. Уг нь бол Үнэт цаасны тухай хуулийн шинэчилсэн хувилбар бэлэн болоод нэлээд удаж байна. Тус хуулийн төслийг хөрөнгийн зах зээлийг шинэ шатанд гаргах учиртай зарчмын чухал ололт тусгагдсан хуулийн төсөл болсон хэмээн холбогдох албаныхан дүгнэж буй. УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Энэ чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад орсон ч саяхан Засгийн газар татаад авчихсан. Чухам ямар үндэслэлээр татсанаа тайлбарлаагүй. Энэ хуулийг цаг алдалгүй хэлэлцэх ёстой. Үүнийг дэмжиж буй гишүүд бий” гэв.

Хөрөнгийн зах зээлийн боломж, гарцыг тултал нь ашиглаж чаддаггүй юм аа гэхэд тоглогчдоо төрөлжүүлэх хэрэгтэйг мэргэжилтнүүд учирлаж буй. Монголын хөрөнгийн зах зээл Эдийн засгийнхаа өсөлтийг даган гэлдрэх бус хөгжлөө хөшүүргэдэх хүч байх ёстой. Цуутай шинэчлэлийн зорилго ч тэр . “Үнэт цаасны тухай хууль арилжааны олон боломжуудыг хааж байгаа учир жижиг тоглогчидтойгоо суугаад байна” Кастадион банк болон өөр замаар ч мөнгө орж ирэхгүй байгаа гэсэн үг” хэмээн МХБ-ийн дэд захирал Г.Саруул хэлсэн юм. Одоогоор жижиг тоглогчдын хувьд өөрийн дансыг нээж тодорхой хэмжээний тоглолт хийж байгаа. Гэвч Монголын хөрөнгийн зах зээл жижиг тоглогчид, эрсдэл өндөртэй хэдэн сангуудаар хязгаарлагдаад байх юм уу.

Угаас их мөнгө гэдэг тэр хэмжээнд өндөр эрсдэл дагуулдаг онцлогтой. Учир нь үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн систем гэдэг асар том эрсдэлийг агуулж байдаг эмзэг хэсэг. Холбогдох мэргэжилтнүүдийн ярианаас үзэхэд тухайлбал “GP



Morgan”-ны хөрөнгө оруулалтын сан ороод ирлээ гэж бодоход кастадион үйлчилгээ зайлшгүй хэрэгтэй болох юм байна. Ингэвэл одоогийн арилжаа сая төгрөгөөр бус хэдэн арван сая ам.доллараар ч яригдаж эхлэх боломжтой. Гэвч жинтэй хөрөнгө татахын тулд их хэмжээний мөнгө хариуцдаг олон улсад нэр хүндтэй кастадион банк хэрэгтэй. Гадаадын хөрөнгө оруулагчид Монголын банкуудыг мэдэхгүй учир итгэл хүлээлгэн төлбөр тооцоогоо хийлгэхгүй нь ойлгомжтой. Харин хэдэн тэрбумаар

хэмжигдэх хөрөнгийн баталгаатай “City”, “HSBC” банкны кастадион үйлчилгээ Монголтой хамтарвал гаднын хөрөнгө оруулагч жишээлбэл 50 сая ам.долларыг айхгүй аваад ирэх нөхцөл бүрдэнэ. Тэр өдрийн тэнгэр мэдэг гээд өндөр эрсдэл үүрчихдэг гадаадын “ковбой” хөрөнгө оруулагчид хөрөнгийн зах зээлийн олимпийн найдвар биш. Тэд хэзээ ч биднийг орхиод явж чадна. Хэрвээ бид найдаж болох хөрөнгө оруулалтын сангуудыг оруулж ирье гэвэл дэлхийн стандарт кастадионыг үл тоомсорлох эрхгүй. Үүний тулд хууль бас дахин хууль хэрэгтэй байна.



Тохиолдлоор давхцаж таарав уу, хөрөнгө оруулагчид тайвшрав уу. Ямартай ч Оюутолгойн гэрээг өөрчлөх эсэхтэй холбогдсон УИХ-ын гишүүн С. Баярцогт, Д. Ганбаатар нарын дуулиант хэлэлцүүлгээс хойш буюу арваннэгдүгээр сарын сүүлчээс хөрөнгийн зах зээлийн арилжаа сэргэх хандлагатай болов. Энэ хугацаанд нийт арилжааны үнийн дүн өдөрт дунджаар 50-55 сая төгрөг хүрч өмнөхөөсөө 10 дахин өсчээ. Дээд түвшинд тодорхойгүй байдал үүсэх үед хүлээлт үүсдэг болсныг бүгд мэддэг болчихсон. Өнөөдөр Wall Street journal, Reuters тэргүүтэй олон улсын хэвлэл мэдээллийн байгууллагууд Монголын улс төрийн шийдвэрүүдийг цаг алдалгүй зарладаг болсон нь Монголын улстөрчид тогоон дотроо хагаралдаад байх нь томоохон уршиг дагуулж болох талтайг харуулж байна.


Эргэн харвал…

Монголын хөрөнгийн зах зээлд юу болоод өнгөрөв өө. Нэгдүгээрт, гаднын хөрөнгө оруулагчид урьдчилж мэдэхийн аргагүй үйл явдлаас сэрэмжилж, Монголын сонгуулийн үр дүнг хүлээсэн. Хоёрдугаарт, хөрөнгийн бирж шинэ систем нэвтрүүлсэн учир үйл ажиллагаа нь жигдэрч, харилцагч, зах зээл хоёрыг холбогч брокер дилерүүд шаардлагад нийцэж, эрхээ авахыг хүлээсэн. Гуравдугаарт буюу одоо хөрөнгө оруулагчид хуучин данстай байсан үгүйгээс үл хамааран мөнгөн төлбөр тооцоо гүйцэтгэх үүрэг хүлээгээд буй банкинд данс нээлгэхээ хүлээж байна.

Сүүлийн үед данс нээхгүй байгаатай холбогдуулан арилжаанд орж чадахгүй байна гэх гомдол тасрахаа болив. Жишээлбэл, “BD-Sec” компанийн хувьд өнөөдрийн байдлаар нийт харилцагчдынх нь дөнгөж 20 хувь нь данс нээлгээд байгаа гэнэ. Мөн данс нээлгэчихсэн атлаа арилжаанд оролцохгүй хүлээсэн хөрөнгө оруулагчид ч байгаа брокер дилерүүд хэлж байгаа. Тоглогчид шинээр нэмэгдэхгүй аваас арилжаа сэргэхгүй гэсэн үг. Шинэ мөнгө орж ирэх урсгал зогсонги байвал хөрөнгийн зах зээл хөдлөхгүй төдийгүй хуучин мөнгөнийхээ хэмжээнд эргэлдэнэ. “Asian Pacific Investment Partners” компанийн захирал Лий Кашел “Бидний хувьд данс нээх ажлыг гурван сарын дотор дуусгана гэж харж байна. Бусад брокер дилерийн хувьд энэ хугацаа зургаагаас есөн сарын хооронд ч байж мэднэ. Хүн болгон данстай болтол Монголын хөрөнгийн биржийн хөрвөх чадвар сайжрахыг хүлээх хэрэг байхгүй. Учир нь хэн ч дансаа нээлгэтэл арилжаанд оролцох эрхгүй шүү дээ” гэв. Хуучин Үнэт цаасны төлбөр тооцоо хадгаламжийн төвийн хариуцдаг байсан хувьцаа, мөнгөн төлбөр тооцоог хоёр тийш нь салгачихсан байгаа. Өөрөөр хэлбэл, бэлэн мөнгөний шилжүүлгийг одооноос банк хийнэ.

Данс нээлгэх үйл явц дэндүү удаашралтай, чирэгдэлтэй байгааг амтай болгон шүүмжилж байна. Ойрын жишээ татахад, Хонконгийн биржийн арилжаанд оролцъё гээд данс нээлгэхэд ердөө л хоёр цаг хангалттай. Тэгвэл Монголд өнөөдөр энэ нь хоёр сарын ажил болж хувирчихаад байна.

Хүснэгт 2. 49.7 хувийн уналт



Эх сурвалж: МХБ

Банкуудын шаардаж байгаа найм, есөн төрлийн бичиг баримтыг бүрдүүлж, нотариатаар батлуулах шаардлагатай. Дээр нь харилцагчдад өөрийн брокер дилерийн сонгосон банканд данстай болох болзлыг тулгачихсан. Харин зарим харилцагч өөрийн сонгосон банкаа хүсэмжилж байгаагаа илэрхийлж гэдийх аж.

Монголд “Direct deposit” буюу нэг банкнаас нөгөө руу шууд мөнгийг нь татах харилцан уялдаа бүхий үйлчилгээ нэвтэрчихвэл харилцагчид дуртай банкаараа үйлчлүүлж болно. Тухайлбал “Голомт” банкны брокер нь ХААН банкны данснаас шууд төлбөрийг нь татахыг л хэлээд байгаа хэрэг. Харамсалтай нь өндөр хөгжсөн банкны салбартай Монгол улсад ийм үйлчилгээ байхгүй.

Нөгөө талаас гадаадын хөрөнгө оруулагчдын хувьд Монголд данстай болохын тулд олон шат дамжлагыг даван туулах сэтгэлийн хаттай байх хэрэгтэй болжээ. Монгол шиг булан тойроод нотариатын газар байдаггүй гадаадын орнуудад урьдчилж цаг авдаг учир бичиг баримт нотариатаар батлуулахад 3-6 долоо хоног шаарддаг.

Жишээлбэл, Японд нотариатын үйлчилгээ авахад зургаан долоо хоног шаарддаг бөгөөд нэг ширхэг баримтыг нотариатжуулахад 100 ам.доллар болдог байна. Үүний дараа шуудангаар бичиг баримтаа явуулна. Яаралтай шуудангаар 40-50 ам.доллар үрж явуулдаг нь цөөхөн тул энгийн шуудангаар өнөөх баримт нь хамгийн багадаа сар аялсны эцэст Монголд ирнэ. Ингэхээр манайд данс нээлгэж хэдэн хувьцаа авахын тулд хоёроос гурван мянган ам.доллар үрэх хүн хэр олон байх бол.

МХБ-ийн дэд захирал Саруулын хэлж байгаагаар эдгээр асуудлаар банкуудтай зөвшилцөж байгаа бөгөөд тэдний зүгээс холбогдох дүрэм журмаа гаргах тал дээр нааштай хандаж байгаа аж. Тиймээс ойрын үед эцсийн шийдэл гарах найдлага байхгүй биш байгаа гэнэ.

Хүлээлт, айдас, горьдлого гэх гурван үгээр их шинэчлэл хийсэн Монголын хөрөнгийн зах зээлийн нөхцөл байдлыг товчхон тодорхойлж болох юм. Олон улсад нэр хүндтэй хөрөнгө оруулалтын банк, сангуудыг томоохон харилцагч нь Монголд хөрөнгө оруулъя хэмээн шахаж байдаг. Монголд хууль тогтоомж, дүрэм журам нь цэгцэрч өгөхгүй удаад байдаг.

Хөрөнгийн зах зээлийг өөдрөгөөр харж буй мэргэжилтнүүд сэргэнэ гэж хэлж байгаа. Боломж бололцоо нь бүрдчихээд байхад бие биенийгээ боомилоод, талцаад суугаад байж таарах уу? ■

САНХҮҮГИЙН ЗАХ ЗЭЭЛ

ЧИНГИС БОНДЫН ЧИН ХҮСЭЛ ЮҮ ВЭ

Б.ЦЭЦЭЭ

...Эндээс явахдаа бондын хүүг 3.5 хувиас хэтрүүлэхгүй, харин ч түүнээс бага байлгах юм ярьж суусан сайд нар эргэж ирээд “Манайх Испаниас сайн нөхцөлтөйгээр бага хүүтэй зарж чадлаа, энэ бол гайхамшиг” хэмээж байна...

Товлосон тав хоногийн хугацааг үл тоомсорлон “Чингис” бонд дэлхийн санхүүгийн зах зээлийг доргиосон тухай “Wall Street Journal”, “Financial Times” тэргүүтэй хэвлэл тэсгэл алдан мэдээллээ. “Өнгөрсөн 22 жилийн хугацаанд Олон улсын валютын сан таван ч удаа аварсан Монгол улс арваннэгдүгээр сарын 28-нд 1.5 тэрбум ам.долларын бонд гаргалаа” хэмээн тэд нийтлэлээ эхлүүлсэн байх юм.

Бонд гаргах ажлын хэсэгт ажилласан Эдийн засгийн хөгжлийн яамны сайд Н.Батбаяр, Сангийн сайд Ч.Улаан нар Засгийн газрын бонд эзнээ олсноос хойш хоёр өдрийн дараа орон даяар бахархалтайгаар зарласан билээ. Тэд мэдэгдлийнхээ эхэнд Монгол улс түүхэндээ анх удаа Засгийн газрын бондыг дэлхийн зах зээлд амжилттай арилжаалласа. Энэ нь Монгол улсын нэр хүнд дэлхийн санхүүгийн зах зээлд өндөр байгаагийн илэрхийлэл гэдгийг тодотгосон юм гэв. Мөнгөтэй болсон юм чинь ажлыг яралзуулаад өгнө гэж хэлж байсан.

Эх орон, эд баялгаараа дэнчин тавьсан Монгол улсын хувьд өндөр эргэн төлөлттэй энэ мөнгө ямартай ч төсвийн алдагдал нөхөхгүй, урсгал зардлыг санхүүжүүлэхгүй, нийгмийн халамжийг хаахгүй гэдгийг тэд тангарагласан гэхэд хилсдэхгүй. Телевизийнхэн хальсандаа, ▸▸

хэвлэлийнхэн дуу хураагуурtаа тод бичиж, баримт түүхийг хадгаллаа. Харин дээрх бондод шинэ бүтээн байгуулалт, дэд бүтэц, эрчим хүч, төмөр зам, хатуу хучилттай зам барих, уул уурхайн бүтээгдэхүүн боловсруулах үйлдвэр байгуулна хэмээн ерөнхий, бөөрөнхий үгээр ам гараад байгаа. Бонд арилжаалах үед хөрөнгө оруулагчдад төслүүдээ танилцуулсан гэх боловч монголчууддаа нарийвчлан тайлагнаж, нэрийг нь дурдсан юм одоогоор алга. Дэлхийн санхүүгийн зах зээлийг шуугиулсан бонд гаргасан бодлого тодорхойлогчид мөнгөтэй болчихлоо, одоо яах вэ гэдэг асуултад бөөрөнхий хариу хэлээд сууж таарахгүй.

УИХ-ын гишүүн Р.Амаржаргал “Санхүүжүүлэх төсөл тун хомс юм билээ. Таван жилийн дотор өртөгөө нөхөх төсөл олох амаргүй . Уул нь бид гэрийн даалгавраа сайн хийх ёстой байсан юм. Шаардлагатай төслүүдээ жагсаагаад, нарийн шалгууруар эрэмбэлээд, улмаар текник, эдийн засгийн үндэслэлийг тооцсон байх ёстой. Гэвч өнөөдөр бид энэ мөнгө эргэлтэд оролгүй “зүгээр хэвтэж буй” хоног тутамд 130-140 мянган ам.доллар төлнө” гэв.

Шинэчлэлийн Засгийн газрын ойрын жилүүдэд хийх бүтээн байгуулалтын томоохон төслүүдийг санхүүжүүлэх Засгийн газрын бонд гаргах шийдвэрийг УИХ гаргаж, 2013 онд 1.5 тэрбум ам.долларын бонд арилжаалах эрхийг олгосон. Түүний зэрэгцээ ирэх жилүүдэд бондын хэмжээг таван тэрбум ам.доллар хүртэл нэмэгдүүлэх юм. Цаг хугацааны хувьд яаравчилж, энэ онд багтааж гаргах болсон нь хөрөнгийн зах зээл тааламжтай байсантай холбоотой хэмээн мэргэжилтнүүдийн зарим нь онцлох аж. Төсөв мөнгөний асуудалтай үед Засгийн газрын бондын хүү харьцангуй гайгүй байдагтай холбогдуулан доогуур хүүтэй гаргах нөхцлийг алдахгүй гэсэндээ яарсан ч байж мэднэ.

Зөв зарцуулбал зээл, буруу зарцуулбал өр

Засгийн газрын таван жилийн хугацаатай 500 сая ам.долларын бонд 4,125 хувийн хүүтэй, арван жилийн хугацаатай нэг тэрбум ам.долларын бонд нь 5,125 хувийн хүүтэй юм. Чингис бондын хувьд хоног тутам буюу арванхоёрдугаар сарын 6-наас 196.000 ам.доллар, өнөөгийн ханшаар 275 сая төгрөг нэмж төлнө. Таван жилийн дараа 500 сая ам.долларын үндсэн өр нэхэгдэнэ. Тэгээд тэрбумын хүүнд хоногт 140.000 ам.доллар төлж дахин таван жил болсны дараа үндсэн өрөө төлнө. Энэхүү 1.5 тэрбум ам.долларыг бид нийт 605 сая ам.долларын хүүтэй хамт буцаан барагдуулна. Мөн төгрөгийн ханш энэ маягаар сулрсаар байвал ирээдүйд эргэн төлөх чадвар тэр хэмжээнд мөн буурна гэсэн үг.

Эндээс явахдаа бондын хүүг 3.5 хувиас хэтрүүлэхгүй, харин ч түүнээс бага байлгах юм ярьж суусан сайд нар эргэж ирээд “Манайх Испаниас сайн нөхцөлтөйгээр бага хүүтэй зарж чадлаа, энэ бол гайхамшиг” хэмээж байна. Монгол улс өөрийгөө



Испанитай жиших нь сайны ерөөл үү, муугийн ёр уу. Хариуцлагын тогтолцоогүй Грек, Испани төрийн бондын зарцуулалтыг хянаж чадаагүй учир өнөөдөр өрөнд баригдаж, өтөнд идэгдчихээд сууж байгааг бид харж, халаглаж сууна. Эдийн засагч Д.Жаргалсайхан “Энэ хоёр орныг Европын холбооны бусад орон “чирэн гаргаж”, алдагдлыг нь хуваан нөхөж, эдийн засгийг нь хэвийн урсгалд оруулахаар ажиллаж байна. Харин Монгол улсыг хэн тэгж “чирэх” билээ” хэмээн нийтлэлдээ бичжээ.

Зөв зарцуулбал зээл, буруу зарцуулбал өр болж хувирна гэдэг болгоомжлол хүн бүрт байна.

Бонд гэдэг нэгээс нөгөөд шилжүүлэн арилжиж болдог өрийн бичиг гэдгээрээ онцлогтой. Манай улсын бондыг 400 гаруй банк санхүүгийн байгууллага сонирхож, 120 гаруй нь худалдан авах ажиллагаанд идэвхтэй оролцсон тухай мэдээлэл байна. Чингис бондын нэр хүнд ийм л өндөрт байж. Тиймээс бодлого тодорхойлогчдын төлөвлөсөн дараагийн бондыг гаргахад асуудал үүсэхгүй нь гэж харж суугаа.

Хоёр оронтой тооноос салахаа байсан инфляци, ВВ- үнэлгээ рүү буусан хөрөнгө оруулалтын орчин, ОУВС-гийн таамаглалаар 12.7 хувь руу унаж магадгүй эдийн засгийн өсөлт, ДНБ-ий долоон хувьтай тэнцэх төсвийн алдагдалтай Монгол улсад тэд яагаад итгэх болов. Арвин их ашигт малтмалын нөөц боломж гэдэг нь хэнд ч ойлгомжтой биз.

Бонд гэдэг тийм ч болохгүй тоглоом биш. Өндөр хөгжилтэй орнууд хөрөнгийн зах зээлээ байнга дэмжиж ажилладаг. Жишээ нь, Австралийн Засгийн газар байнга төсвийн илүүдэлтэй явдаг. Тиймээс ч Засгийн газар нь бонд гаргаад хий хүү төлөөд явж байна. Санхүүгийн зохицуулах хорооны Үнэт цаасны газрын хянан шалгагч С.Цэвэгмид “Төсвийн алдагдалгүй улс бонд гаргаад явна гэдэг нь Засгийн газрын бондын хүү нь зах зээлийн жишиг хүү болдогт оршдог. Урт хугацаатай санхүүгийн хэрэгслийн хувьцааны үнэлгээ хийе гэхэд нэг, хоёр эсвэл таван жилийн жишиг хүү байдаггүй. Тийм учраас Засгийн газар нь төсвийн илүүдэлтэй өөрөөр хэлбэл, өр зээл хураах хэрэггүй ч Засгийн газрын бонд гаргаад явж байх жишээтэй” гэв. Өндөр хөгжилтэй орнуудын хувьд хямралгүй үед энэ төрлийн арга хэмжээгээр хөрөнгө оруулагчдыг татаж хөрөнгийн зах зээлээ дэмжин ажилладаг байна. Засгийн газар бонд гаргалтаа тогтмолжуулах хэрэгтэй ч гэж үздэг. Нөгөө талаар тав, арван жилийн хугацаатай бонд нь дотоодын том том төслүүдээ санхүүжүүлээд явах боломжийг бүрдүүлдэг сайн талтай. Зөв зүгт мөрөө гаргавал бондын өгөөж чулуу болдог дэлхий нийтийн туршлага бий.

ЕРӨНХИЙЛӨГЧ

Ц.ЭЛБЭГДОРЖ: УЛСЫНХАА НЭРЭЭР АВЧ БУЙ ӨР

Монгол улсын Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж УИХ-ын дарга З.Энхболд, Ерөнхий сайд Н.Алтанхуяг, УИХ-ын гишүүн Х.Гарамгайбаатар, Ц.Даваасүрэн, Засгийн газрын гишүүн Н.Батбаяр, Ч.Улаан, Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга П.Цагаан, УАБЗ-ийн нарийн бичгийн дарга Ц.Энхтүвшин, Монголбанкны ерөнхийлөгч Н.Золжаргал нартай энэ сарын 6-нд албан өрөөндөө уулзаж, дараах мэдэгдлийг хийлээ.

Засгийн газрын үнэт цаасны талаар авах зарим арга хэмжээний тухай гэсэн Үндэсний Аюулгүй Байдлын Зөвлөлийн нээлттэй зөвлөмж гарсан. Та бүхэн бүгдээрээ мэдэж байгаа, Монгол улс үнэт цаас арилжсан. Мөнгө нь өнөө өглөөний байдлаар Монгол улсын дансанд орж ирсэн байгаа. Эл асуудлаар ярилцаад зөвлөмж гаргасан юм. Хамгийн түрүүнд нэг зүйлийг хэлье. Монгол улс хариуцлагатай улс болох ёстой. Ерөнхийлөгчөөсөө эхлээд Ерөнхий сайд, УИХ-ын дарга, Засгийн газрын гишүүд, жирийн иргэд бүгдээрээ хариуцлагатай байх учиртай. Ялангуяа албаны хүмүүсийн хийж буй мэдэгдэл одоо үнэтэй болсон. Ер нь олон улсын хөрөнгө оруулагчдыг үргээсэн, буруу мэдээлэл өгсөн, популизм хийсэн улс төр Монголд одоо явахаа болилоо. Хэрвээ тийм юм хийвэл үнэтэй болсон. Их хурлын нэг гишүүний хариуцлагагүй мэдэгдэл /бондоор бодоход/ 10 сая ам.долларын өр болж монголчуудын нуруун дээр бууна. Монгол хүн бүр төлнө шүү дээ. Өмнө нь бид татварынхаа хуулиар мөнгө цуглуулж, төсвөө бүрдүүлээд дотроо ярьдаг байсан. Одоо бол дэлхий нийтийн өмнө хийж буй алхам бүхэн, хэлж байгаа үг бүхэн чинь хариуцлага дагуулна, тодорхой үр дагавартай шүү гэдгийг хэлэх гэсэн юм.

Бид зөвлөмждөө УИХ-д хандан



хоёр заалт оруулсан байгаа. Нэгдүгээрт, Засгийн газрын үнэт цаасны зарцуулалт, эргэн төлөлт, тавих хяналтад шаардагдах нэмэлт эрх зүйн орчинг УИХ-ын намрын чуулганд багтаан бүрдүүл гэсэн. Өөрөөр хэлбэл, одоогийн чуулганд багтаан бүрдүүлэх ёстой. Засгийн газар, хариуцаж буй сайд нарын зүгээс энэ хуулийн төслийг оруулж ирэх хэрэгтэй. Энэ дотроо хариуцлагын асуудлыг маш тодорхой зааж өгөөрэй. Дээр нь Засгийн газрын үнэт цаасны зарцуулалт, төслийн сонголт, хэрэгжүүлэлтэд тавих хяналтыг УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, мөн үнэт цаасны үйлчилгээ, хүүгийн болон үндсэн төлбөрийг барагдуулах, түүнийг төсвийн эх үүсвэртэй уялдуулахад тавих хяналтыг УИХ-ын Төсвийн байнгын хороо хэрэгжүүлнэ гэж заасан. Хоёрдугаарт, Монгол улсын Засгийн газарт хандсан заалтууд байгаа. Засгийн газрын үнэт цаасыг арилжаалах замаар бүрдүүлсэн хөрөнгийн эх үүсвэрээс төсөл, хөтөлбөр сонгон санхүүжүүлэх асуудлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлэж бай. Хэлэлцсэн дүнгээ УИХ-ын даргад бичгээр мэдэгдэж бай гэсэн. Энэ бол УИХ-д мэдэгдэж бай гэсэн үг. Бичгээр ирсэн мэдээллийг УИХ-ын дарга УИХ-ын гишүүд, холбогдох Байнгын хороодод өгнө гэж ойлгож байгаа.

Засгийн газрын үнэт цаасыг арилжаалж бүрдүүлэх хөрөнгөөр юуг санхүүжүүлэх ёстойг тодорхой зааж өгсөн. Монгол улсын эдийн засгийн бие даасан, аюулгүй байдлыг бэхжүүлэхэд чиглэсэн, үр ашиг, эргэн төлөгдөх баталгаа бүхий дэд бүтэц, үйлдвэрлэлийн төсөл, хөтөлбөрүүдийг тэргүүн ээлжинд санхүүжүүлнэ. Юунд зарцуулж болохгүйг бас заасан. Нэгд, төсвийн алдагдлыг нөхөх, хоёрт, төсвийн урсгал зардал, тэр дундаа нийгмийн халамжийн аливаа үйлчилгээнд зарцуулж болохгүй. Ер нь УИХ-аас өмнө нь Засгийн газрын үнэт цаас, бонд гаргах тухай тогтоол гарч байсан. Түүнд бас тодорхой заалт бий. Энэ бүхэн хоорондоо уялдаж байгаа гэдгийг хэлмээр байна. Хамгийн гол заалтын нэг бол тухайн мөнгө, хөрөнгөтэй холбоотой эрсдэлийг багасгах талаарх заалт. Энэ хөрөнгөөс нэг төсөл, хөтөлбөрт хийх санхүүжилт тухайн төслийн нийт санхүүжилтийн 1/3-ээс хэтрэхгүй байна гэдгийг зааж өгсөн. Бүгдийг санхүүжүүлчихвэл алдагдал болох магадлалтай. Тиймээс энэ нь Засгийн газрын нэг ам.доллар дээр хоёр долларыг та бүхэн өөрсдөө олох ёстой гэсэн үг. Хувийн болон гадаадын хөрөнгө оруулалтаас олно. Иймээс хөрөнгө оруулалтын орчинг бид сайжруулах хэрэгтэй. Хөрөнгө оруулалт нь зөөл биш учир ямар ч эрсдэлгүй шүү дээ. Дансанд орж ирж байгаа энэ мөнгийг бол бид төлнө. Өнөөдрөөс эхлээд хүү нь бодогдож байгаа. Жилдээ 70 орчим сая ам.долларын хүү төлөх ёстой. Таван жилийн дараа 1.5 саяар гээд бодвол 500 сая ам.долларыг арван жилийн дараа тэрбум долларыг шууд нийлүүлэх ёстой. Тэгэхээр маш хурдан үр ашгаа өгөх төсөлд эрсдэлгүйгээр энэ мөнгийг зарцуулах учиртай. Үүсч болох эрсдэлийг тооцож, эрсдэлийн удирдлагын механизмыг бүрдүүлэхийн тулд бодлогын зөвлөл байгуулж ажилла. Эдийн засгийн чиглэлийн яамд /тухайлбал, Эдийн засгийн хөгжлийн яам, Сангийн яам, Уул уурхайн яам, Эрчим хүчний яам, Үйлдвэр. хөдөө аж ахуйн яам, Барилга, хот байгуулалтын яам, Зам тээврийн яам/, Монголбанк, УИХ-ын Эдийн засгийн байнгын хороо, Төсвийн байнгын хорооны удирдлага, бие даасан шинжээчдээс бүрдсэн Бодлогын зөвлөл байгуул гэсэн байгаа. Дээр нь Засгийн газар, холбогдох албан тушаалтнууд орох хэрэгтэй. Дараагийн гол гэж үзэж буй заалт бол төсөл хөтөлбөрийн сонголт ил тод, хариуцлагатай байх тухай юм. Энэ нь заасан цаг хугацаандаа хэрэгждэг, иргэний хяналт дор явагддаг байх ёстой. Засгийн газрын бодлогын залгамж чанар хадгалагдах ёстой. Дараагийн Засгийн газар сонгуулиар гарч ирээд “Энэ буруу” гэх асуудал байх ёсгүй. Нэг үгээр үүнийг төрийн хар хайрцагны бодлого гэж ойлгох хэрэгтэй. Тэр улс авсан, бид төлөхгүй гэсэн асуудал байхгүй. Заавал төлөх ёстой. Төлөхгүй бол Монгол улсын бонд дахин өөр улс, хүнд зарагдаад өөр нэгний эрхшээлд орох аюул бий. Ер нь улсынхаа нэр хүндээр дэнчин тавьж авч буй өр шүү гэдгийг хэлье. Үндэсний аюулгүй байдлын зөвлөлөөс зөвлөмждөө тодорхой хяналт тавьж ажиллах ёстой. Энд ажлын алба, нарийн бичгийн дарга гээд албан тушаалтнууд бий. Тиймээс тодорхой заалт оруулсан байгаа. Аль аль талдаа ил тод байх ёстой. Авлигын болон албан тушаалын үйлдэл, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байлгахын тулд энэ ажиллагаан дээр холбогдох хууль хяналтын байгууллагууд хяналт тавьж ажиллана. Ийм заалтыг зөвлөмжид оруулсан байгаа. Төгсгөлд нь энэ мөнгө төлөгдөнө, Монгол улс хариуцлагатай улс болох ёстой гэдгийг дахин хэлье. ■

БАЯЛГИЙН ХАРААЛ

БАЯЛГААС ХАРААТ БАЙХ НЬ ЭДИЙН ЗАСАГ, НИЙГМИЙН ХӨГЖИЛД ХАЛТАЙ



ЯАН ХАНЗЭН
/АХБ-ны Суурин төлөөлөгчийн газрын ахлах эдийн засагч/

Байгалийн баялаг ихтэй улсуудад байнга ажиглагддаг “баялгийн хараал” хэмээх үзэгдлийг Монголд тэр болгон анхаарч үздэггүй. Ядуу буурай орнуудын хувьд байгалийн баялаг нь эдийн засгаа хөгжүүлэх ховорхон боломж боловч бодит байдал дээр эсрэгээрээ байх нь олонтаа. Үүгээр бид уул уурхайд тушиглэсэн эдийн засгийн хөгжил, баялгийн удирдлагын тухай өгүүлэх цуврал нийтлэлийн эхний хэсгийг та бүхэнд хүргэж байна. Энэ нийтлэлд “баялгийн хараал”-тай холбоотой зарим гол асуудлыг хөндөхийн зэрэгцээ тухайн үзэгдэл Монголд хэрхэн нөлөөлж болох талаар авч үзсэн. Харин хоёр дахь нийтлэлд байгалийн арвин баялагтай хөгжиж буй орнуудын хувьд тохиромжтой сангийн бодлогын бүтцийг тодорхойлж, “улсын баялгийн сан”-гийн үүрэг, ач холбогдлыг тайлбарлах болно.


2008-2009 онд дэлхий нийтийг хамарсан эдийн засаг, санхүүгийн хямралыг эс тооцвол олон улсын зах зээл дээр ашигт малтмал, түүхий эдийн үнэ сүүлийн арав гаруй жилийн турш өссөөр ирсэн. 2011 оны эцсийн байдлаар хэрэглээний үнийн инфляциар засварласан эрчим хүч, суурь металлуудын бодит дундаж үнэ өмнөх 10 жилтэй харьцуулахад даруй гурав дахин өссөн нь сүүлийн 40 гаруй жилийн туршид бүртгэгдсэн хамгийн дээд түвшинд ойртож, зарим талаар давж гарсан статистик болсон байна. Олон судлаач ашигт малтмал, түүхий эдийн үнийн дээрх өсөлтийг сүүлийн 10 гаруй жилд хурдацтай хөгжиж буй улсуудын тогтвортой өсөлттэй холбон тайлбарладаг.

Хөгжиж буй орнуудын хувьд байгалийн баялаг нь эдийн засгийн хөгжлийн таатай нөхцөлийг бүрдүүлж өгдөг. Учир нь уул уурхайн салбараас олсон орлогоор дэд бүтэц, төрийн үндсэн үйлчилгээ болон боловсрол, эрүүл мэнд, бодит дэд бүтцэд хөрөнгө оруулалт хийснээр тогтвортой хөгжлийг дэмжих, ядуурлыг бууруулахад чиглэсэн нийгмийн халамжийн хөтөлбөрүүдийг санхүүжүүлэх боломжтой байдаг. Гэхдээ нөхцөл байдал үүнээс өөр байх нь олонтаа. Байгалийн баялгийн хараалын зарчмын үүднээс авч үзвэл байгалийн баялгаар хомс улс орнуудтай харьцуулахад баялаг ихтэй орнууд ихэнх тохиолдолд хурдацтай хөгжиж чаддаггүйгээс гадна хүний хөгжлийн үзүүлэлтүүдээрээ дорвитой ахиц гаргадаггүй байна. Байгалийн баялгийн хараал нь хүмүүсийн дунд тархсан аман яриа, эсвэл эдийн засагт учирсан бодит тохиолдлоор хязгаарлагдахгүй юм. Энэ бол олон улсын ихээхэн хэмжээний өгөгдөл дээр ашиглан эдийн засгийн хувьсагч ашиглан гүйцэтгэсэн статистикийн тестийн үр дүнгээр илэрсэн үзэгдэл юм. Байгалийн баялгийн арвин байдал болон нийгэм, эдийн засгийн хөгжлийн хоорондын сөрөг хамаарал сул байгаа нь байгалийн баялаг ихтэй улсуудын дунд амжилт, бүтэлгүйтлийн аль аль нь байдгийг харуулж байна. Мэдээж энэ хамаарлыг эерэг гэж үзэх үндэслэлгүй юм.

Түүнчлэн, ашигт малтмал, түүхий эдийн сүүлийн үеийн өсөлт, эдийн засгийн бодлогын ахицын улмаас байгалийн баялгаас хараат улсууд баялаг багатай орнуудыг бодвол илүү хурдацтай хөгжиж буй нь судалгаанаас харагдсан. 1980, 1990-ээд онтой харьцуулахад, байгалийн баялаг ихтэй орнуудын сүүлийн 10 жилийн эдийн засгийн дундаж өсөлт нь баялгаар хомс орнуудынхаас дээгүүр байжээ.


Байгалийн арвин баялаг нь эдийн засаг, нийгмийн хөгжилд хэрхэн сөргөөр нөлөөлөх тухай харилцан уялдаа бүхий хоёр ойлголт байдаг. Эхнийх нь богино-дунд хугацаа буюу тав хүртэлх жилийн хугацаанд хамаарах “Голланд өвчин”. Харин хоёр дахь нь таваас дээш жил буюу дундаас-урт хугацааг хамаардаг “байгалийн баялгийн хараал” хэмээх ойлголт юм. »

Нэг өдрийн орлогыг хоёр ам.долларааp тооцсон ядуурлын түвшин (нийт хүн амд ногдох хувь)



ББИ Байгалийн баялаг ихтэй
ББХ Байгалийн баялгаар хомс
БОУ Бага орлоготой улс
БДОУ Бага дунд орлоготой улс

Насанд хүрсэн хүн амын бичиг үсэгт тайлагдсан байдал (15-с дээш насныхны хувиар илэрхийлсэн)




“Голланд өвчин”


“Голланд өвчин” хэмээх ойлголт нь байгалийн баялаг ашиглалтын огцом өсөлтөөс үүдэлтэй богино-дунд хугацааны макро-эдийн засгийн сөрөг нөлөөлөл юм. Голланд өвчин нь олон хэлбэртэй боловч тогтсон нэг хэв шинжийг дагадаг. Юуны түрүүнд ашигт малтмал, түүхий эдийн үнэ тогтворгүй, байнга өсөн нэмэгдэж буйгаас шалтгаалан байгалийн баялаг ашиглалтын огцом өсөлт, түүнтэй холбоотой хөрөнгийн дотогшлох урсгал нь уян хатан ханшийн бодлоготой оронд нэрлэсэн ханш чангарах, харин тогтмол ханшийн бодлоготой орны хувьд инфляцийн хэлбэрээр валютын бодит ханшийг чангаруулдаг. Цаашилбал, өрсөлдөх чадвар болон ашигт ажиллагаа нь буурсан хөдөө аж ахуй, аж үйлдвэр зэрэг уул уурхайн бус гадаад худалдааны салбараас барилга зэрэг гадаад худалдааны бус салбарт нөөц баялаг шилждэг. Ихэнхдээ хамгийн түрүүнд хангамжтай холбоотой хүндрэл үүсдэг салбар бол барилгын салбар бөгөөд энэ нь цаашлаад дэд бүтэц, зам, тээврийн саатал, хэт ачаалал зэргийн эх үндэс болдог.

Хоёрдугаарт, валютын бодит өсөлтөөс үүдэлтэй эдийн засгийн асуудлууд хурцдах нь Засгийн газрын зардлыг их хэмжээгээр өсөхөд хүргэдэг ба улс төрийн өрсөлдөөн, дарамт шахалтын нөхцөлд энэ нь төрийн албан хаагчдын цалин, нийгмийн хангамжид зарцуулагддаг. Үүний үр дүн нь ихэнхдээ орон сууц, барилгын салбарын үнийн өсөлт, өндөр инфляци, урсгал дансны алдагдалтай хосолсон эдийн засгийн хэт халалт юм. Олон улсын зах зээл дээр ашигт малтмал, түүхий эдийн ханшийн урьдчилан таамаглах боломжгүй байдал, ойр давтамжтай үүсэх том хэлбэлзлээс шалтгаалж бусад төрлийн орлоготой харьцуулахад байгалийн баялгийн орлого нь ерөнхийдөө тодорхой бус, тогтворгүй байдаг. Баялгийн орлого хэлбэлзэл ихтэй учраас түр хугацааны огцом өссөн орлогыг зарцуулах нь бүтцийн

Хүн амын дундаж наслалт (жилээр)



Хүний хөгжлийн индекс (ХХИ) (Үзүүлэлт, 0-1 хүртэл)



Эх сурвалж: ОУВС (2012). Байгалийн баялаг ихтэй хөгжиж буй улс орнуудын макро-эдийн засгийн бодлогын бүтэц - Оршил хэсэг 1 - Хавсралт 1.



хувьд төрийн зардлын тогтворгүй өсөлт үүсгэх өндөр эрсдэлтэй байдаг. Байгалийн баялгаас хараат байхын хор хөнөөлтэй шинж чанарын нэг нь ашигт малтмал, түүхий эдийн үнийн тогтворгүй байдал гэдгийг нотлох баримт олон бий.

Валютын бодит ханшийн өсөлтөөс өрсөлдөх чадварт үзүүлэх сөрөг нөлөө, Засгийн газраас эдийн засагт зарцуулах үр ашиггүй зарлагын огцом өсөлт нь "Голланд өвчин"-ий гол шинж тэмдэг юм. "Голланд өвчин"-ий уршгаар гарч буй валютын бодит ханш ба ДНБ-ий бүтцийн өөрчлөлт нь богино болон дунд хугацааны дотоод болон гадаад тэнцэлд үзүүлж буй макро эдийн засгийн тохируулга юм. "Голланд өвчин" нь олонх тохиолдолд мөчлөг дагасан эдийн засгийн (мөнгөний болон сангийн) бодлогын улмаас гарахын зэрэгцээ улам бэхжиж байдаг. Эдийн засаг өндөр өсөлттэй үед тэлэлттэй, харин эдийн засгийн уналтын үед үүний эсрэгээр байх тохиолдолд сангийн бодлого нь мөчлөг дагасан байна гэж үздэг. Эдийн засгийн бодлогын үндсэн зорилго нь хэлбэлзлийг бага түвшинд барих явдал юм. Харин мөчлөг дагасан аливаа бодлого эсрэгээр түүний сөрөг нөлөөг өсөхөд хүргэдэг байна. Голланд өвчний эмчилгээ нь ихэнхдээ төсвийн нэгдсэн байдлыг хангахад чиглэгдсэн хүнд, урт хугацааны үйл явц, нийгмийн хамгаалал, хөдөлмөрийн зах зээлийн шинэчлэлийг шаарддаг. Төсвийн урсгал зардлыг бууруулснаар нийгмийн хүндрэлтэй асуудлууд үүсдэг бол хөрөнгө оруулалтын зардлыг бууруулах нь үр ашигтай хэрэгжих боломжтой төслүүдийг орхигдоход хүргэж болзошгүй байдаг.

Байгалийн баялгийн хараал бол өргөн хүрээтэй ойлголт

Байгалийн баялгийн хараал гэдэг нь гаж тогтолцоо бүхий улс төрийн эдийн засаг, хэврэг улс төр, эдийн засгийн байгууламж болон популист улс төрийн эдийн засаг; "хялбар замаар олдсон баялаг", нийгмийн тогтворгүй байдал зэрэг байгалийн баялаг ихтэй орнуудын хувьд байнга шахам учирдаг эдийн засаг, нийгмийн хөгжлийн доголдолд хамаатай ойлголт юм. Уул уурхайн салбар нь харьцангуй цөөн тооны ажлын байр бий болгож, байгалийн баялгаас олсон орлого нь хүн амын бага хэсэгт ногддог учраас байгалийн баялгаас хараат байх нь ихэнх тохиолдолд эдийн засгийн тэнцвэртэй бус байдал бий болгодог. Орлогын тэгш бус байдал өндөр түвшинд хүрч, цөөн тооны хэсэгт баялгийн төвлөрөл үүссэнээр авьяас чадвартай хүмүүсийн хувьд боловсрол ба капиталыг хүртэх боломж багасч, эсвэл бүрмөсөн хаагддаг учраас энэ нь эргээд хөгжлийн хэтийн төлөвт сөргөөр нөлөөлдөг. Түүнчлэн орлогын тэгш

бус байдлын түвшин нэмэгдэх нь нийгмийн дотоод нэгдэл, нягтралд сөргөөр нөлөөлж, иргэдийн дотор үймээн самуун үүсэх магадлалыг нэмэгдүүлдэг.

Үүний нэг тайлбар нь байгалийн баялаг нь түүнээс олох орлогын төлөөх эрүүл бус улс төрийн өрсөлдөөнийг нийгмийн элитүүдийн дунд бий болгодог учраас эдийн засаг, улс төрийн байгууламжууд сул дорой болоход хүрдэгт оршино. Байгалийн нөөц багатай эдийн засгуудын хувьд зөвхөн капиталын хуримтлал, зах зээлийн хөгжлөөр дамжин эдийн засгийн өсөлт, баялгийн хуримтлал үүсгэдэг. Ийм төрлийн эдийн засгийн хөгжил нь төрийн үйлчилгээний үр нөлөөтэй хүртээмж, өмчлөх эрхийн баталгаа, эрх зүйн хэм хэмжээ зэргийг зах зээлийн жамаар хөгжүүлэх чадамжтай болсон, эдийн засгийн таатай нөхцөлд хүрэх бүх боломжийг хөхиүлэн дэмждэг орчинг бүрдүүлэх чадвартай Засгийн газраас хамаардаг. Иймээс аж үйлдвэрлэлийн салбарыг уул уурхай, олборлолтын салбараас эсрэгээр, урт удаан хугацааны өсөлт хөгжилд шаардлагатай эерэг гадаад орчин бүрдүүлдэг гэж үздэг.

Голланд өвчин Монголд газар авчээ

Монгол улсад уул уурхайн салбар хөгжлийн анхан шатандаа байгаа боловч Голланд өвчний хэд хэдэн шинж тэмдэг илэрч байна. Монголын эдийн засаг 2011 онд 17.3 хувиар өссөнөөс гадна урьдчилсан тооцоогоор цаашдаа энэ үзүүлэлт хоёр оронтой тоотой байна гэж таамаглаж байгаа. Тухайлбал уул уурхайн хөрөнгө оруулалт, үйлдвэрлэлийн гарцтай холбоотойгоор 2012 онд эдийн засгийн өсөлт 11, 2013 онд 12 хувь байна гэж тооцоолжээ. Оюутолгойн зэс, алтны уурхайн олборлолт ирэх оны эхээр эхлэх, Тавантолгойн нүүрсний уурхайн өргөтгөл анхан шатандаа явж байгаа зэрэгтэй холбоотойгоор эдийн засгийн дунд хугацааны хэтийн төлөв таатай байна гэж үзэж байна. Энэ оны хувьд уул, уурхайн салбар экспортын 90 гаруй, төсвийн орлогын 30 орчим, ДНБ-ий 20 хувийг бүрдүүлсэн бол ажил олголтын хувьд ердөө 1.6 хувийг эзэлсэн байна. Энэ онд гадаадын шууд хөрөнгө оруулалт хоёр дахин нэмэгдэж 3.7 тэрбум ам.долларт хүрсэн нь ДНБ-ий 43.6 хувьтай тэнцэж байна. Зарим судалгаанд шинжээчид ирэх 20 гаруй жилийн турш Монгол улс дэлхийн хурдацтай хөгжиж буй орнуудын нэг байна гэж үзэж байна.

Сангийн бодлого энэ онд ч мөн мөчлөг дагасан шинжтэй хэвээр байв. 2011 онд 55.6 хувиар огцом өссөн Засгийн газрын зардал 2012 оны есдүгээр сард өмнөх оны мөн үеийнхээс 38 хувиар өндөр байсан. Тэгвэл орлогын өсөлт жигд хурдаа алдаж, зөвхөн 10.9 хувиар нэмэгдсэн байна. Энэ нь өнгөрсөн оны мөн үед 236.7 төгрөгийн ашигтай байсан төсвийн тэнцэл 535.5 тэрбум төгрөгийн алдагдалтай болоход хүргэсэн. Үүний зэрэгцээ уул уурхайн салбарыг байгаль орчинд ээлтэйгээр хөгжүүлэх, эдийн засгийг төрөлжүүлэх, хүн амын хувьд эрүүл мэнд, боловсрол, орон сууц, усан хангамж, ариун цэвэр-эрүүл ахуй зэрэг наад захын үйлчилгээ хүртэх боломжийг нэмэгдүүлэхийн тулд төрөөс дэд бүтцэд дорвитой хөрөнгө оруулалт хийх шаардлага үүсээд байна. Гэвч Монгол улсын өнөөгийн ДНБ-тэй харьцуулбал дээр дурдсан зайлшгүй хөрөнгө оруулалтыг хийхэд шаардлагатай санхүүжилтийн хэмжээ асар өндөр байна.

Инфляци нэмэгдсээр энэ оны наймдугаар сарын байдлаар 14.8 хувьд хүрчээ. Хэт тэлэлттэй сангийн бодлогын улмаас гаднаас ирэх сөрөг нөлөөнд эдийн засгийн байдал улам эмзэг болжээ. Нэг томоохон эрсдэл бол БНХАУ-ын эдийн засгийн өсөлтийн хурд мэдэгдэхүйц удааширч, олон улсын зах зээл дээрх ашигт малтмал, түүхий эдийн үнэ мэдэгдэхүйц унаж байгаа явдал юм. Эдгээр нөхцөл байдал нь Монгол улсын төрийн санхүү, урсгал дансны байдалд ихээхэн дарамт учруулж, эдийн засагт ноцтойгоор нөлөөлөхөөр байна.

Байгалийн баялгийн хараалыг ерөөл болгож хувиргасан туршлага дэлхийд цөөнгүй бий


Ашигт малтмалын экспортоос үлэмж хамааралтай байж, мөчлөг дагасан макро эдийн засгийн бодлого хэрэгжүүлсэн зэргээс шалтгаалан, 2008-2009 оны дэлхий эдийн засаг, санхүүгийн хямралын нөлөөнд хамгийн их өртсөн орнуудын тоонд Монгол улс багтсан юм. Сүүлийн жилүүдээс харахад Монголд орлогын тэгш бус байдал улам бүр нэмэгдэх хандлага илт ажиглагдаж байна.

Байгалийн баялгийн хараал нь зайлсхийх боломжгүй зүйл биш бөгөөд түүнийг байгалийн баялаг ихтэй улс бүрийг эдийн засгийн доройтолд зайлшгүй оруулдаг зүй тогтол гэж тайлбарлах нь буруу юм. Байгалийн баялаг ихтэй зарим орны эдийн засаг буурай хөгжилтэй байхад нөгөө хэсэг нь өндөр түвшинд хөгжсөн байдаг. Тухайлбал, Норвеги (газрын тос), Ботсвана (алмааз), Чили (зэс) зэрэг орнууд байгалийн баялгаа гайхамшигтай ашиглан өндөр хөгжилд хүрсэн байхад ижил төрлийн баялаг бүхий Нигер, Боливи, Конго зэрэг улсууд эдийн засгийн хувьд ихэд доройтсон байх жишээтэй. Эндээс харахад байгалийн баялгийн хараалыг байгалийн баялгийн ерөөл болгож хувиргахын тулд байгалийн нөөцөөс хараат аливаа улс ямар бодлого хэрэгжүүлэх вэ гэдэгт гол асуудал урган гарч ирж байна. Эдийн засгийн бодлогын үндсэн асуудал нь уул уурхайгаас орж ирэх асар их хэмжээний төсвийн орлогыг зохистой бодлогоор түүний дотор “улсын баялгийн сан” байгуулах замаар захиран зарцуулах явдал юм. ■

УИХ-ЫН ГИШҮҮДИЙН ХАЯГААР

АМЬДРАЛ БА ЭЛЭГНИЙ ӨВЧИН

...Эмч нар халаглаж байна. Тэд “Бид нэг ч болов иргэнийхээ амь насыг аваръя гээд улаан гараараа зүтгээд байдаг, харин төр нь ойлгохгүй, дэмжихгүй болохоор үнэхээрийн гутрах юм” хэмээн ярьсан...



100.000 хүн амд ногдох элэгний өвчлөл /тоогоор/

Манай улс элэгний өвчлөлөөр дэлхийн улсуудыг тэргүүлэх хэмжээнд явж байна. Таван хүн тутмын нэг нь элэгний ямар нэг өөрчлөлт, вирустэй байдаг гэнэ. Бохирын шар өвчин газар авсныг бид мэднэ. Сургууль, цэцэрлэгийг хаах хэмжээнд хүрдэг шүү дээ. Томчууд шарлах явдал нь ихсэж байгааг эмч нар толгой сэгсрэн тэмдэглэх. Энэ бол Монголын эмгэнэл гэдгийг цагаан нөмрөгтнүүд ярьдаг.

Элэгний хатуурал, хавдартай өвчтөнүүдийн тоо улам л нэмэгдэж, цаашдаа ч өсөн нэмэгдэх болно гэж эмч нар үзэж байна. Учир нь, монголчууд өөх, тостой хоол идэж, архи их уудаг нь элэгний өвчлөлийг ихэсгэх том шалтгаан аж. Элэгний өвчлөл нь маш удаан явцтай бөгөөд өвдөж зовоодоггүй учраас хүмүүс тоохгүй хаячихдаг нь хавдар, хатуурлыг үүсгэх гол нөхцөл болж өгдөг байна. Элэгний өвчин эцсийн шатанд тулахаараа амь насаа бурханд л даатгахаас өөр аргагүйд хүрдэг аюултай аж.

Монголын эмч нар энэхүү өвчний уг үндсийг сайн мэдэх юм болохоор элэгний өвчинтэй тэмцэхээр шийджээ. Элэг эмчилгээгүй өвчин, бид яаж ч чадахгүй хэмээн гараа хумхин зүгээр суухгүйгээр элэг шилжүүлэх мэс заслыг эх орондоо нэвтрүүлэх том ажлыг зоригтойгоор эхлүүлсэн билээ. Тэд энэ өвчнөөр олон хүн нас барж, олон хүүхэд өнчрөн хоцорч байгааг хараад элэг шилжүүлэх хагалгааг Монгол улс хийх хараахан болоогүй гэлгүйгээр сэтгэл нэгдэн ажиллаж байна. Энэхүү өндөр технологийг нэвтрүүлэх эхний үед зарим эмч, эрдэмтэн доктор манай улс 15-20 жилийн дараа элэг шилжүүлэх хагалгааг хийж эхэлнэ хэмээн эсэргүүцэж байж.

Ер нь аливаа улсын эрүүл мэндийн шинжлэх ухааны хөгжлийг элэг шилжүүлэн суулгах мэс засал хийдэг эсэхээр нь тодорхойлдог байна. Тэгвэл Монгол энэхүү өндөр технологийг нэвтрүүлсэн 46 дахь орноор бүртгэгджээ. Бахархууштай хэрэг биш гэж үү? Монгол улсын эрүүл мэндийн шинжлэх ухааны түүхэн том ололт энэ юм.

Өнөөдөр Монголын элэг шилжүүлэх үндэсний багийнхан БНСУ-ын АСАН эмнэлгийн эмч нартай хамтран долоон хүнд элэг шилжүүлэн суулгах хагалгааг амжилттай хийгээд байна. Цөөхөн хүн амтай улсад долоон хүний амь насыг аварч, шинэ амьдрал бэлэглэнэ гэдэг том гавьяа.

Клиникийн төв нэгдүгээр эмнэлэг дээр элэг шилжүүлэх хагалгаанд орохоор бүртгүүлсэн хүмүүсийн тоо 50 гарсан байна лээ. Үүнээс гадна олон иргэн хилийн чанадыг зорьж байна. Дээр нь элэгний хавдар нь эцсийн шатандаа орсон өвчтөнүүд хорвоогийн мөнх бусыг хэзээ үзэхээ хүлээн гэртээ хэвтэнэ. Элэгний өвчлөлтэй залуу үе ч ирээдүйд тулгарах хүндрэлдээ санаа зовон ажиллаж байна.

Элэгний өвчинтэй тэмцэж, элэг шилжүүлэх мэс заслыг хөгжүүлэхэд төр, засгийн үүрэг оролцоо, дэмжлэг хамгийн чухал байдаг аж. Үүнийг монгол эмч, мэргэжилтнүүд ярьсаар байгаа. Ялангуяа ард иргэдийн ихэнх нь элэгний ямар нэг өвчинтэй манай

улсын хувьд төрөөс эрүүл мэндийн нэгдсэн бодлого, хөтөлбөрөөр системтэйгээр дэмжиж өгөх ёстой. Түүнээс хэдэн эмч сэтгэл зүрхээрээ хэчнээн зүтгэж тэмцээд энэ ажил, санаачилга хэр хол явах вэ. Төрөөс өнгөрсөн жил 600 сая төгрөг олгожээ. Төр, засгаас дэмжиж буйн илрэл. Сайшаалтай хэрэг. Гэхдээ дээрх мөнгө бараг нэг л аппаратных нь үнэ болов уу. Элэг шилжүүлэн суулгах үйл ажиллагаа нь өөрөө өндөр технологи шаарддаг тул сүүлийн үеийн багаж хэрэгслүүдийг ашиглах ёстой. Солонгосчууд техник хэрэгслээ бүгдийг нь авч ирж хагалгаагаа хийчихээд буцахдаа аваад явдаг байна. Тийм л үнэ цэнэтэй багажууд аж.

Элэг шилжүүлэх багийнхан ирэх оны төсөвт хоёр орчим тэрбум төгрөгийг суулгаж өгөхийг хүсэж, холбогдох байгууллагуудад ханджээ. Энэ мөнгөөр зарим дутагдалтай багаж, хэрэгслийг худалдан авахын тулд шүү дээ. Гэтэл УИХ-ын Төсвийн байнгын хороон дээр ирээд энэхүү мөн хасагдчихсан байна. Ер нь дотоодын эмнэлгүүдээр дундаас доош орлоготой хүмүүс л үйлчлүүлдэг тухай эмч нар ярьдаг. Тэгэхээр эмнэлгийнхээ байр байдал, өвчтөнүүдийн асуудлыг ойлгохгүй дээд зиндааны эрхэм гишүүд элэгний өвчинтэй тэмцэхэд яаж сэтгэлээсээ хандах билээ. Гэхдээ гишүүдийг өнөөдрийг бус ирээдүйгээ бодоод энэ мөнгө ямар чухлыг ойлгохыг хичээхгүй дээ хэмээн харамсах сэтгэл төрсөн.

Элэг шилжүүлэн суулгах үндэсний багийнхны ирэх жилийн төлөвлөгөөг эрхэм гишүүдийн шийдвэр талаар болгож байна гэсэн үг. Энэхүү мэс засал нь хууль хэлэлцдэг шиг асуудал биш юм. Эмч мэргэжилтнүүд тасралтгүйгээр явж, дадлагажиж суралцдаг процесс аж.

Эмч нар халаглаж байна. Тэд “Бид нэг ч болов иргэнийхээ амь насыг аваръя гээд улаан гараараа зүтгээд байдаг, харин төр нь ойлгохгүй, дэмжихгүй болохоор үнэхээрийн гутрах юм” хэмээн ярьсан. Уг нь шинэчлэлийн Засгийн газар ядахдаа элэг шилжүүлэх үйл ажиллагааг хэвийн хэмжээнд нь ажиллахад анхаарлаа хандуулбал дөрвөн жилийн дараа ард түмэнд тайлангаа тавихад хамгийн их очков авах үзүүлэлт нь байхсан.

Эдийн засаг хөгжиж байна, бизнес хөнгөвчлөгдөх жил гээд л ярих, шоудах өрөвдөлтэй жүжгийн цаана цөөхөн ард иргэд нь улам л ядуурч, өвчин зовлонд баригдаж нэрвэгдэн байгааг хэлмээр байна. Өвчтэй иргэдтэй улсын эдийн засаг өвчлөлгүйгээр цэвэр ариунаар хөгжиж чадах уу. Тийм учраас “Mongolian Economy” сэтгүүл энэ удаагийн дугаартаа эдийн засгийг хөгжүүлэхийн тулд эрүүл иргэдтэй байх зорилгоор онцлох нийтлэлүүдээрээ элэгний асуудлыг хөндлөө. ■

АСУУДАЛ

ТЭНГЭР, ГАЗАР ШИГ ЯЛГААТАЙ МОНГОЛ, СОЛОНГОСЫН эмнэлгүүд

Д.Дөл

...Солонгос эмч, сувилагч нарын хүмүүстэй инээмсэглэн харилцах нь үнэхээрийн сайхан. Тэд хөмсөг зангидахыг лав мэддэггүй байх аа...

Би ингэж бодлоо л доо. Үзэж харсан, ойлгосон зүйлээ уншигчтайгаа сэтгүүлчийнхээ хувьд хуваалцъя гэж. Гэхдээ энэ нь эдийн засаг, бизнесийн сэдэв биш. Амьдралд ойрхон, ард иргэдийн амь насыг хамгаалан сахих үүрэгтэй эрүүл мэндийн салбарын тухай юм. Монголын эрүүл мэндийн салбарт шинэчлэл хэрэгтэй, гэхдээ үндсээр нь өөрчилж байж амжилтад хүрнэ гэж ярьдгийн учир утгыг ойлгосон юм. Хүний амьдралд юу эс тохиолдох билээ дээ. Ойр дотны хүнд маань “ирсэн” аюулт өвчний улмаас миний бие найман сар гаруйн хугацаанд Монгол, Солонгосын эмнэлгээр явлаа. Бодит үнэнийг нэмж хасалгүйгээр бусадтай хуваалцах нь сэтгүүлчийн үүрэг юм.

Монголын эмнэлэг

Сүүлийн үед монголчууд эмчлүүлж, шинжлүүлэхээр хилийн чанадыг олноор зорьдог болсон. ▸▸

Яагаад? Хариулт нь ойлгомжтой. Үнэндээ манай эмнэлгүүд болохгүй болоод л гадагш явахаас өөр аргагүйд хүрч байгаа. Түүнээс үндэсний эмнэлэг, эмч нар сайн бол иргэд илүү зардал гаргаж өөр орныг зорихгүй нь лав. Монголын эмнэлгүүд яагаад болохгүй байна вэ?

Нэгдүгээрт, төрийн нэгдсэн бодлого дутагдаж, үгүйлэгдэж байна. Системийг бүхлээр нь харах, шинэчлэх өөрчлөх ухаан, бас сэтгэл алга.Том том зүйл ярьж гарч ирээд салбарын олон төсөл, хөтөлбөрөөс хожих амин хувийн ашгаа бодоод өнөө маргаашийг өнгөрөөсөн байдлаар ажиллаж, цаг авах нь өнөөгийн төр, засгийн үнэн нүүр царай. Энд монгол эмчийн ярьсан нэгэн зүйлийг би эрүүл мэндийн сэдэв хөндөх бүртээ л иш татдаг болсон.

“Эмч нар маш гутранги үзэлтэй болсон. Манай төр, засгийн удирдлага, түшээд эрүүл мэндийн салбарынхаа байр байдлыг мэдсээр байж юу ч хийхийг хүсдэггүй. Яагаад гэвэл тэдний цаашдын карьерт боловсрол мэдлэггүй, өвчтэй иргэд олон байх нь хэрэгтэй. Өвчтэй иргэдийн тоо олшрох тусам эрүүл мэндийн салбараас унагах мөнгө тэдэнд ахиу байна” гэсэн юм. Эндээс төр, засгийн эрүүл мэндийн салбартаа анхаарах бодлогын үр дүн харагдана.

Хоёрдугаарт, технологи, менежмент дутагдаж байна. Хуучирч элэгдсэн техниктэй Монголын цагаан нөмрөгтнүүд юу хийж чадах вэ. Одоо ихэнх багаж хэрэгслийнх нь сэлбэгийг үйлдвэрлэхээ больж, засварлах газар ч олдохгүй байгаа гэнэ. Манай улс өнөөдөр орчин үеийн техник бүхий улсын шинжилгээний том лабораторигүй л байна шүү дээ. Тиймээс эмнэлгүүдийн шинжилгээний хариуд иргэд хэр итгэдэг юм бол. Лав л Өмнөд Солонгосын эмнэлэг, эмч нар манай шинжилгээний хариуг нэг нүдээрээ ч хардаггүй юм билээ. Монголын эмнэлгүүдийн шинжилгээнд бид итгэдэггүй ээ гэж шууд хэлэх. Тэгэхээр бид юунд итгээд байна вэ. Хөрөнгө мөнгөний боломжтой хүмүүс бусад улс орныг зорьж, баталгаат найдвартай газар эрүүл мэндээ



үзүүлэх нь зөв л болж таарч байна. Хүнд эрүүл мэнддээ анхаарахаас өөр юу чухал гэж.

Менежментийн хувьд бүр учир дутагдалтай. Социализмын үеийн үнэр манай эмнэлгүүдээс ханхалсан хэвээр. Эмнэлгийн салбарын менежмент гэж тусдаа зүйл байдаг юм байна. Манай томоохон эмнэлгийн нэгэн эмч надаас нэг зүйл бүтээж өгөхийг хүссэн юм. Би сонсоод эхлээд гайхсан, дараа нь өрөвдсөн. Тэр эмч ”Манай эмнэлгийн сэхээн амьдруулах тасгийн өмнөх хүнд өвчтөнүүд хэвтдэг тасагт агааржуулагч хэрэгтэй байна аа. Сэтгүүлч хүн байна, олоод өгч тусалбал сайн байна” гэсэн юм.

Монгол улсын хамгийн том эмнэлгүүд өвчтөнүүдийнхээ өрөөнд агааржуулагч тавьж чадахгүй хэмжээнд байна гэж үү. Хүнд өвчтөн хэвтдэг тэр жижиг өрөөнд дөрвөн хүн хэвтэнэ. Дөрвөн хүний сахиурууд бас хамт байна. Ихэнхдээ цус алдсан, элэгний өвчин нь хүндэрсэн хүмүүс хэвтдэг болохоор цус үнэртэх юу ч биш. Агаарын солилцоо байхгүй. Сахиурууд нь өвчтөнийхөө дэргэд шалан дээр нуруугаа амраах болно. Түүнчлэн сэхээн амьдруулах тасагт ойр дотны хүнээ хүлээн коридорт зогсох хүмүүст суух сандал үл олдоно. Энэ мэтчилэн зовлон олныг тоочиж болох.

Гуравдугаарт, эмч, сувилагч ажилтнуудын ур чадвар, харилцааны соёл. Ур чадварын тухайд монгол эмч нарыг сайн, олон улсын түвшинд хүрсэн, сүүлийн үеийн техник хэрэгсэл нь байвал стандартын эмчилгээ сувилгаа, хагалгааг хийнэ гэдэг. Үнэний ортой. Гэхдээ л мэддэгээсээ илүү мэдэмхийрдэг, нэр төрөө боддог, дээдсийг дагаж гүйж, доодсыг нүд үзүүрлэн хардаг байдал эрүүл мэндийн салбарт газар авчээ.

Өөр нэг зүйл нь бараг л эмч бүр хувьдаа эмнэлэгтэй болох нь. Хаа сайгүй байдаг баар, цэнгээний газар шиг подволд ч эмнэлэг байгуулагдах болов. Энэ Монголын эмгэнэл үү, эсвэл эрүүл мэндийн салбарын шинэчлэл үү.

Харилцааны соёлын талд манай эрүүл мэндийн ажилтнууд бараг л “0” дүн авна даа. Хялалзаж цэхэлзсэн, уурлаж уцаарласан, их зан гаргасан хүмүүс л явдаг шүү дээ. Өвчтөнүүдийнхээ төлөө үнэн сэтгэлээсээ зовж, зөөлөн эелдэг харьцаж, ар гэрийнхэнд ч асуудлыг сайхан тайлбарлаж өгдөг эмч, сувилагчид бий л дээ. Гэхдээ учир дутагдалтай. Хүмүүс эмнэлэг рүү хандахдаа таньдаг эмч, сувилагч байна уу л гэдэг болсныг нуух юун. Ерөнхийдөө Монголын эрүүл мэндийн манаанд зогсох мэргэжилтнүүдийн төлөөллийн ерөнхий дүр төрх нь ийм.

Тийм учраас л Монголын эрүүл

12.000

Монголд нэг жилийн дотор элэгний өвчнөөр өвчилдөг хүний тоо

нь жинхэнэ үзэж байж төгсгөснөөр эрүүл мэндийн салбарт чадварлаг боловсон хүчин төрүүлдэг гэнэ. Томоохон их сургуулиуд нь дэргэдээ эмнэлэгтэй учраас оюутнуудын хувьд дадлага хийх газар олдохгүй гэх асуудалгүй. Эмнэлгүүд нь Сургуулиа төгссөн болон залуу эмч нараа эмнэлгийнхээ хамгийн сайн эмч нарыг дагалдуулан суралцуулах суралцах замаар ирээдүйн халаагаа бэлтгэдэг. Нэг эмчийг 4-5 туслах эмч

Тэгвэл манай улсын төв эмнэлгүүдэд сувилагч нар тэвэр дүүрэн цаас барьчихсан явж харагддаг.

Солонгос эмч, сувилагч нарын хүмүүстэй инээмсэглэн харилцах нь үнэхээрийн сайхан. Тэд лав хөмсөг зангидахыг мэддэггүй байх аа. Өвчтөнөө гараас нь өргөн өрөөнд нь оруулна. Тэд хүмүүсээс уучлалт гуйж чаддаг. Алдаа гаргасан л бол өвчтөнөөс, ар гэрийнхнээс үнэн сэтгэлээсээ уучлал гуйна. Бас



БНСУ-ын Анам эмнэлэг

мэндийн салбар уг үндсээрээ, системээрээ шинэчлэгдэх цаг болжээ.

Солонгосын эмнэлэг

БНСУ-ын эмнэлгүүд хүний төлөө бүхнээ зориулж ажилладаг юм байна. Тэнд хүнд суртал, уур уцаартай байдал огтхон ч алга. Ажилтнууд өөр өөрсдийнхөө үүргийг ягштал биелүүлж ажиллана. Эмч нарын ур чадвар, харилцааны соёл гайхалтай. Өвчтөн болон ар гэрийнхэнтэй нь ээлдэг зөөлөн инээмсэглэн харилцах юм. Эмч нарын хувьд нэг л чиглэлээрээ мэргэшээд өөрөөр хэлбэл, бөөрний эмч бол энэ л чиглэлээрээ дагнан ажиллаж, гартаа бүрэн оруулж авдаг.

Тус орны Анагаахын сургууль маш чанга. Оюутнуудынхаа үйлийг байнга дагалдан ажиллах юм билээ.

Корэй их сургуулийн харьяа Анам эмнэлгийн үүдийг олон хоног сахиж суухдаа эмч, сувилагч нар нь амардаг юм болов уу гэж бодож билээ. Байнгын л ажиллаж харагдах. Амралтын өдрүүдийн үүрээр ч өвчтөнөө эргээд л явах. 04.00 цагт ч эмч нар өрөөндөө байж л байна.

Сувилагч нар нь байнгын гүйлдээстэй. Өвчтөнүүдээ эргэж тойроод л даралт, халууныг нь 30 минут тутамд үзэж эмийг нь өгнө, бусад цагт компьютерийн араас салахгүй. Юу хийдгийг нь сонирхвол шинжилгээ үзлэгийн хариу, эмийн тун, жагсаалт, өвчтөний биеийн байдлын талаарх мэдээллээ компьютерт оруулдаг юм байна. Тэрийг нь сүлжээгээр эмч нь хүлээн авч үзээд эмчилгээг нь хэлж өгдөг.

талархаж чаддаг. “Манай өвчтөний төлөө их явсан та бүхэнд талархлаа” гэж эмчийн туслах бидэнд хэлж билээ. Тэгэхэд бид их гайхсан. Монголд бол та нар хүнийхээ төлөө гүйхгүй яах юм гэж хэлээд загнах байсан даа хэмээн өөрийн эрхгүй бодогдсон. Сэхээн амьдруулах тасгийнх нь үүдэнд өвчтөнүүдийн сахиуруудад зориулсан сандал хангалттай бий. Мөн тэднийг шөнөөр амрах өрөөг ч тусгайлан бий болгожээ. Тэрхүү өрөө нь зурагт, хөргөгч, хөнжил, дэртэй. Ер нь эмнэлгийн бүх зүйл өвчтөн, хүний төлөө зориулагджээ.

Ийм л эрүүл мэндийн систем БНСУ-д үйлчилж байна. Энэ нь тус улсын Засгийн газраас эрүүл мэндийн салбараа түлхүү анхаарч дэмжсэний ач гэнэ. 20-иод жилийн өмнө энэ оронд элэгний өвчлөл манайх шиг л байсан гэнэ.

Өнөөдөр бага насны хүүхдийн шарлах өвчин байхгүй болж, элэгний хавдар, хатуурал эрс багассан, мөн элэг шилжүүлэх мэс заслыг дэлхийд тэргүүлэх хэмжээнд хийх болсон нь төрийн зөв дэмжлэг, эрүүл мэндийн оновчтой бодлого, үүрэг хариуцлагаа гүнээ ухамсарласан эмч, ажилтнуудын чин сэтгэлтэй холбоотой" хэмээн Анам эмнэлгийн элэгний эмч Ким Дүн Шиг ярьсан юм. Тэрбээр "Манай төрөөс ард иргэдээ ихэд хайрлан халамжилдаг" гэлээ. Солонгос орны бүх иргэн эрүүл мэндийн даатгалд хамрагдсан, хорт хавдартай хүмүүс нийт зардлынхаа таван хувийг л төлөөд бүрэн эмчилгээ авдаг аж. Төр, засгаас нь өвчтөн, иргэдээ халамжлах, эмчлүүлэхэд шаардлагатай зардалд гар татдаггүй гэсэн үг. Тухайлбал, элэг шилжүүлэх хагалгааны нийт зардал солонгос иргэний хувьд 30 сая төгрөг бол гадаадын хүмүүс доод тал нь 100 сая төгрөгөөр хийлгүүлэх боломжтой аж.

Дээрээс нь иргэдээ өвчнөөс урьдчилан сэргийлэх сурталчилгаа, мэдээллийг хангалттай хийдэг тул хүмүүс нь өвдөхгүйн төлөө тэмцдэг. Хоол, ундаа маш сайн зохицуулж иддэг, дасгал хөдөлгөөн их хийдэг байна. Иргэддээ хотын төвөөр гүйж, дасгал хийх зориулалт бүхий замыг тусгайлан засаж өгчээ. Хүүхдүүдэд цэцэрлэгийн наснаас нь эрүүл мэндийн хичээл зааж эхэлдэг учир солонгосчууд багаасаа өвчний талаар бүрэн ойлголттой, өвдөхгүйн төлөөх арга замуудаа сайн мэддэг болж өсдөг байна.


Эцэст нь, Төрийн түшээдээс ирээдүйгээ бодож, алсыг хараад эрүүл мэндийн салбарыг эрс шинэчлэх төлөвлөгөө боловсруулаад, сэтгэл гарган ажиллаасай хэмээн хүснэм. MCS компанийг шинэ эмнэлэг барьж, Анам эмнэлэгтэй хамтран ажиллах гэж байгаа тухай сонссон. Тэрхүү шинэ эмнэлэгт ажиллах олон эмч сувилагч, ажилтан Анам эмнэлэг дээр дадлага, туршлага хийж байна лээ. Тус эмнэлгийн дайны үйлчилгээ үзүүлэхүйц эмнэлэг Монголд нээгдвэл олон иргэн баярлах байх. Өрсөлдөөн нэмэгдэнэ, тэр хэрээр энэ салбарын хөгжил дээшлэх болов уу. ■

МЭРГЭЖЛИЙН ХҮНИЙ ҮГ

"БУРХАН" ЭМЧ

Д.БОЛОР

...Ажилдаа дуртай, үнэнч, хичээнгүй сэтгэл зүтгэл маань эцсийн эцэст үхлийн ирмэгт буй өвчтөнийг авардаг юм даа. Тэдэнд амь нас бэлэглэсний дараа л сэтгэлийн таашаал, баяр баяслыг авч, мэргэжлээрээ бахархаж, эмч гэдгээ мэдэрдэг...



Түүнийг монголчууд "Бурхан" эмч гэдэг юм билээ. Эгэлгүй хорвоод ээнэгшин амьдрах боломжийг хүмүүст дахин олгодог болохоор ийн хүндлэн нэрийдэж. Амьд явна гэдэг алтан аяганаас ус уухтай адил хэмээдэг. Тэрхүү алтан аяга нь бидэнд тэр бүр олдоод байдаг бил үү. Хэлж биш хийсэж ирсэн өвчнийг анагааж, амьд явах боломж олгодог хүмүүс бол эмч нар. Энэ удаагийн ярилцлагын эзэн "Бурхан" эмч бол Солонгос хүн. Тэрбээр БНСУ-ын хоёрт эрэмблэгддэг Корэй Их сургуулийн Анам эмнэлгийн Эрхтэн шилжүүлэх төвийн дарга, элэгний эмчээр ажилладаг. Сүүлийн нэг жилийн хугацаанд элэгний донортой нийлээд 10 гаруй монгол хүнд элэг шилжүүлэх хагалгааг амжилттай хийж, амьдрал бэлэглэсэн ачтан.

Түүний нэр нь Ким Донг-Сик. Энэ эмчийн өвчтөнүүдтэйгээ харьцах харилцаа, тэднийгээ өрөвдөх сэтгэл, мэргэжлийн ур чадвар, өвөртөө итгэх итгэл, багаа удирдах ур ухаан, эрч хүчийг хараад сэтгүүлчийнхээ хувьд бахадсан юм. Түүнийг Солонгос орны нийт эмч нарын төлөөлөл гэж ойлгож байна.

Ким Донг-Сик эмч байнгын л 4-5 туслах эмчийн хамт шөнөөр, амралтын өдрүүдээр ч өвчтөнүүдээ эргэж явж харагдана. Ким Донг-Сик профессор Солонгосын АСАН эмнэлэгт, мөн АНУ-д мэргэжлээрээ ажиллаж байгаад өнөөдөр Анам эмнэлэгт урилгаар ажиллаж байгаа аж. Ингээд түүнтэй хийсэн ярилцлагаа хүргэе. ▸▸

-Таныг монгол хүмүүст үнэн сэтгэлээсээ хандаж, олон хүнд амьдрал бэлэглэж байгааг харахад бахархах сэтгэл төрж байна. Эмч хүн ямар байх ёстой вэ гэсэн асуултаар ярилцлагаа эхлэе.

-Хамгийн түрүүнд өвчтөнүүдээ хайрлах сэтгэлтэй байх ёстой. Бас тэднийг ойлгох нь их чухал. Мөн эрч хүч, хурдтай байж үхэл амьдралын зааг дээр байгаа хүмүүсийг авардаг. Мэс заслын тэр дундаа элэг шилжүүлэх мэс заслын эмчид хувийн амьдралдаа зарцуулах цаг маш хомс, бараг л байхгүй гэхэд болно. Мэргэжлийн хувьд мөнгө олохын төлөө ажилладаг ажил биш юм. Эмч хүн маш их ажиллаж, хөдөлмөрлөж байж үр дүнд хүрдэг. Ажилдаа дуртай, үнэнч, хичээнгүй сэтгэл зүтгэл маань эцсийн эцэст үхлийн ирмэгт буй өвчтөнийг авардаг юм даа. Тэдэнд амь нас бэлэглэсний дараа л сэтгэлийн таашаал баяр баяслыг авч, мэргэжлээрээ бахархаж, эмч гэдгээ мэдэрдэг.


-Та яагаад эмчийн мэргэжил сонгох болсон бэ?

-Манай өвөө намайг хүүхэд байхаас л “Миний хүү том болоод эмч болбол зүгээр дээ” гэж хэлдэг байсан. Өвөө маань хэдийгээр бурхан болсон ч би тэр үеэс эмч болно хэмээн боддог болсон. Би Солонгосын Анагаахын сургуульд элсэн орсноосоо хойш үхэл амьдралын зааг дээр ажиллах мэс заслын эмчийн мэргэжилд татагдан сургууль төгсөхөөсөө өмнө мэс заслын эмч болохоор шийдэж билээ. Тухайн үед элэгний хатуурал гэхэд л ихэнх тохиолдолд эмчилгээ байхгүй үхэхээс өөр гарцгүй хэмээн ойлгодог байсан. Тиймээс элэг шилжүүлэн суулгах мэс засал нь эмчилгээгүй гэх өвчтөнүүдийг амьдруулж чадахаар барахгүй мэс заслын хувьд ч өөрийгөө сорьж болохуйц салбар хэмээн үзэж энэ чиглэлээр мэргэшсэн.

-Ер нь Та амардаг уу?

-Бараг л амардаггүй. Оройдоо 23.00-24.00 цагт очоод өглөө 06.00 гээд ажилдаа явна. Зарим амралтын өдрөөр амрах бол зав чөлөөгөө гэр бүлийнхэндээ зориулахыг хичээдэг.

-Та элэг шилжүүлэн суулгах мэс заслыг хэдийнээс эхэлж хийсэн бэ?



-2004 оноос албан ёсоор элэг шилжүүлэн суулгах мэс засалд суралцаж эхэлсэн. Энэ мэс засал нь нэлээд олон цаг үргэлжилдэг. Амьд донороос элэг авах тохиолдолд дунджаар 12 цаг орчим хугацаа зарцуулагддаг. Элэг шилжүүлэх мэс заслыг амжилттай явуулахын тулд сайн бэлтгэгдсэн баг хэрэгтэй бөгөөд уг мэс засал нь маш хүнд учраас нэг хүн дангаараа хийх боломжгүй. Хамгийн гол нь гар нийлсэн сайн баг байх шаардлагатай.

-Та олон хүнд элэг шилжүүлэн суулгажээ. Элэг шилжүүлэх мэс заслын талаар ойлголт өгнө үү?

-Элэг шилжүүлэн суулгах мэс засал нь эрүүл хүний элгийг өвчтөнд суулгаж өгдөг нэг ёсондоо элэг солих ажиллагаа юм. Ямар нэгэн шалтгааны улмаас элэг өвчилж хэвийн үйл байдлаа хангаж чадахаа больсон нөхцөлд элгийг бүрмөсөн авч, өөр хүний элгийг бүхэлд нь болон хэсэгчилж суулгах үйл явц гэж хэлж болно. Шинээр суулгасан элэг хэвийн ажиллахын тулд элэг рүү орж, гарч байгаа судсыг сайн холбож өгөх ёстой.

Элэг шилжүүлэн суулгах мэс засал нь анх 1950-иад оноос Америкт судлагдсан бөгөөд 1980 оноос албан ёсоор клиникт хэрэгжүүлж, олон өвчтөнд шинэ амьдрал бэлэглэсэн. Одоогоор манай улсын элэг шилжүүлэн суулгах мэс заслын үр дүн дэлхий дахиныг дагуулах хэмжээнд хүрээд байна.

-Хүмүүс юунаас болж элэгний хорт хавдраар өвчилж байна вэ?

-Хавдар нь ихэвчлэн элэгний өвчний эх сурвалжтай хүмүүст үүсдэг гэж тогтоогдоод байгаа. Эх сурвалж нь элэгний В, С вирусийн өвчлөл, архи удаан хугацаанд хэтрүүлэн ууснаас болж үүсдэг алкохолын шинжтэй үрэвсэл, элэгний өөхжилт зэрэг юм. Ихэнх тохиолдолд үрэвсэл удаж даамжирсны улмаас элэгний хатуурал руу шилждэг бөгөөд элэгний хатууралтай өвчтөнүүдэд хорт хавдар үүсэх магадлал өндөр байдаг гэж үздэг. Элгэнд хавдар үүсэх явц нь ерөнхийдөө ямар ч шинж тэмдэг илрэхгүй байх нь олон тул илрэх үед өвчний явц хүндэрсэн байх нь элбэг байдаг.

Иймд дээр дурдсан В, С вирусийн улмаас элэгний үрэвсэлтэй болсон хүмүүс тогтмол шинжилгээнд хамрагдаж хавдар үүссэн эсэх талаар зайлшгүй хянуулах шаардлагатай. БНСУ нь В вирусээр өвчилсөн өвчтөний тоогоор дэлхийд өндөрт ордог орны нэг. Түүгээр ч барахгүй элэгний хорт хавдар үүсч байгаа хувиараа ч дэлхийд дээгүүрт ордог. Монгол улс элэгний өвчлөл, хавдрын шинжээр манай оронтой төстэй байдалд байгаа гэж ойлгодог. Одоогоор манай улсад элэгний хорт хавдартай өвчтөнүүдэд элэг тайрах,

шилжүүлэн суулгах мэс засал, Radio-frequency ablation (RFA), Transarterial chemoembolization (TACE), Ethanol injection therapy (EIT), Radioembolization, Systemic chemo treatment , External radiation treatment зэрэг эмчилгээг хийж байна. Үүн дотроос өвчтөн эдгэрэх боломжтой эмчилгээнд элэг тайрах, шилжүүлэн суулгах мэс засал, ethanol injection therapy зэрэг эмчилгээ орж байна.

-Элэгний өвчлөлөөс хэрхэн урьдчилан сэргийлэх вэ?

-Энэ хавдраас урьдчилан сэргийлэхийн тулд өөртөө өвчний эх сурвалж байгаа эсэхийг мэдэх нь чухал. В, С вирусийн гаралтай элэгний үрэвсэл байгаа эсэх, байхгүй бол В вирусийн хувьд вакцин тариулах, архи хэтрүүлж хэрэглэхээс зайлсхийх хэрэгтэй.

Түүнчлэн сүүлийн үед хэт таргалалт нь уг хавдрыг үүсгэх гол шалтгааны нэг болж байгаа тул жингээ хэтрүүлэхгүй байх нь хамгийн чухал юм. Ер нь өөртөө элэгний өвчин үүсгэх эх сурвалж байгаа бол шинж тэмдэг байх, байхгүй нь хамаагүй тогтмол шинжилгээнд хамрагдан хавдар үүссэн эсэхийг байнга шалгах хэрэгтэй.

-Донорын хувьд мэс заслын явцад болон мэс заслын дараа хүндрэл гарах тохиолдол байдаг уу. Манай улсад эрхтэн шилжүүлэх тэр дундаа элэгний донорын талаарх ойлголт их муу байдаг. Элгээ өгөөд эрхтэн дутуу, насаараа ажиллаж чадахгүйд хүрнэ гэх ойлголт их байдаг л даа.

-Эрхтэн шилжүүлэн суулгаж буй эмнэлгийн эмч, ажилтнууд чин сэтгэлээсээ хичээнгүйлэн ажиллаж, ард иргэддээ мэдээлэл сайн өгөх шаардлагатай. Ер нь эрүүл мэндийн салбарын ажилтнуудын гэрийн даалгавар нь энэ талын мэдээллийг иргэдэд зөв хүргэж, ойлгуулах юм шүү дээ. Манай улсад ч донорын талаарх ойлголт муу байсан он жилүүд бий. Сургалт, семинар сурталчилгаа сайтар хийсний дүнд солонгосчууд одоо нэлээд өндөр мэдлэгтэй болсон.

Хүндрэлийн тухайд донор ч ялгаагүй том мэс засалд орж байгаа учраас мэс заслын явцад болон дараа нь хүндрэл гарч болно. Гэхдээ донор нь энгийн хүмүүсийг бодвол эрүүл мэнд нь маш сайн хүмүүс байдаг. Тэд бусдын төлөө өөрөө шийдвэр гарган мэс засалд орж буй учраас эмч, мэргэжилтнүүд донорыг аль болох хүндрэл багатай байлгах үүднээс бүхнээ дайчлан ажилладаг. Донорын мэс заслын тухайд дэлхий дахинд гаргасан мэдээнээс авч үзвэл баруун талын элгээ донор болгон өгсөн тохиолдолд нас баралтын хувь 0.1-1 хувь орчим гэсэн үзүүлэлт бий. Тоон үзүүлэлтийн хувьд бага тоо мэт харагдавч эрүүл саруул хүний хувьд төсөөлж боломгүй хэрэг учраас эмч нар дээрх нас баралтыг “0” хувь болгохын төлөө хичээнгүйлэн ажиллаж байна.

Донор нь мэс засал хийлгэсний дараа ихэвчлэн 7-10 хоногийн дараа эмнэлгээс гардаг бөгөөд элэгний төлжилтийн хувь нь мэс засалд орсноос хойш хоёр долоо хоног өнгөрөхөд 80 хувьд хүрдэг. Цаашлаад төлжилт нь зургаан сараас нэг жилийн дотор аяндаа явагдах бөгөөд ихэнх донорын элэг эхний хоёр долоо хоногт л нөхөн төлждөг. Мэс заслын дараа анхаарч болгоомжлох зүйл гэвэл элэг бүрэн гүйцэд төлжих хүртэл элгэнд хортой зүйл ялангуяа архи, өөх, тослог ихтэй хүнс хэрэглэхгүй байх нь чухал. Мөн шарх эдгэх хүртэл нэг сар хагасаас хоёр сарын хугацаанд хэвлийн хэсэгтээ хүч өгөх дасгал хийхгүй байх хэрэгтэй.

-Монгол улс элэгний өвчлөлийн үзүүлэлтээр дэлхийд тэргүүлэх хэмжээнд хүрсэн байна. Өвчлөлийг хэрхэн яаж, ямар арга замаар бууруулах вэ?

-Төр, засгаас маш сайн анхаарах хэрэгтэй. Хүүхдүүдийг багаас нь В вирусийн халдвараас урьдчилан сэргийлэх зорилгоор вакцин тарих ёстой. Цусаа өгөх, тамхи татах зэргээс С вирусын халдвар авдаг. Тиймээс цус сэлбэх, цустай холбоотой тарилгуудад төрөөс маш сайн анхаарах хэрэгтэй. Хар тамхи татах, мансуурах асуудал нь улсын хяналтад байдаг. Мөн архи элэгний өвчлөлийг үүсгэдэг гол шалтгаан болдог. Архи нь тухайн улс үндэстний эдийн засаг, соёлтой холбоотой. Архи уух нь хортой, буруу гэдгийг хүн бүр мэддэг мөртлөө уудаг. Тэгэхээр Засгийн газраас архины хор хөнөөл, хүний эрүүл мэндэд хэрхэн нөлөөлдөг талаарх мэдээлэл сурталчилгаа, ойлголтыг ард иргэддээ маш сайн явуулах ёстой. Мөн ард түмэндээ В вирусийн вакцин хийх ажлыг идэвхжүүлж, энэ нь өргөн олныг хамарсан тохиолдолд 10-20 жилийн дараагаас элэгний өвчлөл буурах боломжтой.

-Манайд шарын халдвар их гардаг. Заримдаа сургууль, цэцэрлэгийг хаах хэмжээнд хүрдэг. Тиймээс эцэг, эхчүүд хүүхдүүдийнхээ ирээдүйд маш их санаа зовдог.

-Бага насандаа шарласан бохирын А вирус нь тийм ч аюултай биш. Тухайн үедээ өвдөөд эмчилгээ сайн хийлгэснээр эдгэрдэг. Элэг нь эрүүлжээд нөхөн төлждөг эрхтэн тул том асуудал болж чаддаггүй гэсэн үг. Манай улсад ч дээр үед шарлах тохиолдол их гардаг байсан бөгөөд шарлалтаас улбаалж элэг хатуурч хүндэрсэн тохиолдол ховор. Солонгосын эдийн засгийн хөгжил хурдацтай дээшилснээр бохирын буюу А вирусийн шараар бага насны хүүхдүүд өвчлөхөө больсон. Бага насны хүүхдүүдийн хувьд Монгол улсын эдийн засаг хөгжөөд ирвэл төрөөс нь эрүүл мэндийн асуудалдаа анхаарч ариутгал, ариун цэврийн бодлогыг цогцоор хэрэгжүүлснээр шарлах өвчин аяндаа багасна.

Харин сүүлийн үед томчууд шарын халдвараар их өвдөх боллоо. Энэ бол харамсалтай асуудал. Том хүмүүс шарлахаараа нэлээд хүнд, хурцаар өвддөг. Үхэлд ч хүргэх аюултай.

-Монголд элэг шилжүүлэх хагалгааг танай орны АСАН эмнэлгийн эмч нартай хамтран хийж эхлээд байгаа. Элэг шилжүүлэх мэс заслыг хэрхэн богино хугацаанд хөгжүүлж болох вэ?

- Солонгос эмч нар Монголд очиж хагалгаа хийснээр элэг шилжүүлэх хөгжилд том нөлөө үзүүлж чадахгүй болов уу. Хамгийн гол нь монгол эмч нарыг бэлтгэх шаардлагатай. Гэхдээ энэ нь богино хугацаанд хэрэгжих асуудал биш. Монголоос хэд хэдэн эмч манай улсад элэгний мэс заслын эмчээр бэлтгэгдэж байгаа юм билээ. Манайх элэг шилжүүлэх хагалгааг дэлхийд тэргүүлэх хэмжээнд хийх хүртлээ 20 жилийг зарцуулсан.

Элэгний өвчний эх сурвалж нь В, С вирусийн өвчлөл, архи их ууснаас болж үүсдэг алкохолын шинжтэй үрэвсэл, элэгний өөхжилт юм.



Олон эмч нарын хүчин чармайлт, мөн төрөөс явуулах эрүүл мэндийн салбарын бодлого сайжирснаар элэгний мэс заслыг өнөөгийн хэмжээнд хөгжүүлж чадсан. Түүнээс зөвхөн эмч нар зүтгээд амархан хөгждөг асуудал биш шүү дээ. Тэгэхээр Монгол улс элэг шилжүүлэх хагалгааг бие даан хийх хүртэл нэлээд хугацаа зарцуулах болов уу. Харин гаднын элэг шилжүүлэх том эмнэлгүүдтэй хамтарч ажилласнаар хугацааг багасгаж болох юм. Зөвхөн эмч нар ч бус эмнэлэг, улсын эдийн засаг, эрүүл мэндийн түвшинд өсөж дэвжих ёстой байдаг.

Ер нь мэс засал хийснээр элэг шилжүүлэх ажил дуусчихдаггүй. Хагалгааны дараа элгийг хэвийн хэмжээнд үйл ажиллагаа явуултал маш нарийн хяналт үзлэг, шинжилгээ хийдэг. Өөрөөр хэлбэл, хагалгааны дараах эмчилгээ хамгийн чухал. Тэгэхээр эмчилгээ сувилгаа, хяналтыг өндөр түвшинд үзүүлэхүйц эмч, сувилагч нарыг бэлтгэх ёстой. Системийг харж чадах алсын хараа чадвартай, ерөнхийд нь удирдан чиглүүлэх хүнийг бэлтгэх шаардлагатай. Элэг шилжүүлэх мэс заслыг хөгжүүлье гэвэл асуудлыг цогцоор нь авч үзсэн системтэй төрийн бодлого байх хэрэгтэй. Учир нь эрүүл мэндийн шинжлэх ухааны хамгийн том бөгөөд хүнд мэс засал бол элэг шилжүүлэх ажиллагаа юм.

-Монгол өвчтөнүүдэд элэг шилжүүлэн суулгасан мэс заслын талаар сонирхож болох уу?


-Одоогийн байдлаар манай эмнэлэгт долоон монгол өвчтөн амьд донороос элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгээд байна. Бүх мэс засал амжилттай болж өвчтөнүүдийн биеийн байдал нь хэвэндээ ороод байгаа. Доноруудын бие ч хүндрэлгүй сайн байна.

-Таныг манай улсад анх удаа ажлын айлчлал хийж, элэгний өвчтэй хүмүүсийг үзэж зөвлөгөө өгнө гэж сонссон. Хэдийд очих вэ?

-Арванхоёрдугаар сарын 13-15-нд Монголд очно. 14-нд Сонгдо эмнэлэг дээр элэгний өвчтэй хүмүүсийг үзэхээр төлөвлөж байна. Монголд элэгний өвчтэй хүмүүс олон байдаг гэж анх сонсоод би их гайхсан. Тэгсэн мөртлөө элэгний өвчний талаар ямар ч ойлголтгүй, мэдээлэлгүй байдаг юм байна. Элэг шилжүүлэх хэмжээнд байгаа эсэхээ мэдэхгүй, өвчлөлөө мэдэхгүй монгол хүмүүс надад үзүүлж байсан. Зарим нь өвчнөө эцсийн шатанд хүргээд ямар ч эмчилгээгүй байхад л Солонгосын эмнэлэгт найдлага тавиад хүрээд ирсэн байв. Өмнө нь манай эмнэлэгт элэг шилжүүлэн суулгах мэс засалд орохоор танай улсаас хэд хэдэн хүн ирсэн бөгөөд хавдрын явц хэт даамжирсны улмаас эмчилгээ хийлгэж чадалгүй буцсан тохиолдол ч бий. Тиймээс би Монголд очоод өвчтөнүүдэд ямар эмчилгээ чухал юм, яаж эмчлэх талаар зөвлөгөө өгнө. Хэрвээ элэг шилжүүлэн суулгах шаардлагатай хүн байвал эртнээс илрүүлж, асуудлыг ойлгуулна. Өөрөөр хэлбэл, ямар ч мэдээлэлгүйгээр зардал гаргаад энд ирэхгүй байх талд зөвлөгөө өгч, монгол хүмүүст туслахыг хичээнэ. Мэс засал

ТООН МЭДЭЭЛЭЛ

ЭЛЭГНИЙ ӨВЧЛӨЛД ДАРЛУУЛСАН МОНГОЛ



ЭЛЭГ НЬ ХҮНИЙ БИЕ ДЭХ ХАМГИЙН ТОМ БУЛЧИРХАЙ ЮМ. ДУНДЖААР 1500 ГР ЖИНТЭЙ

МОНГОЛД:

-Элэгний хорт хавдрын өвчлөлийг улс орноор нь гаргасан жагсаалтад Монгол улс 86.5 хувийн үзүүлэлтээр тэргүүлсэн бол Гамби, Малвив зэрэг орон араас нь жагсчээ.

-Монголд 1950-иад оноос халдварт шар өвчин илэрч эхэлсэн.

-Жилд 1700 орчим хүн элэгний хорт хавдартай хэмээн шинээр оношлогддог.

-Жилд 800-900 хүн элэгний хатуурлын улмаас нас бардаг.

-Манай 2.8 сая иргэний 15.6 хувь нь гепатит С, 10 хувь нь В, зургаан хувь нь гепатит дельта вирусийн халдвартай нь шинжилгээрээ батлагдсан байна.

-Манай оронд хорт хавдрын таван тохиолдол нийт хавдрын 81 хувийг эзэлж, аюулын хэмжээнд хүрснийг ЭМЯ-наас зарласан. Үүнд элэг 34, ходоод 15, уушги 12, улаан хоолой 11, Умайн хүзүүний хавдар есөн хувийг эзэлж байна.

хийх нь чухал гэхдээ хагалгаа хийгээд энэ хүн цааш амьдрах найдвар байгаа эсэхийг шийдвэрлэх нь хамгийн чухал. Монголчууд, монгол эмч нартай хамтарч ажилласнаар энэ талд илүү анхаарч сургалт семинар явуулна гэж бодож байгаа.

Манай эмнэлэг танай MCS-ийн барьж буй шинэ эмнэлэгтэй хамтарч ажиллах юм. Миний хувьд Монголд ирэн очин ажиллахаар төлөвлөж байгаа.

-Элэг ямар эрхтэн бэ?

-Элэг бидний бие дэх химийн гол үйлдвэр юм. Биед орж ирж буй бүх зүйлийг зохицуулдаг, өөрөө өөрийгөө төлжүүлэх байдал нь бусад эрхтэнтэй харьцуулшгүй гайхалтай эрхтэн. Хүнд өвчин тусахаас наагуур элэг бараг өвдөхгүй, мэдрэгдэхгүй. Элэг өөрчлөлттэй, муудлаа гэх тохиолдолд тухайн хүний бие дэх олон үйл ажиллагаа зогссон байна гэж ойлгох хэрэгтэй.

-Сүүлийн үед монголчууд БНСУ-д эрүүл мэндийн үзлэг шинжилгээ болон эмчилгээ хийлгэх нь нэмэгдэж байна. Тэр дундаа Анам эмнэлэгт элэг болон бөөр шилжүүлэн суулгуулах мэс засал хийлгүүлж байна. Энэ өвчтөнүүд эх орондоо очоод эмчилгээгээ үргэлжлүүлэх шаардлагатай. Энэ талаар Та юу хэлэх вэ?

-Монголын олон өвчтөн манай эмнэлэг төдийгүй Солонгосын бусад эмнэлэгт эмчилгээ хийлгэж байгаа тухай би сонсож байгаа. Тэднийг эх орондоо буцсаны дараа эрүүл саруул байлгахын тулд хоёр орны эрүүл мэндийн байгууллагын хамтын ажиллагаа чухал гэсэн бодол надад төрдөг. Ялангуяа элэг, бөөр шилжүүлэн суулгах төдийгүй эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал нь өөр салбарыг бодвол тоног төхөөрөмж гэхээсээ илүү хүн өөрөө хамгийн чухал байдаг. Өөрөөр хэлбэл, эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг өөрийн орондоо хэрэгжүүлснээр эрхтэн хүлээн авсан өвчтөнүүдийг асарч халамжлах сургалтад хамрагдсан олон хүн цаашдаа Монгол Улсад хэрэгтэй байх болов уу гэж бодож байна. Өмнө нь Монголын хэд хэдэн эмч Солонгост ирж сургалтад хамрагдсан. Энэ тал дээр манай эмнэлгийн зүгээс ч байнгын анхаарал тавьж боловсон хүчний сургалтын асуудал дээр хичээж ажиллахаар төлөвлөж байна. Манай Кореа их сургуулийн “Анам” эмнэлэг бол Монгол улстай олон талаараа дотно харилцаатай эмнэлэг гэж хэлж болох юм. Цаашдаа ч би болон манай эмнэлгийн бөөрний эмч Паг Гуон Тэй профессор Монгол улсын эрүүл мэндийн байгууллагуудтай хамтран ажиллаж, эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал хийх ба өвчтөний эмчилгээний тал дээр ч тусламж дэмжлэг үзүүлэх талаар бодож байгаа.

-Манай сэтгүүлийн уншигчдад тодорхой мэдээлэл өгсөн танд баярлалаа!

-Цаашдаа Монгол улс, БНСУ-ын харилцаа улам батжин бэхжихэд эрүүл мэндийн салбарын харилцаа, хамтын ажиллагаа чухал хувь нэмэр оруулна гэдэгт найдаж байна. ■

Сөүл хот
2012.11 сар



ДЭЛХИЙД:

-1955 онд Кладиа Велш эрдэмтэн амьтанд элэг шилжүүлэн суулгах туршилтыг анх амжилттай хийжээ .

-Элэгний С вирусийг бүрэн устгах боломж Ази хүмүүст 60-70 хувь байдаг бол цагаан арьстнуудад 30-40 хувь л байдаг аж.

-Дэлхий дээр элгийг гэмтээж, хатуурах, хавдар, өвчлөл үүсгэх 10 төрлийн вирус байдаг.

-132 сая хүн амтай Япон улсын хүн амын дөнгөж нэг хувь нь гепатит С вирусийн халдвартай бол 1.3 тэрбум хүн амтай БНХАУ-ын иргэдийн долоо, ОХУ-ын 139 сая иргэний арав орчим хувь нь энэ төрлийн халдвартай гэх статистик байна.

-Элэгний хорт хавдрын улмаас жил бүр сая шахам хүн нас барж, 315000 орчим хүн шинээр оношлогдож байна.

-Элэгний хорт хавдрын өвчлөл Африк, Алс дорнод, Зүүн ба Зүүн Өмнөд Ази, Номхон далайн арлуудын хүн амын дунд зонхилон тохиолддог. Элэгний хорт хавдраар нас барагсдын 44 хувийг Африкийн орнууд эзэлж байна.

-Элэгний В вирусийн халдвараар Америкт жилд 73 мянган хүн өвчилж байна. Энэ нь 1980 онд тус улсад 260 мянгад хүрч байсантай харьцуулахад бага тоо.

РЕДАКЦИЙН УУЛЗАЛТ

ЭЛЭГНИЙ ӨВЧИН МОНГОЛ УЛСЫН АЮУЛ БОЛЧИХООД БАЙНА

Тэмдэглэсэн:Б.Баяртогтох, Б.Энхмарт

Эрүүл иргэдтэй байж эрүүл эдийн засаг хөгжинө. Тиймээс "Mongolian Economy" сэтгүүл "Редакцийн уулзалт" буландаа Монголын мянга мянган хүнд амьдрал бэлэглэж, амь насыг нь авран хамгаалдаг цагаан нөмрөгтнүүдийг урилаа. Тэр тусмаа Монголын эрүүл мэндийн шинжлэх ухааныг нэг шатаар ахиулсан Эрхтэн шилжүүлэн суулгах төвийн Элэг шилжүүлэн суулгах анхны багийн эмч нарын төлөөллийг оролцуулж байгаагаараа онцлог юм. Монголдоо төдийгүй дэлхийд тархалтаараа тэргүүлж буй элэгний хавдар, хатуурал зэрэг өвчнөөс хэрхэн урьдчилан сэргийлэх, эмчлэх болон элэг шилжүүлэн суулгах мэс ажиллагаанд тулгамдаж буй асуудлуудыг хөндөхийг зорилоо.

Редакцийн уулзалтад ЭМШУИС-ийн Мэс заслын тэнхмийн эрхлэгч, шинжлэх ухааны доктор, профессор, Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төвийн дарга, Монголын мэс засалч эмч нарын нийгэмлэгийн ерөнхий нарийн бичгийн дарга О.Сэргэлэн, ЭМШУИС-ийн Мэс заслын тэнхмийн багш, Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төвийн мэдээгүйжүүлэлтийн эмч Л.Ганболд нар оролцлоо.

Төрийн дэмжлэггүйгээр элэг шилжүүлэх хагалгаа урагшлахгүй

-Монгол улсад элэг шилжүүлэн суулгах мэс ажиллагаа хийгдээд жил гаруйн хугацаа өнгөрчээ. Энэ хугацаанд ямар ололт амжилт болоод саад бэрхшээл учирч байна вэ. Төр, засгаас дэмжлэг хэр үзүүлж байна вэ?

О.Сэргэлэн: -Биднийг редакцийн уулзалтдаа урьж, оролцуулж байгаад Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төвийн эмч, ажилчдынхаа өмнөөс талархал илэрхийлж байна. Хамгийн түрүүнд Монголд яагаад элэг шилжүүлэн суулгах хэрэгтэй болсон талаар цухас дурдах нь зүйтэй. болов уу. Монголд элэгний В,С вирусийн халдвар, элэгний хатуурал, хавдрын тархалт, өвчлөл нийт өвчний тэргүүн эгнээнд ороод удаж байна.

Өнгөрсөн хугацаанд олон зуун хүн бидний гар дээр элэгний өвчлөлөөр амиа алдсан. Тиймээс эмч, мэргэжилтнүүдэд элэгний хавдар, хатуурал, вирустэй тэмцэх, урьдчилан сэргийлэх эмчилгээ, эмчлэх арга барилаа өөрчлөн, сайжруулах, элэг шилжүүлэн суулгахад суралцах зайлшгүй шаардлага тулгарсан. Ингээд бид 2007 оноос элэг шилжүүлэн суулгахтай холбоотой үйл ажиллагааг эхлүүлсэн юм. Шүүмжлэлд ч их өртсөн. Манайд хэрэгжих цаг нь болоогүй, 10-15 жилийн дараа л ярих зүйл гэж зарим хүмүүс эсэргүүцдэг байсан. Монголд өнөөдрийн байдлаар нийтдээ долоон хүнд элэг шилжүүлэн суулгаад байна. Хөгжиж байгаа оронд элэг шилжүүлэн суулгах өндөр технологи, эрсдэлтэй зүйлийг бий болгож, биелүүлж болдгийг манай баг харуулж чадлаа. Дэлхийд элэг шилжүүлэн суулгах эрхтэй 45 орон байсны 46 дахь улсаар Монгол бүртгэгдсэн. Тэдний ихэнх нь хөгжингүй орон. Бидэнд "Хөгжиж байгаа оронд ийм өндөр технологийг маш богино хугацаанд бий болгож, амжилттай хэрэгжүүлж байгаад баярлаж байна" гэсэн талархлын болоод урмын үг их ирж байгаа. Энэ бол Монголын эрүүл мэндийн шинжлэх ухааны хөгжил, чадамжийг харуулж байгаа хэрэг. Мөн Эрхтэн шилжүүлэн суулгах үндэсний төвтэй болсон нь хамгийн том амжилт юм.

Л.Ганболд: -Бидний эцсийн зорилго монгол эмч нар Монголдоо монгол хүмүүст элэг шилжүүлэн суулгах мэс ажилбарыг хийж сурах, энэ арга туршлагыг өвлүүлж үлдээх.

-Элэг шилжүүлэн суулгах өндөр технологийг эзэмшихээр ханцуй шамлан орсон түүхийг сонирхъё?

О.Сэргэлэн: -Манай хоёр эмч Финляндад 2007 онд явж суралцсан. Тэд Монголдоо элэг шилжүүлэн суулгах хагалгааг хийж болох юм байна гэсэн итгэл дүүрэн ирсэн юм. Тэгээд бид ЭМШУИС-д хүсэлт тавьж, туршилт хийх өрөө гаргууллаа. Дараа нь Шинжлэх ухаан технологийн



Фотог Э.Зоригт

Баруун гар талаас О.Сэргэлэн, Л.Ганболд

санд төсөл бичиж, дөрвөн сая төгрөгийн санхүүжилт авсан. Тэр үеэс туршилтын багаа бүрдүүлж, ажлын бус цагаар, хагас, бүтэн сайн өдрүүдэд туршилт хийж эхэлсэн дээ.

-Гахайн дээр туршилт хийж байсан гэсэн үү?

О.Сэргэлэн: -Тийм ээ, 23 гахайнд туршилт хийсэн. Дөрвөн сая төгрөгөөрөө гахай болон шаардлагатай зарим багаж, хэрэгсэл аваад дууссан учраас хагалгааны дараа гахайгаа үргэлжлүүлэн эмчлэх эмчилгээний зардал, бусад зүйлд төсөв олдоогүй. Гэтэл туршилтын мэс ажилбарын дараа 2-3 цаг болоод гахайнууд маань үхэж эхэлсэн. Алдаатай, туршлагагүй зүйл бидэнд байсан л байх. Их ч шүүмжлүүлсэн дээ. Амьтны амиар тоглолоо, тамлалаа гээд л. Бид төр, засаг болоод тусалчих болов уу гэсэн хүн бүрт “Бидэнд сурах зүйл их байна. Суралцах зардал, бусад зүйлд хөнгөлөлт үзүүлж, санхүүгийн туслалцаа үзүүлээч” гэж хандсан боловч бүтээгүй. Харин БНСУ-ын АСАН эмнэлгийн эмч нарт “Бид ийм туршилт явуулаад байна, өвчлөл ийм хэмжээнд хүрлээ. Биднийг туршлагажуулж, сургаж өгөөч” гэсэн хүсэлт тавьсан. Ингэж л тус эмнэлгийн эмч нар биднийг багаар нь хүлээн авч, АСАН сангаас бүрэн санхүүжүүлж, сургаж эхэлсэн. Энэ сургалт өнөөдрийг хүртэл үргэлжилж байна.

Хамгийн сонирхолтой нь Монголын төр, засаг биднийг дэмжээгүй байхад гаднын эмч, мэргэжилтнүүд энэ салбарыг хөгжүүлэх нь зөв хэмээн тусалсан явдал юм. Эхний сургалтаар мэс ажилбар хэрхэн хийхийг харуулах, дараа нь хамтрах, цаашлаад хагалгааны дараах эмчилгээ, асаргаа, сувилгааны талаарх цогц сургалтад хамруулж, дадлага хийлгэх замаар элэг шилжүүлэн суулгах мэс заслын хүндрэл, бэрхшээлийг бидэнд биеэр мэдрүүлсэн дээ. Манай үндэсний төвийн эмч, ажилтнууд Солонгост 3-4 удаагийн сургалтад хамрагдаад байна. Энэ бүгдийн дараа бид өнгөрсөн оны есдүгээр сард УКТЭ дээр элэг шилжүүлэн суулгах анхны мэс ажиллагааг хийсэн. Мэс засалд шаардлагатай багаж, төхөөрөмжүүд манайд байхгүй учраас АСАН эмнэлгээс шаардлагатай бүхнийг авчирч, солонгос эмч нар анхны хагалгааг гардан хийсэн. Манай баг харах байдлаар хамтарч ажилласан. Харин дараа дараагийн ажилбарт оролцож, өнөөдөр өөрсдөө гардах хэмжээнд хүрээд байна. Үүнийг зоригтой хэлж байгаагийн учир нь **нэгдүгээрт,** багийн сэтгэл зүйн байдал бүрэн бэлтгэгдсэн, **хоёрдугаарт,** ард иргэдийн монгол эмч нартаа итгэх итгэл маш их болсон, **гуравдугаарт,** багаж төхөөрөмж бага ч болтугай бүрдэж байна. Гэхдээ бас асуудал байна.

-Тухайлбал?

О.Сэргэлэн: -Хэдийгээр шаардлагатай багаж төхөөрөмж хангалттай байхгүй ч төрөөс 600 сая төгрөг төсөвлөж, нэн шаардлагатай цөөн тооны багажаа авч чадсан. Гэхдээ илүү өндөр үнэтэй, нэн шаардлагатай багажаа өнөөдрийг хүртэл авч чадаагүй. Өнгөрсөн хугацаанд АСАН эмнэлгийн эмч нар

шаардлагатай багаж, төхөөрөмжүүдийг өөрсдөө авчирч хагалгаагаа хийчихээд буцаагаад аваад явдаг байсан. Тэрхүү чухал шаардлагатай багаж, төхөөрөмжүүд байхгүй бол бид бие даан хагалгаа хийх боломжгүй. Бид өнөөдөр ч төр, засагт энэ талаар хүсэлт гаргаад л явж байна.

Бидэнд хагалгаа хийх тоног, төхөөрөмж алга



О.Сэргэлэн эмч өвчтөнөө үзэж байгаа нь

Энэ мэт яаралтай авах багаж, хэрэгслийн мөнгийг ирэх оны төсөвт суулгуулахаар УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороогоор дэмжигдээд явж байтал Төсвийн байнгын хороогоор ороод хасагдчихсан. 2014 оны төсвийг хүлээнэ гэвэл дахиад нэг жил алдана. Энэ хугацаанд хэдэн арваараа хагалгаанд орохоор хүлээж байгаа өвчтөнүүдийн хэд нь хорвоогийн мөнх бусыг үзүүлэх бол...

-Шаардлагатай багаж, тоног төхөөрөмжүүдийг авъя гэвэл хэдий хэмжээний төсөв хэрэгтэй вэ?

О.Сэргэлэн: -1.2 тэрбум төгрөгийн багаж, төхөөрөмж нэн тэргүүнд шаардлагатай байгаа. Манайд хийж буй томоохон мэс ажилбарууд бүдүүлгээр хэлэхэд мэдрэмжээр л явагддаг. Харин одоо нэн тэргүүнд авах багаж, төхөөрөмжүүдийн хяналтын мониторуудын нэг нь л гэхэд тухайн өвчтний цус алдах гэж байгааг эрт илрүүлдэг. Ингэснээр шаардлагатай арга хэмжээг урьдчилан авах боломж бүрдүүлдэг. Гэтэл манайд буй монитор нь цус алдаад нэлээд хугацаа өнгөрсний дараа дохио өгдөг байх жишээний.

Өөр нэг зүйл бол бид цаашдаа зөвхөн амьд хүнээс бус цогцосноос эрхтэн шилжүүлнэ. Үүнд шаардлагатай, цогцосноос эрүүл эрхтэн илрүүлдэг аппарат байдаг. Үүнийг авах зайлшгүй шаардлагатай. Энэ мэт яаралтай авах багаж, хэрэгслийн мөнгийг ирэх оны төсөвт суулгуулахаар УИХ-ын Нийгмийн бодлогын байнгын хороогоор дэмжигдээд явж байтал Төсвийн байнгын хороогоор ороод хасагдчихсан. 2014 оны төсвийг хүлээнэ гэвэл дахиад нэг жил алдана. Энэ хугацаанд хэдэн арваараа хагалгаанд орохоор хүлээж байгаа өвчтөнүүдийн хэд нь хорвоогийн мөнх бусыг үзүүлэх бол. Хугацаа алдах нь мэргэжлийн багийн чадварт ч нөлөөлнө. Мэс заслыг байнгын тасралтгүй явуулж байж эмч, сувилагч нар улам дадлагажиж, суралцаж сайжирна шүү дээ.

-Элэг шилжүүлэн суулгуулахаар нэр нь жагсаалтад орсон хүмүүст ирэх онд мэс засал хийх боломжгүй болсон гэсэн үг үү?

О.Сэргэлэн: -Дахиад л АСАН төв рүү хандаж байгаа. Тус төвийнхөн жилд хоёр удаа буюу хоёр, есдүгээр сард Монголд ирж манай багтай хамтран элэг шилжүүлэн суулгах боломжтой. Тэгж ирэхдээ шаардлагатай багаж, төхөөрөмжөө сангийнхаа зардлаар авчирч хагалгаагаа хийчихээд буцаагаад аваад явж байна гэсэн. Бусад үед нь бид хагалгаа хийх ямар ч боломжгүй болж байгаа юм.

Л.Ганболд: -Солонгосын эмч нар буцахдаа ганц хоёр багаж үлдээж л байгаа юм. Гэхдээ л хэрэгтэй, шаардлагатай зүйл их байна. Орчин нөхцөлийн талаар хэлэх цөөн зүйл байна. Элэг шилжүүлэн суулгах нөхцөл, орчин нь гэнэт бүрдсэн юм биш. 2007 оноос бөөр шилжүүлэн суулгах ажиллагаа тууштай нэвтэрсэн нь элэг шилжүүлэн суулгах ажилбарын үндэс суурь болсон. Тиймээс орчны хувьд асуудалгүй. Хамгийн гол нь дахин дахин хэлэхэд, хагалгаа хийхэд шаардлагатай багаж төхөөрөмжүүд байхгүйд л хамаг учир байна.

-Монголын эрүүл мэндийн салбарын хөгжлийг нэг шатаар ахиулсан энэхүү ололтыг та нарын бодлоор бид яаж илүү хурдан хөгжүүлэх вэ?

О.Сэргэлэн: -Аливаа өвчлөлөөс урьдчилан сэргийлэх талаар ярьж, сурталчилах ёстой. Элэгний эмгэг, вирус, халдвар, урьдчилан сэргийлэх талаар сурталчилгаа, мэдээлэл хийдэг л дээ. Хамгийн наад захын жишээ нь гараа сайн угааж хэвших. Гараа угааж хэвшсэнээр А гепатитаас бүрэн сэргийлнэ. Үүнийг одооноос хэвшүүлж эхэлж байгаа бол В,С вирустэй сэргийлэх талын сурталчилгаа,

мэдээлэл маш хомс. Өнөөдөр манай олон иргэн В, С гепатиттай болчихсон байна. Тэд ирээдүйд элэгний хатууралтай болох нь ойлгомжтой. Тэднийг эмчлэх, аврах ажлын эхлэл бол элэг шилжүүлэн суулгах хагалгаа юм.

Үнэнийг хэлэхэд бидэнд сурталчилгаа, нэвтрүүлэг хийлгэх мөнгө байдаггүй. Эмчийнхээ цалингаар амьдралаа авч явдаг хүмүүс. Ард иргэдийнхээ эрүүл мэндийн боловсролд төрөөс мөнгө гаргаж, сурталчилгаа, мэдээллүүдийг илүү сайжруулах шаардлага байна. Саяхан телевизээр цусны донорын тухай аятайхан реклам явж байсан. Эрхтний донорын талаар ч бас тийм сурталчилгаа хийх ёстой.

Ингэхээр төр, засгийн дэмжлэггүйгээр энэ өндөр технологийн эмчилгээ, бусад зүйл нэг ч алхам урагшлахгүй, хөгжихгүй. Манайханд бас ийм нэг буруу ойлголт байна. Нийтэд тохиолдоод байгаа ханиад, хатгаа зэрэг өвчнөө дийлэхгүй байхад хэдхэн хүнд хагалгаа хийхэд их мөнгө зарцуулах гэлээ гэх. Энэ бол нэг хүний өвчлөл биш, нийтийн дундах, цаашлаад **Монгол улсын аюул болчихоод байна.** УИХ, Засгийн газарт хандаж бидний ярьсан асуудалд анхаарч өгөөч л гэж гуймаар байна.

Амин чухал эрхтний дутагдалд орсон нэгэндээ “За” гэж хэлье

-Ард иргэдэд эрхтэн шилжүүлэх тухай ойлголт маш муу байдаг. Энэ талаар юу хэлэх вэ?

О.Сэргэлэн: -Аль ч оронд хамгийн дутагдалтай зүйл донор. Азийн ихэнх оронд амьд донороос эрхтэн шилжүүлэх нь хөгжсөн байдаг. Европын орнуудад цогцосны донор сайн хөгжсөн. Харин манайх амьд донороос эрхтэн шилжүүлэн суулгахаас гадна цогцосны донорыг хослуулахыг зорино. Европын орнуудад тухайн иргэн таалал төгсөхдөө би донор болно гээд гэрээслэл бичдэг, эсвэл улсаас нь зохион байгуулалттайгаар жолооны үнэмлэх дээр нь тусгай тэмдэглэгээ хийдэг бол зарим оронд ертөнцийн мөнх бусыг үзүүлсэн хүнд эрүүл эрхтэн байгаа л бол донор болгодог хууль байдаг.

Манай орны хувьд энэ тухай хууль, заалт юу ч байхгүй. Дөнгөж эхэлж байгаа шинжлэх ухаан учраас төр, засгийн удирдлагуудтайгаа хамтран энэ тухай хууль, тогтоомжийг цаашид гаргаж ажиллана. Эрхтнээ бүтнээр нь эсвэл таллаж өгөөд өвчтөний хажууд нь хэвтэж байгаа хүү, охин, дүү, ах, эгчийг хараад эмч нар үнэхээр бахархдаг. Бусдад амьдрал бэлэглэж байна шүү дээ.

Л.Ганболд: -Эрхтэн шилжүүлэн суулгах мэс засал өөрөө маш онцлогтой. Маш сайн баг, хамгийн сайн багаж, технологи байгаад энэ хагалгаа бүтчихдэг юм биш. Донор эрхтэн байхгүй л бол хагалгаа хийгдэхгүй, хүний амь насыг аварч чадахгүй. Дэлхийн хандлага бол цогцосноос эрхтэн авахыг илүүд үздэг. Нөгөөтэйгүүр амьд донор хайж явах хооронд өвчтний амь нас эндэх тохиолдол цөөнгүй байдаг. Тиймээс энэ асуудлыг өөрийн орны нөхцөл хийгээд гаднын сайн туршлагатай уялдуулж шийдвэрлэх нь зүйтэй. Мөн төрөөс хөрөнгө хаях хэрэгтэй. Амин чухал эрхтний дутагдалд орсон нэгэндээ “За” гэж хэлэх иргэнийг, нийгмийг бүрдүүлэхэд төрийн бодлого хэрэгтэй байна.

-Манайх ихэвчлэн амьд донороос эрхтэн шилжүүлдэг гэлээ. Тэгвэл донорт ямар нэг халамж, туслалцаа байдаг уу?

О.Сэргэлэн: -Цусны донорт бага зэргийн тусламж, хангамж байдаг гэсэн. Харин эрхтний донорт одоогоор улсаас ямар нэг тэтгэмж, халамж байхгүй. Цаашид энэ талаар асуудал тавьж, шийдвэрлүүлэхээр төлөвлөөд байна. Мөн цогцосны донорыг хөгжүүлэхэд нэгэнт л орчлонгийн мөнх бусыг үзэж байгаа тэр хүн бусдад эд, эрхтнээ бэлэглэвэл дээдийн дээд буян болдог гэж бурхны номонд заасан байдаг.

Нэг эрүүл хүн нас барлаа гэхэд түүний хоёр бөөр, нэг элэг, нойр булчирхай, бусад оронд уушиг, нарийн гэдэс, арьс, мэдрэлийн эс гээд олон эрхтэн нь бусдын амийг аварч болохоор байдаг. Гэтэл зүгээр л чандарлаад, эсвэл булчихдаг нь харамсалтай. Хамгийн гол нь олон хүнд донор олдохгүй шаналж, амиа алдаж байна шүү дээ. Тиймээс энэ талын асуудлыг шийдвэрлэх, сурталчилгаа, мэдээллийг түгээхэд бидэнтэй байгууллага болоод хувь хүн бүрийг хамтран ажиллаасай гэж хүсэж байна.

Элэг шилжүүлэн суулгахад 72-75 сая төгрөг шаардлагатай

-Элэг шилжүүлэн суулгах хагалгааны төлбөрийн талаар мэдээлэл өгнө үү. Олон арван монгол хүн амьд үлдэхийн төлөө гадаадад очиж, хагалгаанд орж, олон зуун сая төгрөг зарцуулж байна. Одоо эх орондоо, ээж аавынхаа дэргэд бага зардлаар хагалгаанд орох боломжтой гэж үзэж болох уу?

-О.Сэргэлэн: -Хагалгаа бол тухайн өвчлөлөөс аврах үйлдлийн ердөө 20 хувь нь юм. Хүмүүс хагалгаа хийчихвэл өргөс авсан юм шиг эдгэрээд, босоод ирнэ гэж боддог. Тийм биш ээ. Хагалгааны дараах асаргаа сувилгаа, эмчилгээ нь цаашид амьдрах нийт боломжийн 80 хувь гэж хэлж болно.

Эрхтэн шилжүүлэн суулгах мэс заслыг хийлгэх гэж байгаа хүн юуны өмнө эдийн засгийн асуудлаа маш нарийн бодож, тооцох учиртай. Энэ талаар бид олон нийтэд үнэн, зөв мэдээлэл өгөх хэрэгтэй байх. Элэг шилжүүлэн суулгах мэс засалд АНУ болон Европын орнуудад нэг хүнээс 200-250 мянган евро шаардагдана. Харин Сингапур, Тайвань, БНСУ-д 200-250 мянган ам.долларын үнэтэй. БНСУ-ын АСАН анагаах ухааны төвд манайх албан ёсоор хүсэлт тавьж, төлбөрийг 150 мянган ам.доллар болгож, хямдруулсан. Өнгөрсөн хугацаанд 10 гаруй монгол хүн уг төвд мэс засалд орсон байна.

Яагаад ийм өндөр үнэтэй байдаг юм бэ гэхээр элэг шилжүүлэн суулгах мэс засалд В, С вирусгүй хүн орох тохиолдол маш ховор. Ихэнх нь вирустэй байдаг гэсэн үг. В, С вирусийг устгахгүйгээр элгийг нь



Л.ГАНБОЛД:

Дан ганц элэг ч биш. Эрүүл байхын тулд ариун цэврийг сахих хэрэгтэй. Архи, тамхийг хэрэглэхгүй байх. Монгол хүний элгийг хордуулж байгаа ганц зүйл архи л байна. Эрүүл байхын тулд эрүүл хоол хүнс хэрэглэх, хөдөлгөөн идэвхтэй амьдралыг мөрдөх, эрүүл амьдрах орчин бүрдүүлэхэд анхаарах учиртай.

шилжүүлж тавиад явуулчихаж байгаа газрууд бас байна л даа. Тийм газар бол хагалгааг хямд хийдэг. Хагалгааны хамгийн их өндөр өртөг нь В, С вирус устгах эмчилгээнд зарцуулагддаг. Тооцоо хийгээд үзэхэд В вирустэй хүмүүст хэрэглэж байгаа хепадиз /hepadiz/ нэртэй тариа бий. Нэг ампал нь 300 мянган төгрөгийн үнэтэй. Хагалгааны үед 10 ампалийг хэрэглэдэг. Эхний долоо хоногт өдөр бүр 10 ампалийг хийх шаардлагатай. Тэгээд тооцохоор хагалгааны өртгийн бараг 90 хувийг эм, тариа эзэлж байгаа юм. Тиймээс вирусийг устгах эмчилгээг хийж байна уу, үгүй юу гэдгийг иргэд анхаарч, хяналт тавих хэрэгтэй. Зарим иргэн хямдыг нь бодоод вирусийн эсрэг эмчилгээ хийдэггүй газар очиж элгээ солиулаад ирдэг. Таван жилийн дараа хамаг мөнгөө зарцуулаад тавиулсан элэг нь эргээд хатуурах, В,С вирусийн халдвартай болох эрсдэл өндөр болдог.

-Харин Монголд ямар үнэтэй вэ?

О.Сэргэлэн: -Манай орны хувьд эхний дөрвөн хүний хагалгааг 50 сая төгрөгөөр хийсэн. Тухайн үед бид эдийн засгийн тооцоогоо нарийн гүйцэд сайн гаргаж чадаагүй, баримжаагаар тооцсон. Гэтэл 50 сая төгрөг элэг шилжүүлэн суулгах хагалгааны зардалд яагаад ч хүрдэггүй юм билээ. Сүүлийн зургаа, долоо дахь хүнийхээ хагалгааг хийхээсээ өмнө Нэгдүгээр эмнэлгийн эдийн засаг, санхүүгийнхэнтэй хамтарч тооцоо гаргасан. Тооцоогоор өнөөдрийн ханшаар элэг шилжүүлэн суулгах мэс засал нь 72-75 сая төгрөгт багтаж байна. Ямар ч хүндрэлгүй тохиолдолд шүү дээ. Хэрвээ хагалгааны үед цус алдах зэрэг хүндрэл гарвал өртөг нэмэгдэнэ.

-Хагалгааны дараах эмчилгээнд бас нэлээд зардал хэрэгтэй юм байна. Барагцаалбал хэр их зардал гарах бол?

О.Сэргэлэн: -Хагалгааны зардалд эхний 14 хоногийн эмчилгээ багтдаг. Хэдийгээр төрөөс зарим нэг эмийн үнийг хөнгөлж, заримыг нь үнэ төлбөргүй олгодог ч энэ нь нэг их хөнгөлөлт болж чадахгүй. Хагалгаанд орсны эхний гурван сард 14 хоног тутамд багц шинжилгээ хийлгэх шаардлагатай. Дээрээс нь В вирусийн эсрэг тариа хийлгэх ёстой. Ойролцоогоор сард сая орчим төгрөг шаардагдана. Тиймээс элэг шилжүүлэн суулгах мэс засал хийлгэх гэж байгаа хүмүүс санхүүгийн асуудлаа анхаарч, хагалгааны дараа ч нэлээд мөнгө хэрэгтэйг ойлгох хэрэгтэй.

Хоёрдугаарт, эрхтэн шилжүүлэн суулгуулсан хүмүүс өөрийгөө хамгаалах ёстой. Бид мэс заслыг нь хийгээд, эрчимт эмчилгээнд нь хамруулаад л гаргана. Хяналтаа тавина. Түүнээс гэрт нь очоод хамт амьдрахгүй. Тухайн хүн өөрийгөө халдвараас, бусад хордлогоос сэргийлэх хэрэгтэй. Дээрээс нь хяналтдаа цаг тухайдаа ирэх нь маш чухал. Бие нь жаахан гайгүй болоод ирэхээр монголчууд алга болчихдог. Утсаар дуудахаар завгүй гэдэг. Нэгэнт өндөр зардал гаргаж, өндөр технологиор элэг суулгуулчихаад хариуцлагагүй байж болохгүй. Хэрвээ хувь хүн хариуцлагагүй байх юм бол энэ мэс заслыг хийлгээд хэрэггүй гэж хэлмээр байна.

-Л.Ганболд: -Үнэ өртгийн хувьд өндөр байхаас аргагүй техник технологи ашиглаж байна. Өөрөөр хэлбэл, элэг шилжүүлэн суулгах мэс засал нь өөрөө өндөр технологи. Энэхүү эмчилгээг өөрийнхөө оронд хийлгэх нь бусад орны өртгөөс харьцангуй хямд. Нэгдүгээрт, манай төрөөс иргэдэдээ анхаарч эхэлж байна л даа. Жишээлбэл, бөөр шилжүүлэн суулгах мэс засал хийлгэхэд нэг хүнд 12-13 сая төгрөгийн зардал гарна. Уг хагалгааны 60 гаруй хувийг Эрүүл мэндийн сайдын багцаас олгож байна. Монголд хагалгаа хийлгэсэн хүмүүс монгол эмчийнхээ хяналтад байна гэх мэтээр туршлага нэмэгдэхэд чухал ач холбогдолтой.

“Хотын мээр асан Г.Мөнхбаяр маш том буян үйлдсэн”

-Хагалгааны дараах эмчилгээ хамгийн чухал гэлээ. Тухайн хагалгаанд орсон хүний элгийг хэвийн хэмжээнд оруулах, хяналт үзлэг, асаргаа, сувилгаа, орчин нөхцөл манайд хэр сайн бэлтгэгдсэн бэ. Мөн хагалгааны дараа шинжилгээ, оношилгоог тун

нарийн хийх ёстой байдаг. Манайд тийм нарийн шинжлэх хэмжээнд лобараториудын хүчин чадал хүрэх үү. Манайхан дотоодынхоо шинжилгээ үзлэгт үнэнийг хэлэхэд итгэдэггүй шүү дээ.

О.Сэргэлэн: -Харьцангуй гайгүй хэмжээнд хүрсэн гэж хэлж чадна. Түрүүн Ганболд багш бөөр шилжүүлэн суулгах мэс засал нь элэг шилжүүлэн суулгахын бэлтгэл болсон гэж хэллээ. Ялангуяа лабораторийн хувьд. Бөөр шилжүүлэн суулгасан хүмүүсийг хянадаг, эмийн тунгаа үздэг, эдийн тохироо үзэх, тухайн хүмүүсийг хянах бүх төрлийн лобаротарийн нөхцөл бүрдсэн. Гэхдээ бас бус дутуу зүйл бий. Жишээлбэл, дээр хэлсэн бидний хүсээд байгаа 1.2 тэрбум төгрөгийн дийлэнх хувийг нь лобаротарийн багажууд эзэлж байна. Манайд байгаа хэдэн багаж хэдийнэ үеэ өнгөрөөсөн. Хамгийн наад зах нь хүчил шүлтийн тэнцвэр үүсгэдэг багаж үйлдвэрлэгдэхээ больсон. Үүнд зориулсан уусмал нь олдохгүй байгаа. Одоо энэ багажийг солонгосчууд өөрсдийн багажаар орлуулдаг.

Хяналтын хувьд 24 цагийн хяналттай, нэг минут ч анхаарал сарних эрхгүй. Тухайлбал, элэг шилжүүлсэн хүмүүсээс цусны шинжилгээг хоёр цаг тутамд, дөрвөн цаг тутамд рентген зураг авч, ЭХО-д харж, 2-3 хоногт тархины зураг авч, өөрчлөлтийг хянаж, дор нь засаж, эмчилгээ хийж байна. Хэрэв түүнийг тухайн үед нь засаж амжихгүй л бол суулгасан элэг маань эргээд үйл ажиллагаа нь алдагдах, ховхрох эрсдэлтэй. Энд нөгөө л АСАН төвийнхөн л тусалж байгаа.

-Төрийн зүгээс тусалж, дэмжих санал ирээгүй юу?

О.Сэргэлэн: -Бидний маш их баярлаж, талархаж, баярласан сэтгэлээ илэрхийлэх ёстой хүн бол Улаанбаатар хотын захирагч асан Г.Мөнхбаяр. Өнгөрсөн хавар Сингапур болон бусад орны эрдэмтэдтэй хамтарч, элэгний асуудлаар олон улсын хурал зохион байгуулсан. Энэ хурлын үеэр Г.Мөнхбаяр дарга биднийг биечлэн хүлээн авч, та нарт ямар зовлон байна вэ гэж асуусан. Төрийн өндөрлөгүүдээс хамгийн анх бидэнд хандаж, биднийг сонссон хүн бол Хотын дарга асан Мөнхбаяр, Эрүүл мэндийн сайд асан С.Ламбаа нар юм. Бид Мөнхбаяр даргаас Эрхтэн шилжүүлэн суулгасны дараах Эрчимт эмчилгээний тасаг байгуулахад туслалцаа үзүүлээч гэж гуйсан.

Яагаад гэвэл хагалгаанд орсон өвчтөнөө Нэгдүгээр эмнэлгийн сэхээний тасагт авдаг. Гэтэл тэр тасаг ачаалал ихтэй, хоёрхон ортой, хагалгаанд орсон хүмүүсээ 21 хоногоор авахаар бусад өвчтнийг авч чадахгүйд хүрнэ. Мөн идээтэй, халдвартай гээд төрөл бүрийн өвчтэй хүн ирдэг болохоор тэднээс халдвар авчих гээд үнэхээр хүнд байсан. Харин Мөнхбаяр дарга 140 сая төгрөгийн санхүүжилт олгосноор зарим багаж, тоног төхөөрөмжөө аваад Эрхтэн шилжүүлэн суулгах төвийг Монгол улсад анх удаа байгуулсан гэж хэлж болно. Энэ оны есдүгээр сард элэг шилжүүлэн суулгуулсан хоёр хүн, бөөр шилжүүлэн суулгуулсан гурван хүнийг энэ төвдөө хэвтүүлэн эдгээгээд гаргасан. Дээрээс нь үе шилжүүлэн суулгасан, элэг тайрсан, томоохон хэмжээний тайралт хийсэн өвчтнүүд бүгд манай төвд хэвтэж, 24 цагийн хяналттайгаар эмчилгээ хийж эдгэрээд гарсан. Энэ бол олон хүний амийг аварсан буянтай ажил юм.

-Монголчуудад тусалж байгаа Солонгосын АСАН төвийнхөнд баярлаж, бахархаж байна. Нөгөө талаас монгол эмч нар өөрсдийн хичээл зүтгэлээр ийм амжилт олоод явж байхад төр, засаг нь сонсоогүй мэт царайлж байгаа нь харамсалтай. Эрүүл мэндийн салбарт 1.2-хон тэрбум төгрөг зарцуулж чадахгүй байгааг юутай холбож ойлгож болох вэ?

О.Сэргэлэн: -Анхааралгүй гэж шууд хэлж болохгүй л дээ. Өнгөрсөн жил төрөөс 600 сая төгрөг өгснийг дээр дурдсан. Энд гурван шалтгаан байгаа байх. **Нэгдүгээрт,** манай багийнхан хүмүүст өөрсдийнхөө хийгээд байгаа ажлаа сайн ойлгуулж чадаагүй, энэ чиглэлд сурталчилгаа муу хийсэнтэй холбоотой болов уу. **Хоёрдугаарт,** нийтийг хамарсан өвчин, эмгэг өндөр, эх нялхсын эндэгдэл зэрэг бусад тал руу хөрөнгө зарцуулж байгаа учраас эрүүлийг хамгаалах салбарт өндөр технологи нэвтрүүлэх, хөгжүүлэхэд хөрөнгө хомс байдаг юм болов уу даа гэсэн ойлголттой байна. **Гурав дахь нь** энэ өндөр технологийн талаар ард түмэнд мэдлэг үнэхээр хомс байгаа.

Ер нь ямарваа нэг юм шууд ногоон гэрлээр явна гэж байхгүй. Бэрхшээлийг туулснаар хөгждөг. Сурталчилгааны байгууллагууд энэ талаар бидэнтэй хамтран ажиллаж, ард түмэнд тодорхой ойлголт өгөөсэй, тусалж, дэмжээсэй гэх бодол өөрийн эрхгүй төрдөг. Бид элэг шилжүүлэн суулгах хагалгааны төлбөрөөс ямар нэг урамшуулал, хагалгаа хийсэн шагнал авдаггүй. Бид цалингаа л авна. Тэр мөнгө тухайн өвчтөндөө л зарцуулагддаг. Тангараг өргөсөн эмч бид нарт нэг иргэнийхээ амь насыг аварч, шинэ амьдрал бэлэглэвэл тэр нь бидэнд ирэх том урамшуулал юм даа.

Л.Ганболд: -Эдийн засгийн шингээлт сайтай уул уурхайн компаниуд нийгмийнхээ хариуцлагыг ухамсарлаад, эрхтэн шилжүүлэх салбарыг аваад явчихгүй юм байх даа гэж заримдаа боддог. Нийгмийн хариуцлагын бизнес, нэр хүндэд нь бид тус болно шүү дээ.

-Элэгний өвчнөөр өвдөхгүйн тулд юунд илүү анхаарах вэ?

Л.Ганболд: -Дан ганц элэг ч биш. Эрүүл байхын тулд ариун цэврийг сахих хэрэгтэй. Архи, тамхийг хэрэглэхгүй байх. Монгол хүний элгийг хордуулж байгаа ганц зүйл архи л байна. Эрүүл байхын тулд эрүүл хоол хүнс хэрэглэх, хөдөлгөөн идэвхтэй амьдралыг мөрдөх, эрүүл амьдрах орчин бүрдүүлэхэд анхаарах учиртай.

О.Сэргэлэн: -Хүн өөрөө л эрүүл мэндээ хамгаалах ёстой. Түүнээс чиний эрүүл мэндийг хэн нэгэн хамгаалахгүй. Мөн өвчнөө эцсийн шатанд ортол нь битгий яваач. Эцэст нь төрийн түшээд, бизнесмэнүүдэд хандаж иргэдийнхээ өвчнийг анагааж, элэг шилжүүлэх мэс заслыг өөрийн оронд хөгжүүлэхээр яваа эмч нараа дэмжиж тусалж өгөөч гэж л хэлмээр байна. ■

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ

ТЭГШИТГЭ ЭСВЭЛ...



Б.ЭНХМАРТ

...Өнгөрсөн онд Эрүүл мэндийн даатгалын сангийн хуримтлалын 84.4 хувийг ажил эрхэлж буй иргэд цалингаасаа төлсөн бол төрөөс дөнгөж 9.4 хувь буюу зарлагын 50.9 хувийг эзлэгчдийн өмнөөс өгсөн байгаа юм. Үлдсэн 6.3 хувийг зарлагын, 22.5 хувийг бүрдүүлэгч өөрөө хариуцагч хэсэг төвлөрүүлсэн байдаг...

Иргэний эрүүл мэндийн тухай хуулиараа Монгол улсын иргэн бүр эрүүл мэндийн даатгалын хураамж төлөх үүрэгтэй. Ард түмэн үүргээ биелүүлсээр ирсэн. Тэр бүү хэл, өнгөрсөн онд нийт иргэдийн 98.6 хувь энэ даатгалд хамрагдаж, улсад татвараа өгсөн байгаа юм. Ажилтай нь төр, хувийн хэвшлийнх гэж ялархалгүй сар бүр, цалингаасаа, хөгжлийн бэрхшээлтэй иргэд болон, хилийн цэргийн албан хаагчид, хүүхдээ асарч байгаа эх, 0-18 насны хүүхэд, тэтгэврийн насныхан, ял эдэлж буй хүмүүс гээд нийгмийн дийлэнх хувийг эзлэх иргэдийн даатгалын төлбөрийг төрөөс “дааж” даатгалын санд асуудалгүй шилжүүлж байна. Ажилгүй болон хувиараа бизнес эрхлэгч, МСҮТ-д суралцагчид болон малчид улсаас тогтоосон мөнгийг төлж байж эрүүл мэндийн үйлчилгээ авч байна. Эрүүл мэндийн даатгалын хураамжаа төлөөгүй бол аль ч улсын эмнэлэг таныг хүлээж авахгүй. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хууль сахиулагчид татвараа төлөхийг шаардаж ирснээс биш даатгал төлснөөр иргэд ямар эрх, хөнгөлөлт эдлэхийг ил гаргахыг тэр бүр хүсдэггүй.

Эрх

Эрүүл мэндийн даатгал төлөгч Та ямар эрх эдэлдэг вэ. Иргэний эрүүл мэндийн даатгалын тухай хуулийн долдугаар зүйлд, эрүүл мэндийн тэгш, аюулгүй, чанартай, хувь хүний эрүүл мэндийн бодит хэрэгцээндээ тохирсон, энэ хуульд заасан тусламж, үйлчилгээ авах эрхтэй гэх мэтчилэн урт жагсаалт бий. Харин иргэд ингэж ярьж байна.

Д.Батжаргал: /БЗД-ийн XIV хорооны иргэн/

-Би улсад 23 дахь жилдээ ажиллаж байна. Эрүүл мэндийн даатгалыг 22 жил төлж байна. Ирээдүйн эрсдэлээ даатгаж сар бүрийн цалингаасаа өгсөн миний хөдөлмөрийн хөлс эргээд надад ширхэг эм, тариа ч болж ирэхгүй байна. Тиймээс даатгалд тушаасан мөнгөнийх нь ядаж 10 хувийг өөрт нь зарцуулдаг болмоор байна.

Б.Батдорж: /Чингэлтэй дүүргийн V хорооны иргэн/

-Иргэдэд жилд нэг удаа 30 мянган төгрөгт багтсан урьдчилан сэргийлэх үзлэг, оношилгоо хийх эрх өгдөг гэсэн. Гэвч түүнд нь цус, шээс гэх мэт үнэ төлбөр шаарддаггүй шинжилгээнүүд багтдаг бөгөөд түүнийг өгөх гэхээр ачаалал их байдаг юм билээ. Энэ бол иргэдийг хуурч байгаа хэрэг. Ажил хийдэг нэг иргэн Эрүүл мэндийн санд жилд 30 мянган төгрөгийг хэд дахин нугалж төвлөрүүлж байгаа шүү дээ. Монгол улсад хэрэгждэггүй олон хууль, тогтоомж байдаг ч ажиллаж, хөдөлмөрлөж байгаа иргэдээ мөлжих хуулиуд нь амь бөхтэй мөрдөгдсөөр л байх юм даа.

Б.Болорцэцэг: /ШУТИС-ийн Уул уурхайн сургуулийн IV дамжааны оюутан/

-Хэдийгээр би өөрөө эмнэлэгт үзүүлж, хэвтэж үзээгүй ч эрүүл мэндийн даатгалын асуудалд манай гэрийнхэн бухимдалтай ханддаг. Аав, ээж хоёр маань хувиараа бизнес эрхэлдэг ч жил бүр татвараа төлдөг. Гэтэл өнгөрсөн зун ээж маань хүнд өвдөж, эмнэлэгт хэвтсэн боловч ямар нэг хөнгөлөлт эдлээгүй. Эмчилгээний зардлаа бүгдийг өөрсдөө төлөхийн хажуугаар он гарахаар дахиад л эрүүл мэндийн даатгалын хураамж төлөх болж байгаа юм. Тэр хураамжийг юунд зарцуулах гэж татдагийг ойлгохгүй байна.

Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан даатгуулагчдын үзүүлэлт /хувиар/								
1996	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011
86.0%	84.3%	76.5%	73.4%	79.8%	83.2%	77.6%	82.6%	98.6%

Эрүүл мэндийн даатгалын сангийн үзүүлэлтүүд /тэрбум төгрөгөөр/									
	1996	2000	2005	2006	2007	2008	2009	2010	2011
Орлого	9.1	18.2	32.6	40.3	55.2	64.6	72.4	90.1	121.5
Зарлага	9.9	12.0	23.6	26.5	26.2	50.8	56.9	78.1	87.2

Эрүүл мэндийн даатгалын сангаас эмчилгээ, үйлчилгээ авагчдад зарцуулсан хөрөнгө /тэрбум төгрөгөөр/								
Улсын эмнэлэг Public hospitals								
1996 он	2000 он	2005 он	2006 он	2007 он	2008 он	2009 он	2010 он	2011 он
9337.2	10,984.7	20,393.5	23,022.4	22,500.3	44,125.4	48916.3	62,714.9	68,703.0
Рашаан сувилал Rehabiliation Centers								
261.4	228.9	462.7	524.6	573.4	1,190.8	1507.6	2062.1	2388.44
Хувийн хэвшлийн эмнэлэг Private hospitals								
43.3	558.5	2,154.0	2,416.8	2,549.5	4,639.8	5032.5	11305	13113.4
Эмийн үнийн хөнгөлөлт Discounts on pharmaceuticals								
219.1	252.4	571.1	564.5	564.4	884.4	1486.2	2045.4	2988.3
Нийт								
9,861.0	12,024.4	23,581.3	26,528.2	26,187.6	50,840.4	56,942.6	78,127.4	87,193.2

Эх сурвалж: НДЕГ

Цэнхэр дэвтэр хэрэгтэй юу

Чингэлтэй дүүргийн эмчилгээ эрхэлсэн орлогч эмч Д.Нэмэхбат “Эрүүл мэндийн салбараар үйлчлүүлэгчдийн 80 хувийг төрөөс даатгалын зардлыг нь даадаг хүмүүс эзэлдэг. Харин даатгалын 80 хувийг бүрдүүлэгч хөдөлмөр эрхлэгчдийн 15 хүрэхгүй хувь нь авах ёстой үйлчилгээгээ авдаг. Энэ нь Эрүүл мэндийн даатгалын тогтолцооны гажуудлыг олон тайлбаргүйгээр баталж байгаа юм. Учир нь хөдөлмөр эрхэлдэггүй, хөгжлийн бэрхшээлтэй гээд эрүүл мэндийн үйлчилгээ үнэгүй авах эрхтэй иргэдэд даатгалын цэнхэр дэвтэр нь юу юунаас чухал. Зарим талаараа тэдэнд тэр дэвтэр л байгаа юм чинь бас аргагүй. Гэхдээ үүнийг дагаад эрүүл мэндийн салбарын хөгжил, эмч, ажилчдын чадавх, идэвх, хөдөлмөрийн бүтээмж үгүй болж байна” гэсэн юм.

Тэрбээр “Эрүүл мэндийн даатгалын тогтолцоог эмч, эмнэлгийн ажилчдын цалингийн системтэй уялдуулан шинэчлэх нь эрүүл мэндийн салбарт маш том ахиц авчрах болно. Одоогийн байдлаар улсын эмнэлгүүдэд үнэ төлбөргүй үйлчлүүлэх бүлгийн иргэд л ирж байна. Даатгалаа цалингийнхаа тодорхой хувиар төлж байгаа иргэд эмнэлгийн үйлчилгээ авах гэхээр ачаалал, дарааллаас нь сүрдээд, хувийн эмнэлгийг сонгож байна. Тэдэнд ЭМД-ын цэнхэр дэвтрийн хэрэг алга” гэсэн юм.

Даатгалыг цалинтай уялдуулбал


Нэмэхбат эмчийн санааг дэлгэрүүлэх гээд үзье. Тухайн эмчийн үзсэн хүний төлсөн даатгалаас тодорхой хувь нь эмчид урамшуулал болох системээр явбал эрүүл мэндийн салбарт ахиц гарна хэмээн онцолж байсан. Хийх ажлыг нь цалингийн хөшүүрэгтэй холбоод өгвөл хүн бүхэн илүү сайн ажиллаж, олон хүн үзэж, эмчлэхийг хичээнэ гэсэн юм. Гаднын орнууд ялангуяа БНСУ, Японы эмч нар яагаад сайхан зантай байдаг гэж бодож байна. Даатгалын системийг цалинтай нь холбосон байдаг болохоор тэр. Ирсэн өвчтнийг эрүүл болгож байж явуулахын төлөө яаж хичээдгийг олон жишээнээс харсан. Тэр бүр чинь өөрт нь мөнгө болж орж ирэх учраас л тийм байгаа юм. Харин манайд их ажилласан ч, бага ажилласан ч авдгаа л авна. Сүүлдээ мэргэжилдээ сайн, мэдлэгтэй эмч нар нь хувийн эмнэлгүүд рүү яваад дуусаж байна шүү дээ.

Эрүүл мэндийн салбарт энэ шинэчлэл хэрэгтэй байна хэмээн Нэмэхбат эмч ярьж байсан. Нэг талаар зөв юм. Иргэдийн төлсөн татварын тодорхой хувь өөрийнх нь эрүүл мэндэд ч зарцуулагдаж байгааг мэдэрнэ, үйлчилгээгээ ч авна. Нөгөө талаар даатгалаас урамшуулаад очих хувийг тодорхой зааж өгөхгүй бол Эв санааны зарчмаар явагддаг даатгалын хуулийн эргэх холбоонд асуудал үүсэх магадлалтай аж.

Даатгалын санг нэгжвэл

Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрч буй мөнгө жил ирэх тусам өсөж байгаа бөгөөд өнгөрсөн онд 121 тэрбум төгрөг төвлөрсөн байна. Түүний 68.7 тэрбумыг улсын эмнэлгүүд “залгиж”, 13.1 тэрбумыг хувийн эмнэлэгт хуваарилж, рашаан сувилал, эмийн хөнгөлөлтөд нийт 5.4 тэрбумыг өгч, 33.8 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй ажилласан байна. Дээрх 121 тэрбум төгрөгийн ердөө 20 гаруй хувийг төрөөс өндөр настан, хөгжлийн бэрхшээлтэй иргэд, 0-18 насны хүүхэд гэх мэт эрүүл мэндийн үйлчилгээ үнэ төлбөргүй авах ёстой иргэдэд зориулан өгдөг бол үлдсэнийг нь төрийн болон хувийн хэвшилд хөдөлмөр эрхлэгч, хувиараа төлөгчид бүрдүүлдэг байна. Уг санхүүжилтийн 80 гаруй хувь нь хэвтэн эмчлүүлэх үйлчилгээнд, тав орчим хувь нь өвчлөлтөөс сэргийлэх нийгмийн эрүүл мэндийн хөтөлбөрүүдэд ногддог гэсэн статистик байна.

Харин энэ талаар НДЕГ-ын Эрүүл мэндийн даатгалын хяналт, санхүүгийн газрын мэргэжилтэн М.Энхтуяа “Тухайн онд зарцуулагдах төсвийг, төвлөрөх дүнтэй харьцуулан тооцоолж, улсаас тухайн хөрөнгийг оны эхэнд эрүүл мэндийн байгууллагуудын данс руу шилжүүлдэг. Оны эцэс гэхэд эрүүл мэндийн даатгалын санд төвлөрсөн мөнгийг улсын санд хийх замаар ажилладаг. Эрүүл мэндийн даатгалаа төрөөс төлүүлдэг иргэн эмнэлэгт хэвтлээ гэхэд нэг удаадаа 110-600 орчим мянган төгрөгийн төсөв зарцуулдаг. Энэ нь даатгалаа төлсөн ч эмнэлгийн үйлчилгээ авахгүй байгаа бусад даатгал төлөгчийн мөнгөөр бүрдэж буй юм. Өнөөдрийн хөдөлмөр эрхлэгч, даатгал төлөгч иргэд хэдэн жилийн дараа





Эх сурвалж: НДЕГ

тэтгэвэрт гарна. Тэр үед одоогийн системээр тухайн үеийн залуу хүмүүсийн даатгалын мөнгөөр эмчлүүлнэ гэсэн үг шүү дээ. Нэг нэгнийгээ нөхөх замаар л явагдаж байгаа нийгмийн харилцаа юм” гэсэн.

Тэгшитгэ

Өнгөрсөн онд эрүүл мэндийн даатгал төлөгчдийн 84.4 хувийг ажил эрхэлж буй иргэд цалингаасаа төлсөн бол төрөөс дөнгөж 9.4 хувийг төлдөг. /Энэ нь эрүүл мэндийн үйлчилгээ авч буй иргэдийн 50.9 хувийг эзэлдэг./ Үлдсэн 6.3 хувийг зарлагын 22.5 хувийг бүрдүүлэгч өөрөө хариуцагч хэсэг Эрүүл мэндийн даатгалын санд төвлөрүүлсэн байдаг. Хамгийн гол нь хөдөлмөр эрхлэгчид олсон орлогынхоо хэмжээгээр татвар төлж байхад, төр болон өөрөө хариуцагч иргэд өнгөрсөн жил сард 670 төгрөг буюу жилийн 8040 төгрөгийн татвар төлсөн байгаа юм.

Хөдөлмөр эрхлэгчийн хувьд гол харламаар, барьцмаар тоо дээрх баримтаас харагдаж байгаа биз ээ. Үүнийгээ Эв санааны зарчмаар явж буй даатгал хэмээн бодлого тодорхойлогчид хэлдэг. Тэгвэл ардчилсан, зах зээлийн эдийн засагтай орны хувьд энэ системийг тэгшитгэх боломжтой юм. Бүх иргэн ижил хэмжээний татвар эрүүл мэндийн даатгалд төлнө. Цалингийн их, багаас үл хамааран улсаас тогтоосон татварыг төлөөд л гүйцээ. Эрүүл мэндийн салбарт ажиллагсад ч дандаа бага татвар төлөгч ирлээ гэж голонгуй суухгүй болох ч юм бил үү. ■

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН АСУУЛТ

Энэ дугаарын хөндөж буй онцлох сэдвийн хүрээнд бид Монголд элэг шилжүүлэн суулгах мэс засалд орсон иргэдийн төлөөллөөс сэтгэгдлийг нь сонссон юм.

Монгол эмч нар туршлагажиж байгаа

н.Гантуяа: *-Миний бие өнгөрсөн хоёрдугаар сард элэг шилжүүлэн суулгах хагалгаанд орсон.*

Мэс заслын өмнө хаван ихтэй, нүд шар туяатай, бие их муу байсан. Элэн шилжүүлэх мэс заслын дараа эмч нарын зөвлөгөөг дагаж, хоолны дэглэм чандлан сахихаас гадна эм, тариагаа цаг тухайд нь хэрэглэсний дүнд биеийн байдал дороо сайжирсан. Хагалгааны дараа цөсний суваг нарийсах, бөглөрөх явдал их байдаг учраас тэдгээрээс сэргийлэх эм үргэлж уудаг. Түүнчлэн цусанд байгаа В, С вирусийг донор элгэнд халдаахгүйн тулд вирус, үрэвслийн эсрэг мөн дархлаа дарах эм хэрэглэдэг. Эхэндээ тариа их хийлгэдэг байсан бол одоо биеийн жиндээ тохируулж эмийн тунгаа өөрчлөн уудаг болсон.

Монголдоо хагалгаа хийлгэх болсон хэд хэдэн шалтгаан бий. Би Японд докторын зэрэг хамгаалахаар сурч байсан юм. Тухайн үед элэг муудсан, хагалгаа хийлгэх шаардлагатай байгаагаа мэдэж байсан л даа. Тэнд ажиллаж, амьдарч байгаа гэдэг утгаараа эмчилгээний зардлын 50 хувийг даатгалаас төлүүлэх боломжтой байдаг учраас Японд мэс засалд орох бодолтой байсан. Гэтэл тухайн үед болсон Японы газар хөдлөлт, цунамигаас болж эх орондоо ирсэн. Японд элэг шилжүүлэн суулгах мэс засалд орох боломжийг хаасан өөр нэг зүйл бол тус улсын хуулинд цусан төрлийн хүн нь донор болно гэж заасан байдаг юм. Хамаатан садангийн хүүхдүүд донор болохгүй гэсэн үг.

Монголд ирээд биеийн байдал эрс муудсан. Ингээд Хавдар судлалын үндэсний төвд хандахад “Эмнэлгийн заалтад биеийн эрүүл мэндийн байдал хэт хүндэрсэн хүнийг хүлээж авахгүй” гэсэн байдаг тул хэвтүүлэн эмчлэх боломжгүй гэсэн хариу өгсөн юм. Хэсэг хугацаанд хувийн эмнэлгүүдэд эмчлүүлж байгаад Нэгдүгээр эмнэлгийн элэгний тасагт шилжин, элэг шилжүүлэн суулгах хагалгаанд орох шаардлагатай 46 дахь хүн болсон. Манайд донорын олдоц муу байдгаас гадна цусан төрөл байхыг шаарддаг. Харин 2012 оны долдугаар сарын 1-нд Донорын тухай хуульд өөрчлөлт оруулснаар цогцосноос донор авахыг зөвшөөрсөн. Одоо энэ асуудал арай хялбар болох байх гэж найдаж байна.

Тухайн үед Монгол, Солонгосын эмч нар хамтарч хийж байгааг дуулаад эх орондоо энэ хагалгаанд орохоор шийдэж, тэдэнд итгэл хүлээлгэсэн. Одоогоор долоон хүн энэ хагалгаанд орсон байгаа гэж сонссон. Бидний өвчин нэг талаар Монгол эмч нарт туршлага өгөх туршилт болж байгаа бол нөгөө талаар монголчууд харийн орныг зорин энэ өндөр өртөгтэй хагалгааг хийлгэх шаардлагагүй болох ач холбогдолтой билээ.


Элэг шилжүүлсэн иргэдээ төр бодлогоор дэмжээсэй

Д.Мөнхжаргал: /46 настай/

-Хагалгаанд орохоос өмнө их зовиуртай, олон төрлийн эм их уудаг байсан. Монгол эмч нартаа итгэж байсан болохоор эх орондоо хагалгаанд орохоор шийдсэн. Хагалгааны өртөг ч харьцангуй хямд шүү дээ. Элэг шилжүүлэн суулгах хагалгааг хийх чадварлаг эмч олон бий. Сүүлийн 2-3 жил элэгний өвчин манайд газар авч байна. Энэ утгаараа эмч нарын чадварын асуудал яригдах болж. Хагалгааг Монгол, Солонгос эмч нар хамтарч хийсэн. Тухайн үед элэг шилжүүлэн суулгах хагалгаанд шаардагдах тоног төхөөрөмж бүрэн байгаагүй. Өртөг өндөртэй төхөөрөмж, багаж хэрэглэдэг болохоор төсөв мөнгө нь хүрдэггүй гэж байсан ч зарим шаардлагатай төхөөрөмжөө авсан гэж дуулсан.

Дотооддоо элэг шилжүүлэх хагалгаа хийлгэх гэж буй иргэдэд зөвлөхөд манай эмч нар чадвартай. Тэдэнд итгэх хэрэгтэй. Мөн хагалгаанд зарцуулагдах төсөв гадны орнуудыг бодоход маш хямд тусна шүү гэж хэлмээр байна. Мөн төрөөс элэг шилжүүлэн суулгах хагалгаанд орсон хүмүүсээ дэмжих халамжийн бодлого хэрэгжүүлээсэй. Бөөр шилжүүлэн суулгасан өвчтөнүүд төрийн халамжийг сайн хүртдэг юм билээ. Тэгэхээр тэднээс хэд дахин илүү зардалтай элэг шилжүүлсэн иргэдээ төр бодлогоор дэмжих байх хэмээн итгэн хүлээж байна. ■





ЖОН КЕННЕДИ
АЛАГДААГҮЙСЭН БОЛ

Орчуулсан Ж.ТҮМЭНБАЯР

Одоогоос 49 жилийн өмнө, 1963 оны арваннэгдүгээр сарын 22-нд АНУ-ын Ерөнхийлөгч Жон Ф.Кеннедиг Даллас хотноо буудан хөнөөсөн билээ. Тэр үеэс өнөөдрийг хүртэл Кеннеди амьд байсан бол, аллагад хэн хамаатай вэ, Кеннедийг яагаад алахад хүрэв зэрэг асуулт хариулт нэхсээр л байна. Түүний үхлийг 1964 онд АНУ-д болсон гурван түүхэн үйл явдалтай холбон тайлбарладаг. Тодруулбал, 1964 оны Ерөнхийлөгчийн сонгууль, Вьетнамын дайны өрнөл, түүхэн баримт бичгүүд болох “Иргэний эрхийн тухай”, “Сонгох эрхийн тухай” хуулиудыг батлах үйл явц, Кеннедийг амьд байсан бол хэрхэн явагдах байсан тухай хүмүүсийн дэвшүүлсэн онол, таамаглалууд. Түүнийг нас барсны дараа өрнөсөн энэ хэргүүдийн тухай таамаглал өнөөг хүртэл нийтийн дунд оньсого мэт сонирхолтой, таавар хэвээр байна.

Кеннеди 1964 оны сонгуульд нэрээ дэвшүүлж байсан ба түүхч, судлаачид түүнийг сонгуульд ялах магадлал маш өндөр байсан гэж үздэг. Аллагын өмнөхөн, Ерөнхийлөгчийн алба хашиж эхэлснээс нь хойших 1000 хоногийн дараа явуулсан урьдчилсан судалгаагаар ард иргэдийн 58 хувийн саналыг тэр авч чадсан нь Ричард Никсон, Рональд Рейган, Билл Клинтон, Жорж Буш, Барак Обама нарын рейтингийг хол хаясан үзүүлэлт юм.

Ли Харвей Освальд буруутан мөн үү?

Аллага болсноос хойш цаг гаруйн дараа Ли Харвей Освальд цагдаа Ж.Д.Типпитийг алсан хэргээр баривчлагдсан. Гэрчийн мэдүүлснээр Освальдыг аллага болсон газраас таван км орчимд явж байхад нь эргүүлийн цагдаа таньж, машин дотроосоо дуудан, түүнийг хоргооход Освальд цагдааг дөрөв буудаж хөнөөсөн байдаг. Алуурчны хаашаа явахыг нь алдалгүй тандсан зэргэлдээх дэлгүүрийн менежер Ж.Бревер, Техасын театрын тасалбар түгээгч хоёр цагдаа дуудан түүнийг баривчлуулж амжсан байна. Тэр даруй Освальдыг Ерөнхийлөгч, цагдаа

хоёрын аллагад буруутган байцааж эхэлсэн боловч тэрбээр хэргийг эрс үгүйсгэснээр барахгүй “Зөвлөлтөд байсан болохоор л та нар намайг золигт гаргаж байна” хэмээн зарга мэдүүлж байжээ.

Хоёр хоногийн дараа Освальдыг Далласын мужийн шоронд хүргэхээр машинд суулгах үед Жек Руби гэгч буудсанаар ерөнхийлөгчийн аминд хүрсэн байж болох цорын ганц сэжигтэн газар дээрээ үхсэн байна. Ж.Рубиг тэр даруй баривчилсан ч эмчийн мэдрэлийн өвчтэй гэсэн дүгнэлтээр шүүх ажиллагаа удаа дараа хойшлогдсоор 1967 онд тэрбээр бөөрний өвчнөөр эмнэлэгт нас барсан юм. Иймээс Ерөнхийлөгчийг хөнөөсөн хэрэгтнийг илрүүлэх, шүүх, жинхэнэ гэмтнийг эцэслэн тогтоох боломжгүй болсон юм.

Гэхдээ Засгийн газрын харъяаны дөрвөн байгууллага, тухайлбал Далласын Цагдаагийн газар, Холбооны мөрдөх товчоо, Конгрессын дэргэдэх Аллагын асуудал хариуцсан тусгай хороо, Уоррений комисс Ли Харвей Освальдыг АНУ-ын 35 дахь Ерөнхийлөгч Жон Ф.Кеннедийн амь насыг хохироосныг мөрдөн байцаалтдаа үндэслэн тайлбарласан билээ.

Аллагын тухай мөрдөн байцаалтууд

Далласын Цагдаагийн газарт арваннэгдүгээр сарын 22-24-нд Освальдыг 12 цагийн турш байцаасан ч тэр хэргээ хүлээгээгүй байдаг. Байцаалтын хүрээнд ойрын үед галт зэвсэг хэрэглэсэн эсэхийг нь шинжлэх ухааны үүднээс тогтоох зорилгоор гар ба баруун хацарт нь параффины сорил явуулсан ч гарынх нь хариу эерэг, хацрынх нь сөрөг гарсан тул хөдлөшгүй нотлох баримт гэж үзэх үндэслэлгүй болж, Уоррений комисс сорилын үр дүнд цаашид ач холбогдол өгөөгүй. Байцаалтаар Освальдаас ямар нэг тодорхой мэдээлэл авч чадаагүйгээс гадна Холбооны мөрдөх товчооныхон мөрдөн байцаах ажилд хөндлөнгөөс оролцож байсан, Освальд алагдсан зэрэг шалтгаанаар байцаалтыг дуусгах боломжгүй болжээ.

Холбооны мөрдөх товчоо 1963 оны арванхоёрдугаар сарын 9-нд тайлангаа гаргаж, Уоррений комисст хүргүүлсэн. Тэд аллагын үед гурван удаа буудсан гэсэн дүгнэлт гаргасан байв. Уоррений комисс гурав буудсан гэдэг дээр санал нийлсэн ч чухам хэд дэх сум ерөнхийлөгчийг, хэд дэх нь амбан захирагчийг оносон бэ гэдэг дээр санал зөрсөн. Товчооны дүгнэлтээр нэг дэх сум Кеннедиг, хоёр дахь нь Коналлиг, гурав дахь нь дахин Ерөнхийлөгчийн толгойд тусаж үхэлд хүргэсэн гэж тогтоосон бол Уоррений комисс гурван сумны нэг нь хий тусаж, хоёр дахь нь эхэлж ерөнхийлөгчийг оноод дараа нь Конналиг оносон бол гурав дахь нь ерөнхийлөгчийн толгойд тусаж үхэлд хүргэсэн гэж үзсэн.

Уоррений комисс нь 1963 оны арваннэгдүгээр сарын 29-нд Кеннедийн аллагын асуудлаар Ерөнхийлөгч Л.Жонсоны дэргэд байгуулагдсан тусгай комисс юм. Комисс 888 нүүр бүхий тайлангаа 1964 оны есдүгээр сарын 24-нд Л.Жонсонд хүргүүлсэн ба түүнд Ерөнхийлөгчийг алж, амбанг шархдуулахдаа Освальд дангаар ажилласан. Ж.Руби ч мөн дангаар ажиллаж, Освальдыг алсан гэж дүгнэсэн.

Конгрессын дэргэдэх Аллагын асуудал хариуцсан тусгай хороо Холбооны мөрдөн байцаах газар, Уоррений комиссын дүгнэлтийн аль аль нь хуудуутай гэж үзэн, Ерөнхийлөгч Кеннеди ямар нэг хуйвалдааны үр дүнд алагдсан гэж дүгнэсэн. Тусгай хороо Освальдаас өөр ямар нэг хувь хүн, бүлэглэлийг хэрэгт хамааруулаагүйгээс гадна Тагнуулын төв газар, ЗХУ, эсвэл ямар нэг зохион байгуулалттай гэмт хэргийн бүлэглэл хэрэгт хамааралгүй гэж онцлон мэдэгдсэн. Гэвч тэдгээр бүлэглэлийн хэн нэг бие даасан гишүүний оролцоо байж болохыг няцаагаагүй.

Хуйвалдааны талаарх онол, таамаглал

Бүр эхнээсээ л мянга мянган хүн хэргийн ар талд буу онилсон ганц этгээд биш, ямар нэг нууц хуйвалдаан байгаа гэж таамаглаж байв. Албан судалгаагаар иргэдийн 52 хувь нь аллагад “Ямар нэг бүлэглэл эсвэл элемент” хамаатай гэж гарчээ. Тэр ч бүү хэл, Освальд хэргийг дангаар үйлдсэн гэж Уоррений комисс дүгнэлт гаргахаас өмнө хэргийн цаана “хуйвалдаан” буй гэх таамаглал бүхий хэд хэдэн ном хэвлэгдээд амжсан байв. 1964 оны есдүгээр сард комисс дүгнэлт гаргахад америкчуудын 31.6 хувь нь дүгнэлтийг эсэргүүцэж, 55.5 хувь нь зөвшөөрч байсан бол дараа дараагийн судалгаанаас харахад ард иргэдийн олонх нь “хуйвалдаан”-ы тухайд итгэлтэй байх болсон.

Освальдын эрх ашгийг хамгаалуулахаар эх Маргаретынх нь хөлсөлсөн өмгөөлөгч Марк Лэйний 1966 онд хэвлэгдсэн “Шударга шийдвэрийн төлөө” номд Уоррений комиссыг “Нотлох баримт гүйцэд бүрдээгүй байхад хэт өрөөсгөл талыг барьсан дүгнэлт гаргасан” гэж буруутгаад, Ерөнхийлөгчийг оносон сумуудыг хэд хэдэн чиглэлээс буудсан тул энэ бол гарцаагүй хуйвалдаан гэсэн таамаг дэвшүүлсэн. Орчин үед хийсэн олон тооны судалгаа, шинжилгээний ихэнх нь аллагын талаар комиссоос гаргасан албан ёсны дүгнэлт эерэг өнцгөөс нь харвал алдаа мадагтай, харин эсрэг өнцгөөс ердөө л санаатай гаргасан хуурамч дүгнэлт гэдэгтэй санал нийлж байна. Аллагын талаарх янз бүрийн онол, таамаг бүхий шуугиан тарьсан ном, нийтлэл, телевизийн мэтгэлцээн одоо ч өрнөсөөр... 2007 оны байдлаар энэ хэрэгт хамаарах 1000 орчим ном хэвлэгдэн гарсны 95 хувиас илүү нь хуйвалдааны асуудлыг хөндсөн байгаа нь дээрхийг баталж буй хэрэг юм.

1990 оноос өмнө уг сэдвээр гарсан бүтээлээс 1980 онд хэвлэгдсэн Антони Саммерийн “Хуйвалдаан”, Дэвид Лифтоний “Хөдөлгөөнгүй баримт”, 1985 онд хэвлэгдсэн Хэнри Хуртийн “Үндэслэлтэй эргэлзээ” зэргийг онцлон дурдах нь зүйтэй. Саммер, Хурт нарын номд тухайн цаг үед олон нийтийн анхаарлыг маш ихээр татсан хуйвалдааны янз бүрийн онол, таамаглалыг дэвшүүлсэн бол Лифтон номдоо хэргийг Освальдад зохиомлоор тулгах үүднээс

Ерөнхийлөгчийн үхлийн шархыг задлан хийхээс өмнө өөрчилсөн гэж нотолсон. Мөн 1989 онд хэвлэгдсэн Роберт Ж.Гордений “Урван тэрслэлт” номд Кеннедийн толгойн шархуудыг нэг буунаас буудсан мэт харагдуулахын тулд задлангийн фото зургуудыг өөрчилсөн тухай үндэслэл бүхий таамаг дэвшүүлсэн.

1992 онд олон нийтийн шахалтаар Конгресс “Ж.Ф.Кеннедийн хэргийн баримтын тухай тогтоол”-ыг баталсан ба уг тогтоолын дагуу “Аллагын баримт хянах зөвлөл”-ийг байгуулж, аллагад хамаарах бүх төрлийн нууц баримт сэлтийг олон нийтэд задлах эрхийг олгосноор 1992-1998 оны хооронд урьд нь задлаагүй дөрвөн сая нүүр бүхий 60.000 орчим баримт материал олон нийт, судлаачдын хүртээл болсон байна. Хэрэгт хамаарах үлдсэн бүх баримтыг 2017 он гэхэд бүгдэд задлах ажээ.

Сонгууль 1964 ба Иргэний эрхийн тухай хууль

Бүгд Найрамдах намаас 1963 оны эцэст Ерөнхийлөгчийн сонгуульд нэр дэвших хамгийн боломжтой хүн бол сенатор Бэрри Гоулдватер байв. Тэрбээр Кеннедийн дотны нөхдийн нэг байсан ба аллагын дараа хэсэгхэн хугацаагаар сонгуулиас нэрээ татсан боловч тун удалгүй, зөвхөн өөрийн үл таашаадаг улс төрийн зүтгэлтэн Линдон Жонсонтой өрсөлдөхийн тулд эргэж нэрээ дэвшүүлсэн байдаг.

Аллагын өмнөхөн Цагаан ордонд зөвлөхүүдтэйгээ ярилцаж байхдаа “Иргэний эрхийг дэмждэгийн улмаас сонгууль ихээхэн өрсөлдөөнтэй болох төлөвтэй байгаа” тухай Кеннедийн хэлж байсан нь бичигдэн үлджээ. Уг хууль Конгресс дээр ширүүн эсэргүүцэлтэй тулгарсан. Ялангуяа нийтийн үйлчилгээний газруудад арьсны өнгөөр ялгаварлах явдлыг урьдын адил хэвээр үлдээх гэсэн өмнөдийн ардчилагчдын оролдлогыг Кеннеди эрс няцааж байж. Кеннедийн алагдсаны дараа Ерөнхийлөгч Жонсон бүх ард түмэндээ хандаж “Иргэний эрхийн тухай хуулийг нэн даруй батлах нь түүний Кеннедийн ард түмэндээ үлдээсэн өвд үзүүлж буй дээд зэргийн хүндэтгэлийн илэрхийлэл байх болно” гэж мэдэгдсэн ч Жонсон, түүний холбоотнууд уг хуулийг батлах хүртэл нэлээд сунжирч, 1964 оны долдугаар сард сая нэг батлагдсан байдаг.

Хэрэв Кеннеди амьд байсан бол “Иргэний эрхийн тухай хууль”-ийн талаарх мэтгэлцээн сонгуулийн жил явагдах байсан уу, үгүй юү гэдэг нь эргэлзээтэй. Зарим судлаач хууль батлах асуудлаар Конгрессоос харьцангуй илүү дэмжлэг авах боломжтой болно хэмээн найдсаны үндсэн дээр, Ерөнхийлөгч уг хуулийг батлах асуудлыг 1964 оны сонгууль өнгөртөл хойшлуулах байсан болов уу гэж үздэг. Кеннеди, Жонсон хоёр хоёулаа байсан бол хууль батлах явц зогсонги байдалд орж, удаан хугацааны сунжирсан мэтгэлцээн өрнөх байсан гэх таамаг ч бий. Чухамдаа, Жонсон Конгрессийн гишүүдийн дунд үлдсэн Кеннедийн нөлөө, итгэл үнэмшил төрүүлэх онцгой ур чадварыг өөрт олгогдсон эрх хэмжээтэй хослуулан ашигласнаар 1964 онд “Иргэний эрхийн тухай хууль”, 1965 онд “Сонгох эрхийн тухай хууль”-ийг батлуулах боломжтой болсон юм.



Огноо, цаг: 1963.11.22. 12:32 цаг
Халдлагын бай: Жон Кеннеди

Халдлагын төрөл: Мэргэн бууч

Халдлага үйлдсэн зэвсэг: 6.5 Ч 52 мм-ийн Италид үйлдвэрлэсэн Carcano M91/38

Алагдсан: Алагдсан 1 (Ерөнхийлөгч Кеннеди)

Шархадсан: Шархадсан 2 (Техас мужийн амбан захирагч Коннали, Жеймс Тэйгу)

Буруутан: Ли Харвей Освальд

Вьетнам ...

Аллагын өмнөхөн Ази яваад ирсэн хоёр зөвлөхтэйгээ ярилцсан Кеннедийн ярианаас тэрбээр Вьетнамын асуудлаар ихээхэн сэтгэл зовниж байсан нь илт харагддаг. Ярианы үед Кеннеди зөвлөхүүдээсээ “Та нарын нэг нь болохоор Вьетнамын асуудал наашгайгаар эргэж байгаа гэх. Нөгөө нь улс төрийн байдал доройтож байна гэх. Эдгээр мэдээлэл яагаад өөр хоорондоо ийм их ялгаатай байгаа талаар би тайлбар авахыг хүсч байна” хэмээн

нэлээд ширүүн тулгаж асуусан байдаг. 1964 оны дөрөвдүгээр сард дүү Роберт Кеннеди нь Вьетнамын талаарх ахынхаа үзэл баримтлалын талаар дурсахдаа “Вьетнамыг бид Коммунистуудад алдаж болохгүй. Вьетнамыг алдах нь Зүүн Өмнөд Азийг бүхэлд нь алдсантай адил. Энэ тэмцэлд бид заавал ялах ёстой” гэж хэлснийг нь онцолжээ.

Ерөнхийлөгч Кеннедийг алуулахаас ердөө гуравхан долоо хоногийн өмнө АНУ-ын шууд бус дэмжлэгтэйгээр Өмнөд Вьетнамын цэргийн эрхтнүүдийн хийсэн төрийн эргэлтийн үеэр Өмнөд Вьетнамын Ерөнхийлөгч Нхо Динх Дием алагдсан аж. Тэрбээр коммунизмыг эрс эсэргүүцэгч байсан тул Францын цэрэг Вьетнамаас гарсны дараа тус улсын ерөнхийлөгч болоход нь АНУ-ын дэмжлэг их түлхэц үзүүлсэн. Гэвч хойшид улс орондоо шашны талаар, тухайлбал Буддизмын эсрэг явуулсан бодлогын улмаас нэр хүнд нь унаж, тэр нь улмаар Вьетнам дахь АНУ-ын нэр хүндэд ч мөн сөргөөр нөлөөлөх болсон, Америкийн ямар нэг нөлөөгүйгээр улс орноо бие даасан бодлогоор хөгжүүлэх гэсэн сонирхол зэрэг нь америк “ах нарынх” нь таалалд нийцэхээ больжээ. Иймд Өмнөд Вьетнамын цэргийн эрхтнүүд Ерөнхийлөгчийнхөө эсрэг хуйвалдаан зохион байгуулах үед АНУ-ын Тагнуулын төв газар хөндлөнгөөс оролцохгүй гэсэн нууц баталгаа гаргаж өгснөөс гадна хуйвалдаанд санхүүгийн дэмжлэг үзүүлжээ.

Кеннеди алагдсаны дараа жилээс Вьетнамын нөхцөл байдал хурдацтай доройтсоны улмаас, 1964 оны наймдугаар сард “Тонкиний булангийн шийдвэр”-ийг Конгресс бараг санал нэгтэй баталснаар Ерөнхийлөгч Л.Жонсон АНУ-ын их хэмжээний цэргийн хүчийг дайн зарлалгүйгээр Вьетнамд оруулах боломжтой болжээ. Тэгвэл судлаачдын зарим нь Жонсоны оронд Кеннеди байсан бол асуудлыг аль болох дипломат аргаар шийдвэрлэхийг эрхэмлэх байсан гэж үздэг. Энэ нь 1966 оны эцэс гэхэд Вьетнамаас цэргээ бүрмөсөн гаргахаар төлөвлөж байснаас харахад үнэнд илүү ойр таамаг юм. 1963 оны арваннэгдүгээр сарын 20-ны өдөр боловсруулсан төлөвлөгөөнд ч онцгойлон үзэхүйц шалтгаан гарахгүй л бол 1965 оны сүүлч гэхэд цэргийн хүчээ Вьетнамаас бүрэн гаргах тухай тусгасан байдаг. Гэхдээ Кеннедийн аллага болох үед Диемийн цэргийн эргэлтийн үр дагавар тодорхойгүй байсан учраас 1964 он буюу сонгуулийн жил Ерөнхийлөгч Кеннеди Вьетнамын талаар ямар шийдвэр гаргах байсныг одоо хэлэх аргагүй.

Иймхүү Кеннедийн аллага, түүнтэй холбоотой бусад асуудал нь өнөөг хүртэл өргөн хүрээг хамарсаар ирсэн билээ. ■

eznis airways

ХААН БАНК
ЭРХЭМ ТАНЫ ИТГЭЛТ АНД

1000₮
төлөөд нис

Та Изинис Эйрвэйз компанийн нислэгээр ХААН Банкны зээлийн үйлчилгээнд хамрагдаж өдөрт 1000 хүртэлх төгрөг төлөөд нисээрэй. Дэлгэрэнгүй мэдээллийг манай тийз борлуулалтын салбаруудаас аваарай.

333311
ТИЙЗ ЗАХИАЛАХ УТАС

8 Зовхис Билдинг, 1-р давхар, Сөүлийн гудамж 21, Сүхбаатар дүүрэг,
Улаанбаатар хот 14251, Монгол Улс
Утас: +(976-11) 333311, Факс: +(976-11) 331514, И-мэйл: feedback@eznis.com
www.eznisairways.com

КОМПАНИЙН ЗАСАГЛАЛ

М.БОЛД: САЙН ЗАСАГЛАЛТАЙ КОМПАНИ ИТГЭЛТ АНДТАЙ АДИЛ

Б.УУГАНБАЯР

...Банкны салбар олон мянган аж ахуйн нэгж, иргэний хадгаламжийг өөртөө төвлөрүүлж, итгэлийг нь хүлээж байдаг учраас асар өндөр хариуцлага үүрдэг. Тиймээс иргэдийн мөнгөн хөрөнгийг үрэгдэж шамшигдахаас, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх давхар хамгаалалт хийх ёстой.

Монголын банкны салбарын засаглал ямар түвшинд байгаа болон тулгамдаж буй асуудал, түүнээс гарах арга замын талаар "Тэнгэр санхүүгийн нэгдэл" компанийн гүйцэтгэх захирал, Монголын банкны холбооны ерөнхийлөгч М.Болдтой ярилцлаа.

-Манай банкуудад засаглал сайн бэхжиж эхэлж буйг та онцолж байсан. Энэ талаар сонирхуулахгүй юу?

-Булган аймагт байдаг манай нэг харилцагч "Банк гэдэг бол хариуцлага юм, зээл бол итгэл юм" гэж хэлж байсан. Эндээс банкны үүрэг хариуцлага тодорхой харагдаж байна. Банкны салбар олон мянган аж ахуйн нэгж, иргэний хадгаламжийг өөртөө төвлөрүүлж, итгэлийг нь хүлээсэн байдаг учраас асар өндөр хариуцлага үүрдэг. Тиймээс иргэдийн мөнгөн хөрөнгийг үрэгдэж шамшигдахаас, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх давхар хамгаалалт хийх ёстой. Үүнд хувь нийлүүлэгчид болон гүйцэтгэх захирал хоорондын гүүр болж өгдөг ТУЗ-ийн зөв зохион байгуулалт, үүрэг оролцоо хамгаас чухал. Нөгөө талаас компанийн хөрөнгө мөнгө өсөж, арвижих эсэхийг бүрэн хариуцаж байдаг гүйцэтгэх удирдлага чадварлаг, ил тод, нээлттэй, ёс зүйтэй байх ёстой. Хувь нийлүүлэгч, ТУЗ, гүйцэтгэх удирдлага гурвын харилцаа зөв зохион байгуулалттай, эрх тэгш байж чадвал сайн засаглалтай компани болж буйн шинж. Нэг ёсондоо дээрх гурван тал тулгын гурван чулуу байх ёстой.

Дээр нь ёс зүйн болон ашиг сонирхлын зөрчлийг зохицуулах дүрэм, журам манай банкуудад нэвтэрч эхэлж буй. Банкны үйл ажиллагаа Компанийн тухай хуулийн зэрэгцээ Банкны тухай хуулиар өндөр шаардлага тавьж зохицуулдаг учир засаглалаа сайжруулахад түлхүү анхаарал тавьж чадаж буй юм. Хэрэв засаглал муу байвал тухайн банк богино наслаж, дээр нь иргэдийн эрх зөрчигдөж, хохирдог гэдгийг бид өнгөрсөн жилүүдэд цөөнгүй жишээгээр харсан. Тухайлбал, манайд банкны 38 лиценз өгснөөс одоогийн байдлаар 14 банк л үйл



ажиллагаагаа явуулж буй. Тэгэхлээр цаана 24 банк засаглал муутайгаасаа ул мөргүй алга болсон гэсэн үг.

-Бусад оронтой харьцуулахад манай банкны салбарын хөгжил, засаглал ямар түвшинд явж байна вэ?

-Манай банкууд дэлхийн сайн туршлага болж яваа улсуудын засаглалын хэмжээнд хүрэх бүрэн боломжтой. Тухайлбал, олон улсын байгууллагуудын тэргүүн туршлага, бичиг баримтуудыг судлах ч бололцоо бий. Манайд энэ чиглэлээр гадаад, дотоодын байгууллагууд сургалт, сурталчилгааны үйл ажиллагаа явуулаад эхэлчихсэн болохоор мэдээллийн урсгал бидэнд нээлттэй байна. Түүнчлэн ихэнх банкны ТУЗ-

д гадаадын экспертүүд ажиллаж буйгаараа онцлог юм. Олон улсын санхүүгийн корпорациар манай дотоодын хоёр банк үнэлүүлэхэд сайн гэсэн үнэлгээ авсан. Дээрээс нь АНУ-ын Олон улсын хөгжлийн агентлагийн "Бизнесийг дэмжих санаачилга" төслөөс банкуудын засаглалыг үнэлэх аргачлалыг гаргасан. Монголын банкны холбооны зүгээс энэ аргачлалыг ашиглаж, засаглалынх нь түвшинг өөрсдөөр нь үнэлүүлэхээр ажиллаж байна.

-Банкууд засаглалаа илүү сайжруулахын тулд юуг голлон анхаарах ёстой вэ?

-Зах зээлийн харилцаанд шилжих эхний жилүүдэд банк шинээр байгуулагдахад эзэн нь өөртөө үйлчлэх ёстой мэтээр боддог байсан. Энэ бол мэдээж маш бүдүүлэг ойлголт. Үүнийг гадаадад "халаасны банк" гэж нэрлэдэг. Хууль дүрмээр ч үүнийг хориглосон. Хувь нийлүүлэгч тухайн банкнаасаа бага хүүтэй зээл богино хугацаанд авдаг, эсвэл шимтгэл төлөлгүй

САЙН ТУРШЛАГА

ТУРШЛАГАТАЙ ТУЗ

Гол бизнес, эрхэлдэг үйл ажиллагаа:

"Тэнгэр санхүүгийн нэгдэл" ХХК нь санхүүгийн иж бүрэн үйлчилгээг иргэдэд тэгш байдлаар хүргэх зорилготой, банк, даатгал, хөрөнгийн зах зээл, лизингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг компаниудын нэгдэл юм. Тус нэгдэлд "Хас банк", "Хаслизинг", "Тэнгэр даатгал", "ХасСекьюрити", "Тэнгэр капитал" зэрэг компани багтдаг.

САНХҮҮГИЙН ТОВЧ ТАЙЛАН:

Он	Нийт хөрөнгө	Цэвэр ашиг	Нийт хөрөнгө оруулалт /тэрбум төгрөгөөр/
2010	474.8	6.7	1.6
2011	833.8	12.9	2.0

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ТОО: 16

"Тэнгэр санхүүгийн нэгдэл" болон "Хас банк" нь 2010 онд Олон улсын санхүүгийн корпорациар компанийн засаглалын үнэлгээ хийлгэж, үнэлгээний үр дүн, зөвлөмжийн дагуу Компанийн засаглалаа сайжруулах 2010-2012 оны ажлын төлөвлөгөө гаргаж амжилттай хэрэгжүүлж байна. Үүний хүрээнд, ёс зүй, сонирхлын зөрчлийн журам, нэгдмэл сонирхолтой этгээдтэй хэлцэл хийх болон ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах журмыг баталсан. Түүнчлэн ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн үйл ажиллагаа, өөрсдийн оруулж буй хувь нэмрийг жил бүр үнэлж, компанийн зохистой удирдлага, засаглалыг улам боловсронгуй болгоход чиглэсэн арга хэмжээ аван ажилладаг.

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ: МАГВАНЫ БОЛД

Тэрбээр 2009 оны нэгдүгээр сараас "Хас" банкны гүйцэтгэх захирлаар ажиллаж байгаад өнгөрсөн оны нэгдүгээр сараас "Тэнгэр санхүүгийн нэгдэл"-ийн гүйцэтгэх захирлын албанд томилогдсон. Төрийн болон хувийн хэвшлийн санхүүгийн байгууллага болон Дэлхийн банк, Олон улсын валютын сан зэрэг олон улсын санхүүгийн байгууллагад 20 гаруй жил ажиллаж, банкны салбарын эдийн засгийн бодлого, бүтцийн шинэчлэлийн асуудлаар мэргэшсэн.

ТУЗ-ИЙН ГИШҮҮД:



Компанийн ТУЗ найман гишүүнтэй. Үүнээс тав нь Олон улсын санхүүгийн корпораци (IFC), Европын сэргээн босголт хөгжлийн банк (EBRD), АНУ-ын Мерси Корпс, Нидерландын "Триодос банк", Швейцарын "Бамбуу Финанс" зэрэг олон улсын байгууллага, банк хөрөнгө оруулалтын сангуудыг төлөөлсөн гишүүд. ТУЗ-ийн хараат бус нэг гишүүн Ч.Ганболд нь ТУЗ-ийн даргын ажлыг хавсран хийдэг.

үйлчлүүлэх гэх мэтээр давуу эрх олгох хэрэгтэй гэсэн сэтгэлгээ одоо ч байгаа. Энэ хэвээрээ байвал өөрсдийгөө л хорлож байна гэсэн үг. Тэгэхээр үүнээсээ салж чадвал үйл ажиллагаагаа тогтвортой явуулна. Дээр нь хувь нийлүүлэгчид болон ТУЗ банкны гүйцэтгэх удирдлагад тавих хяналт зүй зохистой байж чадахгүй байна. Яагаад гэвэл, зарим нь гүйцэтгэх удирдлагынхаа өдөр тутмын нарийн үйл ажиллагаанд оролцож, үйл ажиллагаанд нь саад болдог бол нэг хэсэг нь хяналт огт тавилгүй орхисон байх жишээтэй. Тэгэхээр үүнийгээ зохицуулж, алтан дунджийг барьж, ил тод, нээлттэй, тэнцвэртэй засаглалтай байх ёстой. Улс орны баян чинээлэг, ядуу буурай эсэхээс үл шалтгаалан засаглал сайтай компани нь хаана ч урт настай байж чаддаг.

-Банкны салбарынхан бизнесийн бусад байгууллагад сайн засаглалыг ойлгуулах, татан оролцуулахад хувь нэмрээ оруулах ямар боломж харагдаж байна вэ?

-Банкууд аливаа компани, иргэнд зээл өгөхдөө тухайн компанийн засаглал ямар түвшинд байгааг дүн шинжилгээ хийж чаддаг. Тухайлбал, компанийн удирдлага зах зээлээ судалж буй эсэх, хувь нийлүүлэгч болон ТУЗ, гүйцэтгэх удирдлагын эрх, үүрэг ямар байгаа болон бизнесийн үр ашгийг судалж үздэг. Тиймээс тухайн компаниудад банкны туршлагатай зээлийн эдийн засагч нар зөвлөгөө өгөх боломжтой юм. Уг нь үүнийг ашиглавал банк болон зээлдэгчийн ашиг орлого нэмэгдэж, урт хугацаандаа тогтвортой хамтран ажиллах боломж бүрдэнэ. Тиймээс энэхүү зөвлөгөө өгч нөлөөлөх үйл ажиллагааг шинэ шатанд аваачиж, системтэйгээр хийх хэрэгтэй. Түүнчлэн компаниуд тайлан балансаа олон янзаар гаргаж татвараа нуудаг. Гэвч энэ нь эргээд зээл авахад тушаа болж буйг санах хэрэгтэй.

-Компаниуд засаглалаа бэхжүүлэхийн тулд юунаас эхлэх хэрэгтэй гэж Та зөвлөх вэ?

-Сайн засаглалын мөн чанарыг ойлгож чадвал бизнесийн ашиг орлого нь нэмэгдэж, гаднын хөрөнгө оруулалт байнга орж ирэхийн зэрэгцээ хамтран ажиллах түншүүд ч нэмэгддэг. Дээр нь дутагдаад буй авьяаслаг, чадварлаг хүний нөөц соронзон мэт татагдаад өөрсдөө хүрээд ирдэг. Өөрөө хэлбэл, сайн засаглалтай компани итгэлт сайн анд нөхөртэй л адил гэсэн үг. Компаниудын эзэд, гүйцэтгэх захирлууд хамгийн түрүүнд засаглалын чиглэлийн сургалтад сууж мэдээлэлтэй болоод эхэлбэл, нэг мэдэхэд л засаглалын талаар илүү ихийг судалж, компанийнхаа үр ашгийг нэмэгдүүлэхээр ажиллаж эхлэх болно. ■



Эрхэмсэг Хатагтай, Ноёд оо

Та бүхэнтэй **WOW ВИДЕО ШУУДАН** мэндчилж байна.

ТА бизнесийн ашгаа нэмэгдүүлмээр байна уу?
өөрийн болон байгууллагынхаа зардлыг хэмнэмээр байна уу?
шинэ хэрэглэгч, үйлчлүүлэгчидтэй болмоор байна уу?
найз нөхөд, түншүүдийнхээ цар хүрээг өргөжүүлмээр байна уу?
ДЭЛХИЙН ШИЛДЭГ ТЕХНОЛОГИЙГ ӨДӨР ТУТАМ,
БАЙГУУЛЛАГЫНХАА МЕНЕЖМЕНТЭД АШИГЛАМААР БАЙНА УУ?

БИД ТАНД ТУСЛАЯ

- ✔ Таны бизнес болох бараа бүтээгдэхүүний худалдаа, үйлдвэрлэл, үйлчилгээний тань мэдээлэл рекламыг Монголын болон гадаадын зорилтот зах зээлд нь "MINI TV"-ээрээ БИЗНЕС СУРТАЛЧИЛГАА-гаар үйлчилнэ.
- ✔ Та шинэ түнш, бизнес хамтрагчтай танилцах, хамтран ажиллах бол таныг ОНЛАЙН НЭРИЙН ХУУДАС, ТАНИЛЦУУЛГА- аар холбоно.
- ✔ Та бусдад баяр хүргэх, урилга мэндчилгээ түгээх, сэтгэлийн үгээ илгээх, аливаа тэмдэглэлт арга хэмжээ, баярын мэдээг бусдад дуулгах бол бид АМЬД УРИЛГААР хүргэнэ.
- ✔ Таны цаг хугацаа, хөрөнгө санхүүг хэмнэн өдөр тутмын бизнес уулзалт, хурал чуулган, гэр бүл найз нөхөдтэйгээ чөлөөтэй харилцах ВИДЕО КОНФЕРЕНЦ-ОНЛАЙН ТАНХИМ-ыг танд санал болгож байна.


БИДНИЙ ДАВУУ ТАЛ

- ✔ Манай бүтээгдэхүүн АМЬД. Учир нь таны сурталчилгаа видео мэйлээр дуу, дүрс, төрөл бүрийн загвар дизайнаар хүрнэ.
- ✔ Үйлчилгээ ШУУРХАЙ. Таны захиалсан үйлчилгээнд төрөл бүрийн линк, вэбсайт, өөрийн хүссэн мэдээллийг холбох боломжтой.
- ✔ Үр дүн БАТАЛГААТАЙ. Манай үйлчилгээний хүртээмжтэй та бодитоор танилцах боломжтой.

Манай бүтээгдэхүүн үйлчилгээ



Бизнес сурталчилгаа



Онлайн уулзалт, хурлын заал



Видео урилга, нэрийн хуудас



Баярын видео мэндчилгээ

Хүмүүс сонссон зүйлийнхээ 10%-ийг тогтоодог, харсан зүйлийнхээ 50%-ийг санадаг,
харин видео мэдээлэл хүнд 85%-ийн хүртээмжтэй нөлөөлдгийг эрдэмтэн судлаачид тогтоожээ.